



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11

- Үнэт цаасны тухай Монгол Улсын хууль
- Ашигт малтмалын тухай Монгол Улсын хууль
- Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

1994 он

## «ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» БА «ТӨР, ЗАСГИЙН АЖИЛТАНД ТУСЛАМЖ» СЭТГҮҮЛИЙГ ЗАХИАЛААРЫН

1994 оноос эхлэн сар бүр тогтмол хэвлэгдэн гарч уншигч захиралагчиддаа цаг хугацаандаа саадгүй хүрч байгаа төрийн албан ёсны хэвлэл «Төрийн мэдээлэл» сэтгүүл нь 1995 оноос эхлэн «Төр, засгийн ажилтанд тусламж» нэртэй сар бүрийн хавсралттайгаар гарах болов.

**«Төрийн мэдээлэл» сэтгүүл:**

- Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжууд;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг захирамжууд;
- Засгийн газрын тогтоол шийдвэрүүд;
- Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт, тогтоолууд;
- Монгол Улсын Хуулийн талаарх Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбарууд бүрэн эхээрээ хэвлэгдэнэ.

«Төрийн мэдээлэл» сэтгүүлийн хавсралт **«Төр, засгийн ажилтанд тусламж»-д:**

— УИХ-аас батлан гаргаж буй хууль тогтоомжуудын хураангуй утга агуулга, зарим шинэлэг зүйлс, онол, практик чухал асуудал, тэдгээрийг хэрэгжүүлэх аргачлал, асуулт-хариутийн хэлбэрээр ойлгомжтой өгүүлдсэн аман зуулууд ашиглах зорилгоор бүхий ярианы сэдэв;

— Монгол Улсын иргэдээс төр, засагтаа хандаж хууль тогтоомж, төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн сурталчлалааг сайжруулах талаар ирүүлсэн ажил хэрэгч санал хүсэлт, санаа зориулалттай шүүмжлэл

— Аймаг, хотын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, засаг даргын тамгын газруудын үйл ажиллагааны дэвшилт арга хэлбэр, туршлага

— Гадаад орнуудын парламентын үйл ажиллагаатай холбогдсон сонирхолтой мэдээ, мэдээлэл зэргийг байнга нийтэлж байх болно.

Зөвхөн «Төрийн мэдээлэл» сэтгүүл, «Ардын эрх» сонинд нийтлэгдсэн хууль тогтоомжуудыг албан ёсоор ашиглаж

Болох үндсэн эх гэж үзэхийг хуулиар заасан байдгийг эрхэм уншигч Танд сануулахад илүүдэх юун. Төр, засгийн албан ёсны үнэн зөв мэдээллийг анхдагч эхээр нь авч алба ажилдаа ашиглаж гээвэл Та «Төрийн мэдээлэл» сэтгүүл, түүний хавсралт «Төр, засгийн ажилтанд тусламж»-ийг захиалаарай.

«Төрийн мэдээлэл» сэтгүүл, «Төр, засгийн ажилтанд тусламж» хавсралтын хамт нэг дугаарын үнэ нь 550 төгрөг. Удирлаар 1650, хагас жилээр 3300, бүтэн жилээр 6600 төгрөг болно.

Захналгыг аймаг, хотын холбооны салбаруудаар дамжуулан хийж, үнийг «Монгол шуудан» компанийн 200002 тоот дансанд шилжүүлнэ.

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨД



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШНЙДВЭР, НИЙТЛЭЛ—ХУУЛИЙН  
ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар

№

1994 оны 11 сар

№ 11 (30)

## ГАРЧИГ

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |   |      |
|---|------|
| 1. Үнэт цаасны тухай                    | 955  |
| 2. Ашигт малтмалын тухай                | 968  |
| 3. Зарлаг хүчингүй болсонд тооцох тухай | 1000 |

### II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |   |      |
|---|------|
| 4. Ажлын хэсэг байгуулах тухай № 69   | 1001 |
| 5. Байнгын хорооны дүгнэлтийн тухай № 70  | 1002 |
| 6. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн<br>эвишөөрөх тухай № 71   | 1003 |
| 7. Үнэт цаасны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим<br>арга хэмжээний тухай № 72   | 1003 |
| 8. Улс орны эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал,<br>дэмжлэн зориулалтын тухай Засгийн гэрэмцэнтэй<br>хэлэлцсэн дүнгийн тухай № 73 | 1004 |
| 9. Ерөнхийлөгчийн хоригийн тухай № 74   | 1009 |
| 10. Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим<br>арга хэмжээний тухай № 75  | 1010 |

### III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |   |      |
|---|------|
| 11. Н. Дэлгэрсүрэнг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн<br>одонгоор шагнах тухай № 85 | 1011 |
| 12. С. Сутармыг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 86                            | 1011 |
| 13. С. Баранясэнг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 87                          | 1012 |
| 14. С. Мөнхдалайг «Алтан гадас» одонгоор шагнах тухай № 88                          | 1013 |
| 15. Зарим хүмүүсийг одон, медалаар шагнах тухай № 89                                | 1013 |

- |   |      |
|---|------|
| 16. Ф. Бержаныг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнах тухай № 90                     | 1043 |
| 17. Зарим шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчийг залбан тушаалаас нь чөлөөлөх тухай № 93 |      |
| 18. Зарим шүүхийн шүүгчийг томлох тухай № 94                                      | 1016 |

#### IV. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

- |  |      |
|--|------|
| 19. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцгийн тогтоол № 02 | 1018 |
|--|------|

#### V. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |   |      |
|---|------|
| 20. Улсын тусгай хамгаалалттай зарим газрын хялгийн цэс, хамгаалалтын горимыг батлах тухай № 95                         | 1040 |
| 21. Радио, төлөвнээр нэвтрүүлэг явуулах байх тухай № 96   | 1040 |
| 22. Жагсаалтад нэмэлт оруулах тухай № 97  | 1041 |
| 23. Мэргэжлийн урлагийн зарим байгууллаагмын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай №98                      | 1041 |
| 24. Журамд өөрчлөлт оруулах тухай № 101   | 1042 |
| 25. Дүрэм батлах тухай № 102  | 1043 |
| 26. Улсын эрдсийн баяагийн зөвлөлийн дүрэмд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай № 103 | 1047 |
| 27. "Ядууралыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 104                            | 1050 |
| 28. Дундаж хэлс тодорхойлох журамд нэмэлт оруулах тухай № 105   | 1052 |

#### VI. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

- |   |      |
|---|------|
| 29. Дээд шүүхийн бүгд хурлын зарим тогтоолд өөрчлөлт оруулах тухай № 125  | 1053 |
| 30. Эрүүгийн хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэх журмын тухай № 126 | 1055 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 9 дүгээр  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
 хот

### ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн ашиглах зорилгоор энэ хуульд заасан үнэт цаас гаргах, худалдах, арилжих, хадгалах, түүний төлбөр, тооцоог хийх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч бусад этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Үнэт цаасны тухай хууль тогтоомж

Үнэт цаасны тухай хууль тогтоомж нь энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд:

1) «үнэт цаас» гэж хувьцаат компанид хөрөнгө оруулж, ногдол ашиг авах болон саналын эрхтэйг гэрчилсэн хувьцаа, эрх бүхий байгууллагаас гаргасан 1-ээс дээш жилийн хугацаатай зээллэгээ, Засгийн газрын өрийн бичиг, түүнчлэн Үнэт цаасны хороо (цаашид «Хороо» гэх)-ноос энэ хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;

2) «биет үнэт цаас» гэж тогтоосон журмын дагуу биет байдлаар хэвлэсэн үнэт цаасыг, «биет бус үнэт цаас» гэж тусгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тооцоолох машины санах байгууламжид байгаа үнэт цаасыг;

3) «үнэт цаас гаргагч» гэж үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, гадархай төсөл хэрэгжүүлэх болон санхүүгийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд шаардагдах хуримтлалыг бий болгох зорилгоор үнэт цаас гаргасан болон гаргаж байгаа хуулийн этгээдийг;

4) «үнэт цаасны зах зээл» гэж үнэт цаас гаргагчаас

шууд, эсхүл андеррайтераар дамжуулан үнэт цаасаа худалдах анхдагч зах зээл болон гүйлгээнд гарсан үнэт цаасыг дахин худалдах, арилжих хоёрдогч зах зээлийг;

5) «андеррайтер» гэж үнэт цаас гаргагчаас шинээр гаргаж байгаа үнэт цаасыг бүгдийг буюу түүний тодорхой хэсгийг худалдан авч, ашиг олох зорилгоор бусдад худалдах, эсхүл үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс үнэт цаасыг нь бусдад худалдах, арилжих үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг;

6) «дилер» гэж үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авч ашиг олох зорилгоор бусдад худалдах, арилжих үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг;

7) «брокер» гэж үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр үнэт цаасыг зуучлан худалдах, арилжих үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийг;

8) «нийтэд санал болгох» гэж үнэт цаас гаргагчаас үнэт цаасыг нь худалдан авахыг 20 болон түүнээс дээш тооны этгээдэд хандан тогтоосон журмын дагуу санал болгож таниулахыг;

9) «тендер санал гаргах» гэж аль нэг компанийн тодорхой хувьцааны тогтоосон хувийг худалдан авах саналаа зохих журмын дагуу нийтэд зарлахыг;

10) «дотоод мэдээлэл» гэж нийтэд тараагдаагүй бөгөөд үнэт цаасны зах зээлийн ханшинд нөлөөлж болох мэдээллийг

11) «дотоод мэдээллийг эзэмшигч» гэж үнэт цаасаа гаргаж байгаа компанийн удирдлага болон тухайн компанийн гаргасан үнэт цаасны 10-аас доошгүй хувийг (баги) эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, түүнчлэн дотоод мэдээллийг мэдэж байгаа бусад этгээдийг;

12) «хөрөнгийн бирж» гэж үнэт цаасны худалдаа, арилжаа, түүнтэй холбоотой үйлчилгээ явуулах зорилго бүхий ашгийн төлөө бус компанийг;

13) «үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа» гэж үнэт цаасны худалдаа, арилжааны төлбөр тооцоог хийх, үнэт цаас өмчлөх эрх бусдад шилжсэнийг дансны бичиглэлийн хэлбэрээр бүртгэх ашгийн төлөө бус үйлчилгээ эрхлэхийг;

14) «үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа» гэж үнэт цаасыг биет болон биет бус хэлбэрээр хадгалах ашгийн төлөө бус үйлчилгээ эрхлэхийг;

15) «хөрөнгө оруулалтын сан» гэж өөрийн үнэт цаасыг нийтэд гаргах замаар хөрөнгө оруулагчдын хөрөнгийг төвлө-

рүү-гк, үнэт цаас худалдан авах, худалдах үйл ажиллагаа дагнан эрхэлдэг компанийг тус тус хэлнэ.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ .

### Үнэт цаас гаргах, худалдах, арилжих

**4 дүгээр зүйл.** Үнэт цаас гаргах этгээд

Дараахь этгээд үнэт цаас гаргаж болно:

- 1) Засгийн газар, түүнчлэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Засаг дарга;
- 2) Монгол Улсын хуулийн этгээд болох компани.

**5 дугаар зүйл.** Үнэт цаасны бүрдүүлбэр

Үнэт цаас нь дараахь бүрдүүлбэртэй байна:

- 1) үнэт цаасны нэр, төрөл;
- 2) үнэт цаас гаргагчийн нэр;
- 3) үнэт цаасны нэрлэсэн үнэ;
- 4) үнэт цаасар хуримтлуулсан мөнгийг зарцуулах зориулалт;
- 5) үнэт цаасар олох ашиг, хүү авах нөхцөл;
- 6) төлбөр хийх болзол зэрэг бусад нөхцөл.

**6 дугаар зүйл.** Компани үнэт цаас гаргаж нийтэд санал болгон худалдах

1. Компани нь үнэт цаасыг нийтэд, эсхүл нийтэд санал болгохгүйгээр цөөн тооны этгээдэд худалдахаар гаргана.

2. Үнэт цаасыг нийтэд санал болгож худалдахаар гаргахдаа Хорооноос зөвшөөрөл авна. Нийтэд санал болгохгүй үнэт цаас гаргахад энэ журам хамаарахгүй.

3. Үнэт цаас гаргагч зөвшөөрөл авахдаа өргөдөл, тогтоосон журамд заасан бусад баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

4. Үнэт цаасыг гаргаж нийтэд санал болгох тухай өргөдөл дараахь дүйлээс бүрдэнэ:

1) үнэт цаас гаргагч болон андеррайтерийн оноосон нэр, хаяг, орших газар, тэдгээрийн эрх барих байгууллагын гишүүдийн нэрсийн жагсаалт улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2) нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл, өмч (алдагдал)-ийн тайлан (нөгөөс дээш жил ажилласан бол);



3) гаргах үнэт цаасны нэр, төрөл, тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, гаргах хугацаа, загвар;

4) үнэт цаас гаргагчийн хөрөнгийн хэмжээ, санхүүгийн чадавхийн талаарх баримт, бусадтай байгуулсан томоохон гэрээ, хэлцлүүд, үнэт цаас гаргах эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо.

5. Хороонд ирүүлэх өргөдөл, баримт бичиг нь тухайн компанийн эрх барих байгууллагаар батламжлагдсан байна.

6. Хороо өргөдөл баримт бичгийг бүрэн хүлээж авсан өдөрөөс хойш 30 хоногийн дотор үнэт цаас гаргаж нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан шийдвэрийн аль нэгийг гаргана.

7. Үнэт цаас гаргагч нийтэд санал болгосон үнэт цаасаа анхдагч зах зээлд шууд худалдах буюу эсхүл андеррайтерт худалдаж болно.

8. Үнэт цаас гаргагч үнэт цаасны зуучлагчид өөрөө олох үүрэгтэй.

9. Үнэт цаас худалдан авагч нь өөрийн хөрөнгөөр, эсхүл банкинаас авсан зээлийн хөрөнгөөр уг үнэт цаасыг худалдан авна. Банкны зээлээр үнэт цаас худалдан авах журмыг Хороо тогтооно.

10. Үнэт цаасыг зээлээр худалдахыг хориглоно.

11. Үнэт цаас гаргагч нэгэнт худалдсан үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээхгүй.

12. Үнэт цаас гаргагч үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг түүний зориулалтаар захиран зарцуулна.

13. Үнэт цаас гаргагчаас Хороонд ирүүлсэн өргөдөл, баримт бичгийн үнэн зөвийг тэдгээрийг гаргасан, бэлтгэсэн мэргэжлийн хүмүүс хариуцна.

14. Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 1, 2-т заасан зөрчлөөс учирсан хохирлыг тухайн үнэт цаас гаргах өргөдөлд болон бусад холбогдох баримтад гарын үсгээ зурсан этгээд гэрээнд заасны дагуу хариуцна.

**7 дугаар зүйл. Засгийн газар; аймаг, нийслэлийн**

Засаг дарга үнэт цаас гаргаж нийтэд санал болгон худалдах

1. Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрлөөр; аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэсэн Сангийн сайдын баталгаатайгаар тус тус үнэт цаас гаргаж нийтэд санал болгон худалдаж болно.

2. Зэстийн газар; аймэг, нийслэлийн Засаг дарга үнэт цаас гаргаж нийтэд санал болгон худалдаадаг энэ зуулийн 6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4 дэх хэстийн 1, 2 дахь заалт, 5, 6, 13, 14 дэх хэсэгт зааснаас бусад заалтыг баримтална.

8 дугаар зүйл. Тендер санал

1. Тендер саналыг энэ хууль болон түүнд нийцүүлэн Хорооноос тогтоосон журмын дагуу гаргана.

2. Тендер санал гаргахыг хүссэн этгээд энэ тухайгаа тогтоосон хугацаанд Хороонд мэдэгдэнэ. Хороо уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд шийдвэр гаргах хүртэл хугацаанд тухайн компанитай холбогдсон өөр тендер санал хүлээн авахгүй.

3. Тендер саналыг нийтэд зарлах, сурталчлах, тендер саналыг өөрчлөхдөө Хорооноос тогтоосон журмыг баримтална.

4. Тендер санал нь түүнийг гаргахыг Хороо зөвшөөрснөөс хойш 45 хоногос доошгүй хугацаанд хүчинтэй байна.

5. Тендер саналын дагуу үнэт цаасаа худалдахыг зөвшөөрсөн этгээд тендер санал хүчинтэй байх хугацаанд саналла буцааж авах эрхтэй.

6. Тендер санал гаргах үед уг саналтай холбогдсон үйл ажиллагааг зохшуулах журмыг Хороо тогтооно.

7. Тендер санал гаргасан үед үнэт цаас худалдах үнийг тендер зарлагчийн тухайн үнэт цаасыг сүүлийн 12 сард худалдаж авсан хамгийн дээд үнэ болон уг саналыг зарлахаас өмнөх 30 хоногийн худалдаа, арилжааны дундаж үнэ хоёрын аль өндөрөөр нь тогтооно.

8. Үнэт цаас гаргагч тендер саналтай холбогдсон мэдээллийг сонирхогч бүх этгээдэд нэг адил хүргэх үүрэгтэй. Тодорхой шалтгаанаар нэг буюу хэсэг санал гаргагчдад тусгайлан өгсөн мэдээллийг бусад санал гаргагчдад нэгэн адил хүргэнэ.

9 дүгээр зүйл. Үнэт цаас өмчлөгчийн үүрэг

1. Аль нэг компанийн гаргасан нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг шууд болон шууд бусаар өмчилсөн этгээд нийзүү өмчлөх эрх үүссэн өдрөөс хойш 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй.

2. Аль нэг компанийн гаргасан нийт хувьцааны 20-иос илүү хувийг шууд болон шууд бусаар өмчлөхийг хүссэн этгээд

гээд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмын дагуу тендер санал гаргах үүрэгтэй.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ

#### Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд, тэдгээрийн бүрэн эрх

**10 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд.

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд нь андеррайтер, брокер, дилер, хөрөнгийн бирж, түүнчлэн үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн үйл ажиллагааг эрхэлж байгаа байгууллага, хөрөнгө оруулалтын сан байна.

**11 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд зөвшөөрөл олгох

1. Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан этгээдэд үнэт цаасны зах зээлд оролцож үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тогтоосон журмын дагуу Хороо олгоно.

2. Хөрөнгийн биржийн болон үнэт цаасны төлбөр тооцооны, мөн хадгаламжийн үйл ажиллагааг нэг байгууллага хавсран эрхэлж буюу хэд хэдэн байгууллага дагнан гүйцэтгэж болно.

3. Хөрөнгийн биржийн болон үнэт цаасны төлбөр тооцооны, мөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх, түүнчлэн брокер, дилер, андеррайтераар ажиллахыг хүссэн этгээд энэ тухай хүсэлтээ Хороонд бичгээр гаргана. Хороо хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.

**12 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд болон үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээд болон үнэт цаас гаргагч дараахь нийтлэг үүрэгтэй байна:

1) үнэт цаасны гүйцлээний талаарх мэдээ тайланг холбогдох аргачлал маягтын дагуу хийж, тогтоосон хугацаанд Хороонд өгч байх;

2) санхүү, аж ахуйн үйл ажиллагааны хагас жилийн тайлан тэнцлийн болон нягтлан бодох бүртгэлийн хөндлөнгийн байгууллагаар хяналт шалгалт хийлгэсэн жилийн тайлан тэнцлийн хураангуйг тус тус хэвлэн нийтэлж байх;

3) үнэт цаастай холбогдсон үнэн зөв мэдээллийг сонирлогч этгээдэд шуурхай хүргэх;

4) үнэт цаасны гүйцлээг үнэнч шударга, ил тод хийх.

**13 дугаар зүйл.** Хөрөнгийн биржид тааигдах шаардлага

1. Хөрөнгийн биржийн дүрмийн саяг зөвхөн Хорооноос үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон брокер, дилер, андеррайтер болон Засгийн газар бүрдүүлнэ.

2. Биржийн эрх барих байгууллага болох төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 50-иас доошгүй хувь нь үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагч байна.

3. Хөрөнгийн бирж нь үнэт цаасны худалдааг зохион байгуулахдаа дараахь шаардлагыг баримтална:

1) үнэт цаасыг худалдахад хамгийн бага үнээс, худалдан авахад хамгийн өндөр үнээс эхлэх;

2) үнэт цаасыг худалдах, худалдан авахад саналын үнэ тэнцсэн тохиолдолд захиалгын дарааллыг чанд баримтлах.

**14 дүгээр зүйл.** Хөрөнгийн биржийн эрх, үүрэг

Хөрөнгийн бирж энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

1) Хорооноос хориглоогүй үнэт цаасыг худалдах, арилжих;

2) Хорооны зөвшөөрлөөр, эрх хэмжээнийхээ дотор журам гаргах;

3) өөрийн бирж дээр худалдаа, арилжаа явуулах зөвшөөрлийг брокер, дилерт олгох.

**15 дугаар зүйл.** Үнэт цаасны төлбөр тооцооны үйл

ажиллагаа эрхлэгч этгээдийн

эрх, үүрэг

Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэгч этгээд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

1) Хорооны зөвшөөрлөөр, эрх хэмжээнийхээ дотор журам гаргах;

2) үнэт цаасны төлбөр тооцоо хийх гэрээг харилцагч тус бүртэй байгуулах;

3) зөвхөн хөрөнгийн бирж дээр хийгдсэн үнэт цаасны гүйлгээний төлбөр, тооцоог хийх;

4) үнэт цаас өмчлөх эрх шилжээнийг тооцох.

**16 дугаар зүйл.** Үнэт цаасны хадгаламжийн үйл

ажиллагаа эрхлэгч этгээдийн

эрх, үүрэг

Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс

гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

1) үнэт цаас өмчлөгчийг боловч өмчлөх эрх нийлжсэнийг бүртгэх;

2) хадгалагдаж байгаа үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хариуцах.

**17 дугаар зүйл.** Хөрөнгө оруулалтын сан

1. Хөрөнгө оруулалтын сан нь нээлттэй, хаалттай гэсэн хэлбэртэй байна:

1) хөрөнгө оруулалтын нээлттэй сан гэж үнэт цаасаа бусдад худалдахар байнга санал болгож, хэрэгцээний хэмжээгээр гаргадаг болон үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг бүхий компанийг хэлнэ;

2) хөрөнгө оруулалтын хаалттай сан гэж хувь нийлүүлэгчдийн тогтоосон тоо хэмжээнд үнэт цаас гаргаж худалдааг компанийг хэлнэ.

2. Хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд дараахь зүйлийг заана:

1) нээлттэй сангийн үйл ажиллагаанаас олох нэвэр орлогыг тодорхойлох, хувьцаа өмчлөгч хувьцаагаа санд буцааж худалдахад түүнд төлөх төлбөрийн хэмжээг тогтоох журам; болон мэдээлэл, тайлан гаргахад тавих шаардлага;

2) нийгдэн бодох бүртгэл, санхүүгийн хяналт шааргалт

3) Хорооноос хориглоогүй үнэт цаасыг худалдах, арилжих журам.

3. Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа өмчлөгчдийн хурлыг нийт хувьцаа өмчлөгчдийн 25 хувиас доошгүй нь оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

**18 дугаар зүйл.** Андеррайтерийн үүрэг

Андеррайтер энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна үнэт цаас гаргаж нийтэд санал болгох тухай өргөдөлд тусгагдсан болон түүнд хавсрагдсан баримт мэдээллийн үнэн зөвийг хянах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага**

**19 дүгээр зүйл.** Хороо, түүнийг байгуулах

1. Хороо нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд орол-

ногчдын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх бүхий байгууллага мөн.

2. Хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хорооны даргад Ерөнхий сайд, гишүүдэд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр 1 хүнийг, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо үлдэх 2 хүнийг тус тус санал болгож, Улсын Их Хурлаас томилно. Байнгын хорооны санал болгох 2 гишүүн нь энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасан компаниудын ашиг сонирхлыг төлөөлсөн байна.

3. Хорооны дарга орон тооны, гишүүд орон тооны бус байна.

4. Төрийн албаны тухай хуульд заасан далах, чөлөөлөх, огцруулах үндэслэл байвал Хорооны дарга, гишүүдийг анх санал болгосон байгууллага, албан тушаалтан уг асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүнэ.

5. Хорооны дүрмийг Улсын Их Хурал батална.

6. Хороо ажлын албатай байх бөгөөд улсын төснөөс санхүүжинэ.

7. Хорооны дүрэмд заасан журмаар орон тооны бус гишүүдэд урамшил олгож болно.

**20 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх**

Хороо нь дарваахь бүрэн эрхтэй байна:

1) үнэт цаасны зах зээлийн харилцааг зохицуулахтай холбоотой дор дурдсан асуудлаар эрх хэмжээнвйхээ дотор зохих журам гаргах:

а) нийтэд санал болгож гаргах үнэт цаасны талаар Хороонд ирүүлэх баримт бичгийн тухай;

б) тендер санал гаргах, түүнтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулах тухай;

в) хөрөнгийн биржийн, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллага байгуулах, тэдгээрт болон брокер, дилер, андеррайтерт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, түүнийг цуцлах тухай;

г) үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцогч этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх тухай;

д) хуульд заасан бусад асуудал.

2) үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн бүх үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл зөвлөх;

3) үнэт цаасны холбогдолтой нягтлан бодох бүртгэлийн тайлан мэдээний болон бусад маягтыг баталж мөрдүүлэх;

4) зохих шаардлагыг хангасан брокер, дилер, андеррайтер, хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагад үнэт цаасны холбогдолтой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;

5) үнэт цаасны тухай хууль тогтоомж болон өөрийн шийдвэрийн биелэлтийг хянан шалгаж, эрх хэмжээнийхээ дагуу зохих арга хэмжээ авах;

6) хөрөнгө оруулагчдын эрх ангийг хамаалах үүднээс зөрчилтэй гэж үл үндэстэйгээр сэжиглэгдсэн үнэт цаасны худалдааг түр зогсоож, шалгуулах, зөрчилтэй нь нотлогдвол түүнийг хориглох, жагсаалтаас хасгах, тодорхой хугацаагаар төлбөр тооцоог нь зогсоох;

7) брокер, дилер, андеррайтер, хөрөнгийн биржээс тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санаал болгох, энэ санааг хүлээж аваагүй тохиолдолд хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох буюу зохих этгээдэд олгосон зөвшөөрлөө цуцлах, энэ тухайгаар нийтэд зарлах;

8) үнэт цаасны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санаал, томдлын дагуу зохих арга хэмжээ авах;

9) үнэт цаас гаргагчийн тайлан тэнцэл, санхүүгийн бусад баримтыг Хорооноос тодорхойлсон нягтлан бодох бүртгэл, хяналтын итгэмжлэгдсэн байгууллагаар шалгуулан баталгаажуулахыг шаардах;

10) хөрөнгийн бирж, үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын захирлыг сонгох (томилгох), чөлөөлөхөд хувь нийтүүлэгчидтэй зөвшилцөх, шаардлагатай гэж үзвэл түүнийг өөрчлөх тухай асуудлыг хувь нийтүүлэгчдэд тавих;

11) хууль бус үйл ажиллагааны улмаас төрийн өмчид учирсан хохирлыг нөлөн төлүүлэх тухай, түүнчлэн эрхийн чадамжгүй этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор түүний нэрийн өмнөөс шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах.

## ТАВДУГААР БҮЛЭГ

**Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага**

**21 дүгээр зүйл.** Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлийн оролцогч этгээдэд хориглох үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) үнэт цаасны шууд буюу шууд бус худалдаа хийх, үнэт цаасыг гаргаж нийтэд худалдахаар санал болгох явцад холбогдох этгээдийг болон олон нийтийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх;

2) үнэт цаасны ханшинд нөлөөлж болох дотоод мэдээллээс бусад мэдээллийг орхигдуулах, нуун дарагдуулах, холбогдох этгээдэд өгөхөөс татгалзах;

3) брокер, дилер, андеррайтер, арилжаа хөтлөгчөөс үнэт цаасны ханшийг тодорхой түвшинд зохиомлоор тогтоон барих, өсгөх, бууруулах оролдлоготой гүйлгээ хийх;

4) хуурамч гүйлгээ хийх;

5) давхар буюу нууц гүйлгээ хийх.

**22 дугаар зүйл.** Үнэт цаасны тухай дотоод мэдээллийн нууцыг халгаалах

1. Гаргахаар буюу худалдаа, арилжаа хийлээр бэлтгэж байгаа үнэт цаасны тухай дотоод мэдээлэл эзэмшигчийг түүгээр хийх худалдаа арилжаанд ямар нэг хэлбэрээр оролцохыг хориглоно.

2. Дотоод мэдээлэл эзэмшигч нь уул мэдээллийг бусдад дамжуулахыг хориглоно.

3. Хорооны дарга, гинүүн болон энэ хуулийн дагуу Хорооноос мэдээлэл авсан этгээд уг мэдээллийг хувьдаа ашиглаж буюу Хорооны ажлын шаардлагатайгаас бусад тохиолдолд задруулж болохгүй.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

**Үнэт цаасны гүйлгээнд хийх хяналт шалгалт**

**23 дугаар зүйл.** Үнэт цаасны гүйлгээнд хяналт шалгалт хийх эрх бүхий этгээд

1. Үнэт цаасны Хороо, Засгийн газар өөрсдийн бүрэн эрхийн дагуу үнэт цаасны гүйлгээнд хяналт шалгалт хийнэ.



2. Энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг ямар нэг этгээд зөрчилөөр завдаж байгааг Хороо баримтаар нотлон тогтоосон нөхцөлд тухайн этгээдийн үнэт цаасны төлбөр доошоог гурь буюу бүрмөсөн зогсоох; түүнчлэн зөрчлийг тогтоосон нөхцөлд банкнд харилцах дансаар хийгдэх гүйлгээг зогсоох асуудлаар шүүхэд хандах эрхтэй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зарсан асуудлаар гаргасан Хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзсэн этгээд энэ талаарх гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

4. Хорооны шийдвэр хууль тогтоомжид харингаж байвал Засгийн газар уг шийдвэрийг түдгэлзүүлж, түүнийг хүчингүй болгуулах савалыг Хороонд мэдэгдэх бөгөөд Хороо үл эвчлөөрөө шүүхэд хандах эрхтэй.

**24 дүгээр зүйл. Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх**

1. Хорооны дарга, гишүүд болон Хорооноос эрх олгогдсон түүний ажилтан үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчийн эрх эдэлнэ.

2. Улсын байцаагч дараахь хүрээнд хяналт шалгалт хийнэ:

1) гүйлгээг үнэт цаасны зах зээл дээр эрх авсан этгээд хийж байгаа эсэх;

2) үнэт цаасны гүйлгээнд хууль, эрх зүйн холбогдох бусад актаар тогтоосон журмыг баримталж байгаа эсэх;

3) үнэт цаасны зах зээл дээр хийж байгаа гүйлгээ үзэн шударга, ил тод хийгдэж байгаа эсэх;

4) үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зориулалтаар нь захиран зарцуулж байгаа эсэх;

5) харилцагчдын эрх, зинг сонирхлыг хохироосон гүйлгээ хийсэн эсэх;

6) үнэт цаасны гүйлгээний бүртгэл, тайлан мэдээ үзэн эвч эсэх;

3. Улсын байцаагч нь хяналтын үүргээ биедүүлдээ дараахь эрх эдэлнэ:

1) үнэт цаасны гүйлгээнд холбогдолтой баримт сэлтийг үзэх, холбогдох албан тушаалтны, иргэнийг мэдээ, тайлбар шаардлагатай баримтыг гаргуулан авах;

2) хяналт шалгалтын дүнгээр акт тогтоож, түүний гүйцэтгэлийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг өгч шаардлага тавих;

3) энэ хэсгийн 2-т заасан шаардлагыг биелүүлээгүй буюу үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд энэ хууль болон бусад хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэж, үйл ажиллагааг нь хязгаарлах, зогсоох, олгосон зөвшөөрлийг нэг жил хүртэл хугацаагаар хүчингүй болгох, эсхүл бүр цуцлах.

4. Улсын байцаагч хяналт шалгалтыг өөрийн санаачилгаар Сүюү мэдээллийн дагуу хийж болно.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**25 дугаар зүйл.** Үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчсөнд хүлээлтгэх захиргааны хариуцлага

Үнэт цаасны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлтгэхээргүй байвал дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1) үнэт цаас гаргаж нийтэд санал болгон худалдах, арилжих, түүний төлбөр тооцоог хийх, хадгалж явцад энэ хуулийн 6 дугаар зүйлийн 5, 9, 10, 12; 8 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг; 9, 12, 13 дугаар зүйл 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт; 15 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх заалт, 16, 18 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй буюу 21 дүгээр зүйлийн заалтыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, 10000—25000 төгрөгөөр торгох;

2) энэ хуулийн 22 дугаар зүйлийн заалтыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, 15000—25000 төгрөгөөр торгох;

3) энэ хуулийн 6 дугаар зүйлийн 2, 7 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрлийг авалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, 15000—25000 төгрөгөөр торгох.

**26 дугаар зүйл.** Маргаан шийдвэрлэх

Үнэт цаасны гүйлгээний талаарх маргааныг шүүх шийдвэрлэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 9 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмалын орд ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хууль тогтоомж

1. Ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын хэвлийн тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1) «ашигт малтмалын орд» гэж геологийн хувьсал өөрчлөлтийн үр дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтсон, чанар, нөөц нь тодорхойлогдсон эрдэс бодисын хуримтлалыг хэлнэ;

2) «үйлдвэрлэлийн ач холбогдолтой орд» гэж тодорхой төрлийн ашигт малтмалыг аж үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн үр ашигтай болох нь техник-эдийн засгийн үндэслэлээр тодорхойлогдсон ордыг хэлнэ;

3) «ашигт малтмалын ордыг ашиглах» гэж уурхайн эдэлбэрийн хүрээнд ашигт малтмал олборлох, буталж тээрэмдэх, баяжуулах үндсэн ба туслах үйл ажиллагааг хэлнэ;

4) «таваарын бүтээгдэхүүн гаргах» гэж уурхайн үйлдвэр дараалсан 15 хоногос доошгүй хугацаанд үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийнхээ хүч чадлын 60-аас доошгүй хувийг эзэмших цаашид тогтвортой ажиллах нь тогтоогдсоныг хэлнэ;

5) «уурхайн эдэлбэр» гэж ашигт малтмалын орд ашиглахад зориулж тусгай зөвшөөрлийн дагуу олгосон талбай, түүний хэвлийн хэсгийг хэлнэ;

6) «эдэлбэр газар» гэж уурхайн үйлдвэрт олгосон бөгөөд уурхайн эдэлбэрээс бусад газрыг хэлнэ;

7) «урьдчилсан гэрээ» (меморандум) гэж ашигт малтмалын хайгуул хийх, ордыг түрээслэн ашиглах талаар харилцан хүлээх үүрэг, түүнийг гүйцэтгэх хугацаа болон бусад үндсэн болзлыг тусгаж тусгай зөвшөөрөл олгох байгууллагын санал болгосон гэрээний төслийг талууд хэлэлцэж бичгээр тохиролцсоныг хэлнэ;

4 дүгээр зүйл. Ашигт малтмал, түүний ангилал

1. Газрын гадарга, түүний хэвлийн байгалийн байдлаар оршиж байгаа хатуу, хий, шингэн төлөвтэй эрдэс бодисыг ашигт малтмал гэнэ.

2. Ашигт малтмалыг эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан түүний хайх, олборлох эрх зүйн дэглэмийг ялгамжтай тогтоох зорилгоор:

- 1) стратегийн ашигт малтмал;
- 2) тусгай ашигт малтмал;
- 3) ердийн ашигт малтмал гэж ангилна.

3. Стратегийн ашигт малтмалд алтын хүдэр, мөнгөний хүдэр, цагаан алт, түүний бүлгийн метала (валладий, придий, родий, рутений, осмий)ын хүдэр, бадмазраг, доржпалам, маргад эрдэнэ, индранил, ураны хүдэр, газрын тос, чулуун нүүрс хамаарна.

4. Тусгай ашигт малтмал энэ зүйлийн 3, 5 дахь хэсэгт нэрлэж зааснаас бусад ашигт малтмалын хүдэр, металлын бус ашигт малтмал хамаарна.

5. Ердийн ашигт малтмалд жас, хайрга, элсэн чулуу, кварцит, шавар, аргиллит, алевролит, цэрд, шохойн чулуу, доломит, мергель, маагмин чулуулаг, галт уулын чулуулаг, хувирмал чулуу, занар хамаарна.

6. Ашигт малтмалыг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

7. Газрын тос, байгалийн хий, усны хайгуул хийх, тэдгээрийн ордыг ашиглахтай холбогдсон харилцааг тухайн хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд тийм хуульгүй бол энэ хуулийг баримтална.

**5 дугаар зүйл.** Орд болон ашигт малтмалыг өмчлөх

1. Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал, түүний орд нь төрийн өмч мөн.

2. Төр ашигт малтмалын ордыг өмчлөгчийн хувьд түүнийг тусгай зөвшөөрөл, төлбөр, хугацаатайгаар хуульд заасан бусад болзол, журмын дагуу хуулийн этгээд, хувь хүнд эзэмшүүлэн ашиглуулж хяналт тавих онцгой эрхтэй бөгөөд энэ онцгой эрхэд тусгайлан олгосон эрх бүхий байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

3. Ордыг хууль, гэрээний дагуу ашиглаж олборлосон ашигт малтмал нь улс орон нутгийн орлогод оруулах түрээсийн болон бусад төлбөр, албан татвар, хураамжийг төлж дууссаны дараа, хэрэв хуульд тусгайлан зааснаар уг ашигт малтмалыг буюу түүний тодорхой хэсгийг улсад заавал худалдах захиалгатай бол уул захиалгыг биелүүлж дууссаны дараа түрээслэгчийн өмч болно.

4. Төр нь өөрийн эрдэнэсийн санг арвижуулах улсын бусад хэрэгцээг хангах зорилгоор орд ашиглагч этгээдийн олборлосон стратегийн болон шаардлагатай бусад ашигт малтмалаас хууль, гэрээнд заасан хэмжээний дотор дэлхийн зах зээлийн ханшийг харгалзан тохиролцсон үнээр тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй.

5. Төрийн өмчийн үйлдвэрийн газрын олборлосон ашигт малтмалыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааг хууль, болон эрх бүхий байгууллагаас баталсан түүний дүрмийн дагуу зохицуулна.

6. Өмчийн олон хэлбэрийн оролцоотой аж ахуйн нэгжийн олборлосон ашигт малтмалыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааг тухайн өмчийн оролцооны хувь хэмжээгээр энэ зүйлийн 3, 4, 5 дахь хэсэгт заасан журмаар зохицуулна.

**6 дугаар зүйл.** Ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах үйл ажиллагааг төрөөс зохицуулах

1. Улсын Их Хурал дараахь бүрэн эрхтэй:

1) ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах талаархи төрийн бодлогыг тодорхойлох;

2) газрын хэвлийн нөхөн сэргээгдэхгүй баялгийг хойч үеийнхэндээ өвлүүлэх ашиг сонирхлыг бүрэн харгалзаж ариг гамтай зөн зохистой ашиглах зарчимд нийцүүлэн улсын хэмжээгээр жил тутам олборлох стратегийн ашигт малтмалын дээд хэмжээ, түүнчлэн улсад худалдан авах стратегийн ашигт малтмалын доод хэмжээг тус тус тогтоох; Энэ заалтыг хэрэглэхдээ орд түрээслэгч тодорхой этгээдийн нэгэнт байгуулсан гэрээ болон техник эдийн засгийн үндэслэлд заасан ашигт малтмал олборлох хэмжээг нь бууруулж болохгүй.

3) улсын тусгай хамгаалалттай газрын хилийн дотор ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэх;

4) Засгийн газрын өргөн мэдүүлснээр гадаадын хуулийн этгээдэд стратегийн ашигт малтмалын орд ашиглах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

5) Засгийн газрын өргөн мэдүүлснээр тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлохыг хязгаарлах, хориглох;

6) Газрын хэвлийн тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

## 2. Засгийн газар дараахь бүрэн эрхтэй.

1) ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

2) стратегийн ашигт малтмалын хайгуулын болон орд ашиглах урьдчилсан гэрээг батлах;

3) улсын тусгай хэрэгцээний газрын хилийн дотор ашигт малтмалын орд ашиглах эсэх асуудлыг шийдвэрлэх;

4) ашигт малтмалын хайгуул хийх, ордыг ашиглахтай холбогдуулан аймаг, нийслэлийн засаг захиргааны байгууллагын шийдвэрийн талаарх шүүхээр шийдвэрлэгдэхээс бусад маргааныг хянан шийдвэрлэх;

5) Газрын хэвлийн тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

3. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид энэ хуульд «төрийн захиргааны төв байгууллага» гэх):

1) ашигт малтмалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2) хуульд өөрөөр заагаагүй бол ашигт малтмалын хайгуул хийх, стратегийн болон тусгай ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох;

3) ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах үйл ажиллагаанд геологч, уул техникийн улсын хяналт тавих, хэмжих болон бусад шалгалт хийх;

4) ашигт малтмалын ордын нөөцийн улсын бүртгэл хөтлөх;

5) Газрын хэвлийн тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

4. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

1) нутаг дэвсгэртээ ашигт малтмалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнчлэн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2) аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээний газрын хилийн дотор ердийн ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл олгох;

3) аймаг, нийслэлийн тусгай хэрэгцээний газрын хилийн дотор ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах зорнулалтаар эдэлбэр газар олгох;

4) нутаг дэвсгэртээ бүх төрлийн ашигт малтмалын хайгуул, орд ашиглалтын байдал, үр дүнгийн мэдээ, мэдээлэлтэй танилцах;

5) Газрын хэвлийн тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

5. Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй:

1) нутаг дэвсгэртээ ашигт малтмалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнчлэн хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон дээд шатныхаа Засаг даргын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2) хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нутаг дэвсгэртээ ердийн ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл олох;

3) нутаг дэвсгэртээ ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах зорнулалтаар эдэлбэр газар олгох бөгөөд шаардлагатай гэж үнэмл уул асуудлыг тухайн шатим иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлж болно;

4) нутаг дэвсгэртээ бүх төрлийн ашигт малтмалын хайгуул, орд ашиглалтын байдал, үр дүнгийн мэдээ, мэдээлэлтэй танилцах;

5) ердийн ашигт малтмалын ордын ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх;

6) Газрын хэвлийн тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### Тусгай зөвшөөрөл

**7 дугаар зүйл.** Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах эрх бүхий этгээд

1. Төрийн эрх бүхий байгууллагаас ашигт малтмалын хайгуул хийх болон ашигт малтмалын орд ашиглах эрх олгосон гэрчилгээн тусгай зөвшөөрөл гэнэ.

2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зөвхөн эрх бүхий байгууллагаас хуулийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл бүхий этгээд ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах эрхтэй.

3. Ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөлийг хууль тогтоомжид заасан шаардлага хангасан дараах этгээдэд олгож болно:

1) Монгол Улсын аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг бусад хуулийн этгээд;

2) Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж.

4. Ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээдэд олгож болно.

5. Гадаадын хуулийн этгээдэд стратегийн ашигт малтмалын ордыг ашиглуулах тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага нь Улсын Их Хурлын зөвшөөрлийг үндэслэн олгоно.

**8 дугаар зүйл.** Тусгай зөвшөөрөл олгох байгууллага

1. Стратегийн болон тусгай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2. Ердийн ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга төрийн захиргааны төв байгуулагатай зөвшилцөн олгоно.

3. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийг дор дурдсан байгууллага олгоно:



1) стратегийн болон тусгай ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага;

2) ердийн ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 6 дугаар зүйлийн 4, 5 дэхь хэсэгт зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга.

4. Ердийн ашигт малтмалыг шалзан, вааран эдлэл хийх, гад, хүчилд тэсвэртэй хэрэглэгдэхүүн, эрдэс хөвөн үйлдвэрлэх, түүнчлэн цементийн болон төмөрлөг, шилний үйлдвэрийн түүхий хэийн зориулалтаар ашиглаж болох нь хайгуул, шинжилгээгээр нотлогдовол түүний ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

5. Газар эзэмшигч нь эдэлбэр газарт нл байгаа буюу уурхайн бус аргаар олборлож болох ердийн ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр зөвхөн өөрийн хэрэгцээнд ашиглахад тусгай зөвшөөрөл авахгүй.

**9 дүгээр зүйл.** Ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөл олгож болох газар нутаг, талбай

1. Ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрлийг батлагдсан газрын зурагт тэмдэглэсэн газар нутагт олгоно.

2. Ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах газрын зургийг төрийн захиргааны төв байгууллага нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон төрийн захиргааны холбогдох бусад байгуулагатай тохиролцон баталж албан ёсоор хэвлүүлнэ.

3. Батлагдсан газрын зургийг тусгай зөвшөөрөл олгох байгууллага, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга тус тус бүртгэн хадгалж, өөрчлөлтийг тухай бүр тэмдэглэнэ.

4. Хайгуул хийх талбай, уурхайн эдэлбэрийн хэлийг нмар ч нөхцөлд тэгш өнцөгтийн хэлбэрээр тогтоох бөгөөд түүний гүний хэмжээг хязгаарлахгүй.

**10 дугаар зүйл.** Тусгай зөвшөөрөл авах тухай өртөдөл гаргах

1. Ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөл авах тухай өртөдлийг сонирхогч этгээд энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад гаргана.

2. Тусгай зөвшөөрөл авах тухай өртөдлийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид ний-

цүүдэн Засгийн газраас баталсан тусгай зөвшөөрөл олгох журмаар тодорхойлно.

3. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргана:

- 1) хайгуулын ажил гүйцэтгэх урьдчилсан гэрээ;
- 2) орчныг хамгаалах төлөвлөгөө (төсөл).

4. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргана:

- 1) эдэлбэр газрын зөвшөөрөл;
- 2) техник эдийн засгийн үндэслэл;
- 3) орчныг хамгаалах төлөвлөгөө (төсөл);
- 4) байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.

5. Гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай Монгол Улсын аж ахуйн нэгж стратегийн ашигт малтмалын орд ашиглах болон төслийн хөрөнгө оруулалт нь 4 тэрбум буюу түүнээс дээш төгрөг байх тохиолдолд сонирхогч этгээд энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан бичиг баримтаас гадна урьдчилсан гэрээг хавсаргана.

#### II дүгээр зүйл. Өргөдлийг хянан үзэх, тусгай зөвшөөрөл олгох

1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтан ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөл авах тухай сонирхогчийн өргөдлийг хүлээн авмагц түүний бүрдлийг хянан үзэж хуулийн шаардлага хангасан эсэхийг тогтооно.

2. Өргөдөл хуульд заасан шаардлага хангасан бол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэж харну өгнө. Харин ийнхүү шаардлага хангаагүй нь тогтоогдвол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор буцаана.

3. Дараахь тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохгүй:

1) тухайн газар нутаг, талбайд буюу ордод урьд олгосон тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаа;

2) хууль тогтоомжоор хориглосон газарт хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөл авахыг хүссэн;

3) хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээд тусгай зөвшөөрлийг хамтран эзэмшихээр өргөдөл гаргасан бол;

4) тухайн талбайд хайгуул хийх, эсхүл тухайн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл авахыг хүсч гаргасан өргөдөл хянан хэлэлцэгдэх шатанд байгаа бол;

5) шалгаруулалт зарласан тохиолдолд өргөдөл ирүүлэх хугацаа хожимдуулсан бол;

4. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл, мөн үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой гэж үзвэл сонирхогчдыг өрсөлдүүлэн ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийг шалгаруулалтын замаар олгож болно. Өрсөлдүүлэн шалгаруулах журмыг эцсийн шалгаруулалт хийх өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө зарласан байвал зохино.

5. Сонирхогч нэг этгээдэд 5-аас дээшгүй тусгай зөвшөөрөл олгох бөгөөд үүнээс 3 нь стратегийн ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл байж болно. Энэ хэсэгт заасан хэмжээний тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөл нэмж авахыг хүсвэл хайгуулыг өөрөө хийгээгүй тохиолдолд шалгаруулалтад орно.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн заалт хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгоход болон улсын үйлдвэрийн газарт орд ашиглах зөвшөөрөл олгоход хамаарахгүй.

7. Тусгай зөвшөөрөл олгохоор өрсөлдүүлэн шалгаруулахдаа дараахь үндсэн үзүүлэлт буюу шалгуурыг харгалзана:

- 1) орд ашиглалтын эдийн засгийн үр ашиг;
- 2) нөөц ашиглалтын түвшин;
- 3) ашиглах техник, технологи;
- 4) орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний чанар түвшин;
- 5) мэргэжлийн боловсон хүчний хангамж;
- 6) ашигт малтмал төрөл онцлогтой холбогдсон бусад үзүүлэлт.

8. Тусгай зөвшөөрөл олгогч байгууллага нь өрсөлдөгчдийн санаа, төсөл адна байгаа тохиолдолд өргөдөл хүлээн авсан дарааллыг харгалзан үзнэ.

9. Тусгай зөвшөөрөл олгох, шалгаруулалт явуулах журмыг Засгийн газар батална.

## **12 дугаар зүйл. Төрийн өмчийн оролцоо**

1. Тодорхой нэр төрлийн ашигт малтмалын орд ашиглаж улмаар түүний үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, орлого буюу ашиг хуваахад Засгийн газар хувь хөрөнгө нийлүүлж оролцох сонирхолтой бол энэ тухайгаа хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгохоос өмнө нийтэд буюу сонирхогчдод албан ёсоор зарлан мэдээлнэ.

2. Энэ зүйлийн I дэх хэсэгт заасан тохиолдолд төр оролцох болзол, хэлбэр, хугацааг ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглах гэрээгээр тодорхойлно.

3. Тодорхой нэр төрлийн ашигт малтмалын хайгуул хийх, ордыг ашиглахад Засгийн газар оролцохдоо хүлээх үүргийг төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжээр дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн аж ахуйн нэгж нь оролцогч бусад аж ахуйн нэгжтэй адил тэгш байх зарчмын үндсэн дээр үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

4. Ордыг илрүүлэх зорилгоор улсын хөрөнгөөр (төсвийн санхүүжилтээр) хийсэн хайгуулын ажлын зардлыг ордын үнэлгээнд оруулан тооцож, ашиглагч этгээдээс түрээсийн төлбөрт оруулан тооцох замаар нөхөн гаргуулна.

### 13 дугаар зүйл. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн давуу эрх

1. Хайгуул хийж, ашигт малтмалын орд илрүүлж нөөц тогтоосон тохиолдолд хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түүний хүчин төгөлдөр байх хугацаанд тухайн ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг тэргүүн ээлжинд авах давуу эрхтэй.

2. Энэ зүйлийн I дэх хэсэгт заасан тохиолдолд тухайн ордыг ашиглах тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл өөр этгээд гаргавал хайгуул хийж, орд илрүүлж нөөц тогтоосон этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүнд уг ордыг ашиглах тусгай зөвшөөрөл олгож болохгүй.

3. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордыг ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдлөө хайгуул хийх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө гаргана.

### 14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх, үүргээ бусдад шилжүүлэх

1. Хайгуул хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул зөвшөөрөл болон түүний дагуу байгуулсан гэрээгээр олсон эрх хүлээсэн үүргийг тусгай зөвшөөрлийг олгосон төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусад этгээдэд шилжүүлэх буюу уг эрх, үүргийг өөрчилсөн амар нэгэн гэрээ байгуулахыг хориглоно.

2. Тусгай зөвшөөрөл, түүний дагуу байгуулсан гэрээгээр олсон эрх, хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн бусдад шилжүүлэх, шилжүүлэн авахыг хүссэн хоёр тал энэ тухай өргөдөл гаргаж эрх шилжүүлэн авснаар хүлээх үүргийг

зохих ёсоор биелүүлэхээ эрх залгамжлагч этгээд бичгээр нотлон мэдэгдсэн бол анх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага тийнхүү эрх шилжүүлэхийг зөвшөөрсөн эсэхийг өргөдөл, мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор шийдвэрлэж харну мэдэгдэнэ.

3. Тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллага уул зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд эрх үүрэг шилжүүлсэн, шилжүүлэн авсан тухай хоёр талин гэрээ хүчин төгөлдөр болтол тусгай зөвшөөрөл анхлан эзэмшигч нь ашигт малтмалын тухай хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн биелүүлнэ.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дампуурсан, хэрэг хариуцах чадваргүй болсон, татан буугдсан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны байгууллага уул тусгай зөвшөөрлөөр олгосон эрхийг бусдад шилжүүлж болно.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд эрхээ шилжүүлэх хүртэлх хугацаанд биелүүлбэл зохих үүргийн гүйцэтгэлийг хангахад чөлөөлөгдөхгүй.

6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн саналын буюу шийдвэрлэх эрхэнд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад заавал мэдэгдэх бөгөөд энэ заалт тусгай зөвшөөрлөөр олгосон эрхийг шилжүүлэн авсан этгээдэд нэгэн адил хамаарна.

#### **15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг тооцох, сунгах**

1. Хайгуул хийх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгоно.

2. Орд ашиглах тусгай зөвшөөрлийг тухайн ордыг ашиглах техник эдийн засгийн үдэслэлээр тодорхойлсон хугацаагаар олгох бөгөөд энэ хугацаа 30 жилээс илүүгүй байна.

3. Хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс эхлэн тоолно.

4. Хайгуулыг үргэлжлүүлэн хийх зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон, тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын тухай хууль тогтоомж, хайгуулын ажлын гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол тусгай зөвшөөрөл анх олгосон байгууллага түүний хугацааг тус бүр хоёр жилээр хоёр удаа сунгаж болно.

5. Ашигт малтмалын тухайн ордыг цаашид ашиглах нөөц үлдсэн нь тогтоогдсон, тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын тухай хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол тусгай зөвшөөрөл анх олгосон байгууллага түүний хугацааг үлдсэн нөөцийг ашиглах хугацаагаар нэг удаа сунгаж болох бөгөөд энэ хугацаа 20 жилээс дээшгүй байна.

6. Хугацаа сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

#### **16 дугаар зүйл. Өргөдөл гаргасны үр дагавар**

1. Хайгууд хийх, орд ашиглах тухай зөвшөөрөл эзэмшигч нь хугацаа сунгуулах өргөдлөө энэ хуулийн 15 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан хугацаанд гаргасан бол тусгай зөвшөөрлийн анхны хугацааг сунгах буюу шинээр тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэрлэж хариу ирүүлэх хүртэл тусгай зөвшөөрлийн анхны хугацаа үргэлжилсэнд тооцно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрх нь хэвээр хадгалагдаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах, ордыг үргэлжлүүлэн ашиглах, тусгай зөвшөөрөл шинээр авах тухай өргөдөлд зааснаас бусад талбайг тогтоосон журмын дагуу чөлөөлөх үүрэгтэй.

#### **17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох үндэслэл**

1. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь эзэмшигчээс түүнийг сунгуулах тухай өргөдөл гаргаагүй бол анх төвлөсөн он, сар, өдрийн дараагийн ажлын өдөр болмогч ажилдаа дуусгавар болно.

2. Дараахь үндэслэлийн аль нэг нь байвал тусгай зөвшөөрлийн хугацаа төвлөснөөс өмнө дуусгавар болсонд тооцно:

1) тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан;

2) орд ашиглах тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 5 жилийн хугацаанд таварын бүтээгдэхүүн гаргаж эхлээгүй;

3) тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс эрх бүхий байгууллага энэ хуульд заасны дагуу уул зөвшөөрлийг дангаар буюу эзэмшигчийн хүсэлтээр нупалсан;

4) ашиглалтыг дуусгаж тухайн ордыг улсад эргүүлэн хүлээлгэж өгсөн.

**18 дугаар зүйл. Ашигт малтмалтай холбогдох мэдээллийг ашиглах**

1. Хайгууд хийх, орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан, мэдээллийг хадгалалч байгууллага нь уул зөвшөөрөл дүчинтэй байх хугацаанд энэ зүйлийн 2 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд эзэмшигчийн нь зөвшөөрөлгүйгээр уг тайлан, мэдээллийг бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тайлан, мэдээллийг дараахь үндэслэл байвал тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусдад танилцуулж болно:

1) шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага танилцуулахыг шаардах;

2) ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан танилцуулахыг шаардах;

3) улсын статистикчийн нэгдсэн мэдээ, тайлан гаргахад ашиглах.

## ГҮРАВДУГААР БҮЛЭГ

### Хайгуул

**19 дүгээр зүйл. Хайгуул**

Ашигт малтмалын ордыг олж баруулах, түүний үйлдвэрлэлийн ач холбогдлыг тодорхойлох зорилгоор региональ геологи, геофизик, геохимийн судалгаа хийх, ил, далд малталт, өрөмдлөгөөр ашигт малтмал, ус, хөрсний дээж, сорьц авч шинжлэх, лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн нөхцөлд технологийн туршиат хийх, орд газрын нөөцийг тогтоох үйл ажиллагааг хайгуул гэнэ.

**20 дугаар зүйл. Хайгууд хийх тусгай зөвшөөрлөөр олгох талбай**

1. Хайгууд хийх тусгай зөвшөөрлөөр олгох талбайн хэмжээ 8 ам километрээс багагүй, 4 мянган ам километрээс ихгүй байна.

2. Эрх бүхий байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгоходоо хайгууд хийх талбайн хилийг тогтоосон журмын дагуу тодорхойлон тэмдэглэсэн газрын зургийн нэг хувийг

тусгай зөвшөөрөлд, нөгөө хувийг гэрээний эх хувьд тус тус хийсэргэн хадгална.

3. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөр этгээдэд олгоогүй талбайг нэмж авахаар өргөдөл гаргасан бол хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн нөхцөлд эрх бүхий байгууллага урьд олгосонтой нь хял заалгасан талбайг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дээд хэмжээнд багтаан олгож болно.

#### 21 дүгээр зүйл. Хайгуулын ажил эхлэх

1. Эзэмшигч нь тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 180 хоногийн дотор гэрээ байгуулж, хайгуулын ажлыг эхлэх бөгөөд энэ тухайгаа төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргад бичгээр мэдэгдэнэ.

2. Хайгуулын ажил эхэлсэн тухай мэдэгдээд тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн овог нэр, албан ажлын болон оршин суугаа газрын хаяг, тусгай зөвшөөрлийн дугаарыг бичсэн байвал зохино.

#### 22 дугаар зүйл. Хайгуулын ажил гүйцэтгэх гэрээ

1. Хайгуулын ажил гүйцэтгэх гэрээг нэг талаас тусгай зөвшөөрөл олгосон төрийн байгууллага (цаашид «захирал» гэх) нь нөгөө талаас хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид «гүйцэтгэгч» гэх)-д энэ хуульд заасан хэмжээний талбайг олгон хайгуул хийлгэх, хэрэв төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бол уул хөрөнгийг паг тухайд нь гаргаж өгөх, гүйцэтгэгч нь зөвшөөрөгдсөн талбайд өөрийн буюу захиралын хөрөнгөөр хайгуулын ажлыг гүйцэд хийж, нөхцийг тогтоон талбайг хүлээлгэн өгөх үүрэг тус тус хүлээнэ.

2. Хайгуулын ажил гүйцэтгэх гэрээг (цаашид «хайгуулын гэрээ» гэх) тусгай зөвшөөрөл, урьдчилсан гэрээний үндсэн дээр иргэний хуульд нийцүүлэн бичгээр байгуулна.

3. Хайгуулын гэрээний хугацааг урьдчилсан гэрээ, хайх дингт малтмалын нэр төрөл, уул-геологийн нөхцлийг харгалзан тусгай зөвшөөрлийн хугацаанд багтаан талууд харилцан тохиролцож тогтооно.

#### 23 дугаар зүйл. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх

1. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх эдэлнэ:



1) хайгууд хийх зөвшөөрөгдсөн талбайд нэвтрэхийн тулд шаардлагатай газар нутгаар дамжин өнгөрөх;

2) хайгуул хийх зорилгоор хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу зам тавих, нислэгийн зурвас, талбай засах, хайгуулидын тогтон, түр барилга байгууламж барих, зориулалтын техник, тоног төхөөрөмж суурилуулах, суваг шуудуу татах, ил, далд малталт, өрөмдлөг хийх;

3) хайгуулын талбай дахь ус, элс, хайрга, зам, суваг болон дэд бүтцэд хамаарах байгууламжийг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу ашиглах;

4) хайгуулаар илрүүлсэн ашигт малтмалын дээж, сорьцыг шинжлэн судлах, технологийн туршилт хийхэд ашиглах.

2. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын дээж, сорьцыг зөвхөн хээрийн ажлын баримт бичиг бүрдүүлсний үндсэн дээр хайгуулын талбайгаас гаргах эрхтэй.

#### **24 дүгээр зүйл. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг**

1. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

1) хайгуулын ажлыг гэрээнд заасан хугацаанд эхэлж, гүйцэд хийж дуусган талбайг сэргээн засаж хүлээлгэн өгөх;

2) гэрээнд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрөл олгох талбайг хүлээлгэн өгөх болон гэрээгээр гүйцэтгэх ажлын зардлыг санхүүжүүлэх;

3) хайгуул хийхдээ дэвшилтэт техник, технологи, арга барилыг хэрэглэх;

4) хайгуулын ажлын зураглал, бүртгэл, мэдээг тогтоосон журмын дагуу хөтлөх, мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнах;

5) шинжлэн судлах, туршилт хийх зорилгоор авсан ашигт малтмалын дээж, сорьцыг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад илгээжүүлэх;

6) орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, хууль тогтоомжийн бусад шаардлагыг чанд биелүүлэх.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуул хийх явцад газар, түүний хэвлийд гаргасан эвдрэлийг засаж тохижуулах, хүн, мал амьтанд аюул осолгүй болгох, газар өмчлөгч буюу эзэмшигчид учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

3. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хураамжаас гадна хайгуулын талбай эзэмшсэний хураамж төлөх Бөгөөд түүний хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.

**25 дугаар зүйл.** Хайгуул хийх тусгай зөвшөөрлөөр ашигт малтмал олборлохыг хориглох

1. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөгдсөн талбайд зөвхөн хайгуул хийх эрхтэй бөгөөд дээж, сорьц авахаас өөрөөр ашигт малтмал олборлох, боловсруулах, борлуулахыг хориглоно.

2. Хайх, олборлох ажлыг нэгэн зэрэг хийвэл зохих ашигт малтмалын тухайд хайгуул хийх болон орд ашиглах тусгай зөвшөөрлийг хамт авсан байвал зохино.

**26 дугаар зүйл.** Хайгуулын ажлын зардал, барьцаа

1. Хайгуулын ажлын зардалыг доод хэмжээг тогтоох, үдгээрт өөрчлөлт оруулах журмыг Засгийн газар энэ хуульд нийцүүлэн тогтооно.

2. Тусгай зөвшөөрлийн хугацаанд хайгуулын зардал хэтэрсэн бол уул тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах үед шалжүүлэн тооцож болно.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулыг хууль болон гэрээнд заасан хугацаанд эхлэх, дуусгахын баталгаа болгож тухайн жилийн хайгуулын зардалын 10 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг захиалагчид барьцаална.

4. Захиалагч нь хайгуулын ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлсэн хэмжээгээр барьцаалсан хөрөнгийг түүнд буцаан олгох буюу үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулах зардалд тооцон суутгана.

5. Барьцааны хөрөнгийг энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар суутган авсан нь гүйцэтгэгчийг хайгуулын ажлаа хугацаанд нь эхлэх үүргээ бүрэн чөлөөлөх үндэслэл болохгүй.

**27 дугаар зүйл.** Ашигт малтмалын ордын нөөцийн тооцоог гаргах, хянах

1. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөөцийн тооцоог хийж хайгуулын ажлын тайлангийн хамт тусгай зөвшөөрөл олгогчид албан ёсоор хүлээлгэн өгнө.

2. Тусгай зөвшөөрөл олгогч нь ордын нөөцийг үнэн зөв тооцсон эсэхийг шалгаж тогтоосны үндсэн дээр уул тооцоо, тайланг хүлээн авах үүрэгтэй.

**28 дугаар зүйл.** Хайгуулын ажлыг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь зөрчил гаргасан тохиолдолд түүний шалтгааныг тогтоох, уул зөрчлийг арилгах зорилгоор төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хайгуулын ажлыг 90 хүртэл ховогийн хугацаагаар түдгэлзүүлж болно;

1) хайгуулын гэрээ болон уул ажлыг санхүүжүүлэх үүргээ биелүүлээгүй;

2) зөвшөөрөгдсөн талбайн хилийн гадна хайгуул хийсэн;

3) тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлосон;

4) үйлдвэрлэлийн аюул осол гарах болон ажиллагчдын эрүүл мэнд, амь насанд аюул учруулахуйц нөхцөл байдал бий болсон;

5) орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөт арга хэмжээг биелүүлээгүй болон бусад хэлбэрээр байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн.

2. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь уул зөвшөөрлийг эзэмшигч энэ зүйлийн I дэх хэсэгт зааснаар түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй, түүнчлэн татан буугдсан, дампуурсан, бусад шалтгаанаар хуулийн этгээдийн хувьд оршин тогтнохоо больсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг дангаараа цуцлах эрхтэй бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол тийнхүү цуцалснаас учирсан дохирлыг харууцахгүй.

3. Хайгуулын ажлыг түдгэлзүүлсэн болон тусгай зөвшөөрлийг цуцалснаар түүнийг эзэмшигчийг хууль болон гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дутууг гүйцэтгэх, учруулсан хохирлоо нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

4. Хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй.

**29 дүгээр зүйл.** Эзэмшигчийн хүсэлтээр тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын тухай хууль тогтоомж, хайгуул хийх, орд ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт төлөх албан татвар, төлбөр, хураамжийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох өдрөөр тооцож бүрэн төлсөн бол түүний хүсэлтээр уул зөвшөөрлийг хугацаанаас өмнө цуцалж болно.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ийнхүү цуцлах тухай өргөдлөө түүнд холбогдох бүх тооцоо, бичиг баримтын хамт бичгээр гаргаж хайгуулын ажлаа зогсоохоос 90-ээс доошгүй хоногийн өмнө тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад өгсөн байвал зохино.

3. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийг цуцлах өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэж харну мэдэгдэх бөгөөд энэ хугацаанд зохих харну өгөөгүй бол эзэмшигч тусгай зөвшөөрлийг цуцалсанд тооцож үйл ажиллагаагаа зогсоож болно.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн буруугаас түдгэлзүүлсэн, цуцалснаас үүссэн хохирлыг хууль, гэрээнд заасны дагуу үүргийн гүйцэтгэлээр тооцно.

**30 дугаар зүйл.** Хайгуулын талбайг чөлөөлөх

1. 40 ам километрээс дээш хайгуулын талбай эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн анхны хугацаа дуусмагц талбайнхаа 75 хувиас багагүйг уул зөвшөөрлийг сунгуулсан хугацаа дуусах бүрт үлдсэн талбайн 50 хувиас багагүйг тус тус чөлөөлж эргүүлэн тушаах үүрэгтэй.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул хийсэн талбайгад энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас илүү хэмжээгээр жил бүрийн эцэст чөлөөлж эргүүлэн тушааж болно.

3. Чөлөөлөх талбай нь түүний урьд чөлөөлсөн талбайтай хил залгасан байвал зохино.

4. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь талбайг чөлөөлөх талаар дарлах шаардлагыг хангах үүрэгтэй:

1) талбайг чөлөөлөхийн өмнө тэнд хайгуулын болон байгаль орчинг хамгаалах ажлыг гэрээ, төлөвлөгөө ёсоор бүрэн гүйцэтгэж, хайгуулын ажлын төлөвлөгдсөн зардлыг бүрэн гаргаж тоодсон байх;

2) талбайн хэсгийг чөлөөлөх бүрт хайгуулын гэрээ, зардлын хэмжээг үлдсэн талбайн ажлын хэмжээнд тохируулан өөрчлөх;

3) хайгуулын ажлын бүх төрлийн тайлан, мэдээ, зураг, бүдүүвч, шинжилгээ судалгаа, туршилтын дүн, бусад бичиг баримтын хувийг үнэ төлбөргүйгээр төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэн өгөх

4) энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор чөлөөлөх талбайд байгаа техник, тоног төхөөрөмж, эд хөрөнгөө татан авах;

31 эд хөрөнгөө татан авах хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө хайгуулын явцад гаргасан бүх цооног, нүх, шуудуу, малталтыг дарж булаах буюу өөр байдлаар тогтоосон журмыг дагуу талбайг аюулгүй болгож байгаль хамгаалахтай холбогдсон бусад шаардлагыг хангаж тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

5. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалмагц буюу түүний хугацаа дуусмагц гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн талбайгаас техник, тонсг төхөөрөмж бусад эд хөрөнгөө гарган авахыг уул зөвшөөрлийг эзэмшигчид мэдэгдэх бөгөөд тогтоосон хугацаанд тэдгээр эд хөрөнгөө татан аваагүй бол улсын зардлаар зайдуулж гарсан зардал, хохирлыг нөхөн төлүүлнэ.

**31 дүгээр зүйл.** Хайгуулын талбайг хүлээлгэн өгөх журам

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн шаардлагын дагуу талбайг хүлээлгэн өгөхөд бэлэн болгож уул тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

2. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага мэдэгдэл хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн захиргааны байгаль, орчныг хамгаалах болон геологи, уул уурхайн хяналтын байгууллагын төлөөлөгчийг тус тус оролцуулсан талбай хүлээн авах комиссыг томилж уул талбайд үзлэг шалгалт хийнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хүлээн авах комисст хайгуулын талбайг хүлээлгэн өгч энэ тухай акт үйлдэн хоёр талын гарын үсэг зурснаар уул талбайг хүлээлгэн өгсөнд тооцно.

4. Актанд хүлээлгэн өгсөн талбайн байршил, хэмжээ, чөлөөлөх болон байгаль орчныг хамгаалах талд ар тавих шаардлагыг хангасныг бичиж маргаантай асуудал байвал түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа дурдсан байвал зохино.

5. Комисс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчээс энэ хуулийн 30 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй бол талбайг хүлээн авахаас татгалзаж болно.

**32 дугаар зүйл.** Өөр этгээдэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох

Хууль болон гэрээнд заасны дагуу чөлөөлж, эргүүлэн хүлээлгэж өгсөн талбайд дахин буюу нэмэлт хайгуул хийх тусгай зөвшөөрлийг сонирхогч этгээдэд энэ хуульд заасны журмын дагуу олгож болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Уурхайн эдэлбэрийг түрээслэх, ашигт малтмалын орд ашиглах

#### 33 дугаар зүйл. Уурхайн эдэлбэрийг түрээслэх гэрээ

Уурхайн эдэлбэр түрээслэх гэрээг нэг талаас төрийн өмчийн зохих шатны байгууллага (цаашид «түрээслүүлэгч» гэх), нөгөө талаас ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид «түрээслэгч» гэх)-д ашигт малтмалын орд бүхий уурхайн эдэлбэрийг зохих болзол, төлбөртэйгээр тодорхой хугацаагаар эзэмшүүлж ашиглуулах, түрээслэгч нь түрээсийн төлбөрийг цаг тухайд нь төлж, ордыг хууль тогтоомжийн дагуу ашиглах үүргийг тус тус үлдэнэ.

#### 34 дүгээр зүйл. Гэрээний хэлбэр, хугацаа

1. Уурхайн эдэлбэр түрээслэх гэрээг (цаашид «түрээсийн гэрээ» гэх) тусгай зөвшөөрлийн үндсэн дээр энэ хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл ба урьдчилсан гэрээний үндсэн дээр Иргэний хуульд нийцүүлэн бичгээр байгуулна.

2. Түрээсийн гэрээний хугацааг техник эдийн засгийн үндэслэл, түүний уул-геологийн нөхцөлийг харгалзан тусгай зөвшөөрлийн хугацаанд багтаан талууд харилцан тохиролцож тогтооно.

#### 35 дугаар зүйл. Түрээсийн төлбөр

1. Түрээсийн төлбөр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уурхайн эдэлбэр газрын төлбөрөөс бүрдэнэ. Уурхайн эдэлбэр газрын түрээсийн төлбөрийг хууль тогтоомжийн хэлбэгдох актаар зохицуулна.

2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь тухайн ордыг ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулснаас олох орлогын 1,5 хувиас багагүй, 12, 5 хувиас ихгүй байна. Харин борлуулалтын орлогыг нь тооцох боломжгүй ашигт малтмалын хувьд төлбөрийг түүний биет хэмжигдэхүүнээр тогтоож болно.

3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тарифыг стратегийн ашигт малтмалын хувьд Улсын Их Хурал, тусгай ашигт малтмалын хувьд Засгийн газар, ердийн ашигт малтмалын хувьд тухайн уурхайн эдэлбэрийг харьяалах аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ту-

хайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр хууль тогтоомжид заасан дээд хэмжээнд багтаан тус тус тогтооно.

4. Стратегийн ашигт малтмалын орд ашиглаж байгаа нөхцөлд ашигт малтмалын нөөц ашигласан төлбөрийг хуульд өөрөөр заагаагүй бол талууд харилцан тохиролцож тухайн төрлийн биет бүтээгдэхүүнээр төлж болно.

5. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг шууд тодорхойлох боломжгүй нөхцөлд төрийн захиргааны төв байгууллага уг төлбөрийн түр мөрдөх хэмжээг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хэмжээний дотор тогтоон өгч болох бөгөөд бодиг хэмжээг тодорхойлсны дараа холбогдох зөрүүг нөхөн төлүүлэх буюу эгүүлэн олгоно.

6. Ердийн ашигт малтмалыг иргэд өөртөө гэр ахуйн зориулалтаар нэг удаа ашиглахад ашигт малтмалын нөөц ашигласны түрээсийн төлбөр төлөхгүй бөгөөд нэг удаа төлбөргүй ашиглаж болох ашигт малтмалын жагсаалтыг Засгийн газар батална.

7. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Төсвийн болон албан татварын тухай хууль тогтоомжийн дагуу төсөвт хуваарилан оруулах журмыг Засгийн газар тогтооно.

### 36 дугаар зүйл. Түрээслүүлэгчийн үүрэг, эрх

Түрээслүүлэгч нь дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

1) уурхайн эдэлбэр, ашигт малтмалын ордыг гэрээнд заасан болзол, хугацаанд түрээслэгчид хүлээлтэн өгөх, хүлээж авах болон хууль, гэрээнд заасан бусад үүрэг хүлээнэ;

2) гэрээний биелэлтэд хяналт тавих, түрээслэгч зэрэгцээ орших ордыг хууль бусаар хойдсон, түрээсийн төлбөрийг хугацаанд нь удаа дараа төлөөгүй, геологи-уул уурхайн хяналтын болон байгаль орчны хяналтын байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, түүнчлэн хууль, гэрээнд заасан үүргээ бусад хэлбэрээр зөрчсөн тохиолдолд хуульд заасан үндэслэлийн дагуу гэрээг тудгэлзүүлэх, цуцлах, үүргийн дутууг хангахыг болон учирсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

### 37 дугаар зүйл. Түрээслэгчийн үүрэг

1. Түрээслэгч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) уурхайн эдэлбэрийн хилийн тэмдгийг тэмьж, зохионо рөгдсөн хилийн дотор ашигт малтмалыг техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, уулын ажлын болон байгаль орчныг хамгаалах арга хэмжээний батлагдсан төлөвлөгөө технологийн горимын дагуу бүрэн гүйцэд олборлох;

2) ашигт малтмалын орд ашиглах дэвшилтэт техник, технологи, түүний дотор алт болон түүнтэй адилтгах валютын үнэт металл олборлохдоо шороон ордод 90-ээс доошгүй, үндсэн ордод 85-аас доошгүй хувийг ялган авах технологи хэрэглэх;

3) түрээсийн төлбөрийг гэрээнд өөрөөр заагаагүй бол тогтмол хугацаанд нь бүрэн төлөх;

4) ордын ашиглалттай холбогдсон бүх төрлийн бүртгэлийг хөтөлж мэдээ, тайланг, тогтоосон хугацаанд гаргаж тайлагнах, алт, үнэт металлын орд ашиглахдаа олборлосон алтыг өдөр бүр жилэн, чанарыг тодорхойлон бүртгэж, экспортолох бол цэвэршүүлж сорьцыг тогтоолгон баталгааны тэмдэг даруулсан байх;

5) стратегийн ашигт малтмалын орд ашиглаж олборлосон бүтээгдэхүүнийг борлуулахдаа төлбөр тооцоог гагцхүү банкаар дамжуулан гүйцэтгэх;

6) улсын санд худалдах стратегийн ашигт малтмалыг эхний ээлжинд нийлүүлэх;

7) 400 граммаас дээш жинтэй, түүнээс бага боловч онцгой чамин дүр хэлбэртэй төрц алтыг олсон, олборлосон бол төрийн эрдэнэсийн санд урамшилтай үнээр худалдах;

8) ордыг буюу түүний хэсгийг ашиглаж дууссан тохиолдолд уурхайн эдэлбэрийг байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээж, ордыг хууль тогтоомжид зассан журмын дагуу түрээслүүлэгчид хүлээлгэн өгөх;

9) Газрын хэвлийн тухай хууль, бусад хууль болон талуудын тохиролцсон гэрээнд заасан бусад үүрэг.

2. Тухайн үндсэн ордын уул-геологийн нөхцөлөөс шалтгаалан түүний ашигт малтмалын хүдрийн агуулгыг зохистой ашиглах дээд түвшин энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-г заасан хэмжээнд хүрэхээргүй байвал техник эдийн засгийн үндэслэлийг харгалзан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр 50 хувь хүртэл бууруулж тогтоож болно.

3. Өөд нэр төрлийн ашигт малтмалын ордыг түрээслэгч нь тухайн уурхайн эдэлбэрийн дотор стратегийн ашигт малтмалын илэрц, орд нэвчлэл энэ тухай төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд нээсэн ордоо хуульд заасан нөхцөлөөр ашиглах тусгай зөвшөөрлийг тэргүүн ээлжинд авах давуу эрхтэй.

4. Түрээслэгч нь орд ашиглахтай холбогдсон барилга байгууламж барих, нийтийн хэрэглээний зориулалттай эрчим



хүч, харилцаа холбооны сүлжээ, суваг, авто болон төмөр зам ашиглах, эдэлбэр газар, ус ашиглах, уурхайн аюулгүй ажиллагаа, ажиллагчдын хөдөлмөр хамгааллыг хангах, орд болон олборлосон ашигт малтмалыг хадгалаж хамгаалах зэрэг бусад төрлийн харилцаанд хууль тогтоомжийн холбогдох ахтад заасан журмыг нийтийн адил сахин биелүүлэх бөгөөд эдгээр нь орд ашиглах тусгай зөвшөөрөлд хамаарахгүй.

### 38 дугаар зүйл. Түрээслэгчийн эрх

1. Түрээслэгч нь дараахь эрх эдэлнэ:

1) ордыг ашиглаж олсон бүтээгдэхүүн буюу орлогоо энэ хуульд заасны дагуу өмчлөх;

2) уурхайн эдэлбэрт нэвтрэхийн тулд шаардлагатай газар, нутгаар дамжин өнгөрөх, ашигт малтмал олборлох, тээвэрлэх, хадгалах, боловсруулахад шаардагдах барилга байгууламж барих, техник, тонг төхөөрөмж суурилуулах;

3) уурхайн эдэлбэрийн дотор ашигт малтмалыг нэмэн хайх, олборлох;

4) эзэмшилдээ байгаа ордын аж үйлдвэрийн аргаар ашиглах боломжгүй нь тогтоогдсон хэсгийн ашигт малтмалыг түрээслэгчийн зөвшөөрөлдгүйгээр Монгол Улсын иргэд, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан олборлуулж, үүргийн гүйцэтгэлийг өөрийн ажлын дүнд оруулан тооцох;

5) ашиглалтын ишэд ашигт малтмалын ордын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан уурхайн эдэлбэрийн хэмжээг өөрчлөхийг шаардах.

2. Түрээслэгч нь орд ашиглахтай холбогдсон нэмэлт ажлыг иргэний зохих гэрээний үндсэн дээр бусад этгээдээр гүйцэтгүүлж болох боловч түрээслүүлэгчийн өмнө хүлээсэн бүхий л үүргийн гүйцэтгэлийг сагхлуу өөрөө хариуцна.

3. Уурхайн эдэлбэрийг дамжуулан түрээслэхийг хориглоно.

### 39 дүгээр зүйл. Уурхайн эдэлбэр олгох

1. Эрх бүхий байгууллаага нь ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохын өмнө уул зөвшөөрлийг зэмших этгээдийн зардлаар маркшейдерийн хэмжилт хийж, уурхайн эдэлбэрийн талбай, хилийг тогтоож баримтжуулана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хилийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгогчсор уурхайн эдэлбэрийг олгоснол тооцно.

3. Уурхайн эдэлбэрт хамаарахгүй эдэлбэр газрыг газрын тухай хууль тогтоомжинд заасан үндэслэл, журмын дагуу олгоно.

**40 дүгээр зүйл.** Техник эдийн засгийн үндэслэл

1. Уул уурхайн үйлдвэрлэлд түгээмэл хэрэглэдэг олон улсын хэмжээний шалгуур, тооцоо, шинжилээний аргыг хэрэглэн тухайн ордын үр ашиг, ашиглалтын явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг тогтоож, уг ордыг ашиглах үндэслэлийг тодорхойлсон бичиг баримтыг техник эдийн засгийн үндэслэл гэнэ.

2. Техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын болон орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө нь энэ хуульд нийцүүлэн гаргасан журамд заасан мэдээллийг агуулсан тусгай зөвшөөрөл олгосон байгууллагаар батлагдсан байвал зохино.

3. Түрээслэгч нь техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын болон орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага уг зөрчлийг арилгах хугацаатай шаардлага тавих, уг зөрчлийг арилгаж дуустал уурхайн ашиглалтын өмнөх болон ашиглалтын үйл ажиллагааг түдгэлзүүлэх эрхтэй.

4. Техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын болон орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө бодит байдалтай нийцэхгүй нь илэрвэл түрээслэгч энэ тухайгаа тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэж, уул техник эдийн засгийн үндэслэл, төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан батлуулах эрхтэй.

**41 дүгээр зүйл.** Ашиглалтын өмнөх үйл ажиллагааг эхлэх таваарын бүтээгдэхүүн гаргах

1. Түрээслэгч тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш нэг жилийн дотор уурхайн ашиглалтын өмнөх үйл ажиллагааг эхэлж 5 жилийн дотор таваарын бүтээгдэхүүн гаргасан байвал зохино.

2. Түрээслэгч нь хүндэтгэн үзэх ноцтой шалтгаанаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд таваарын бүтээгдэхүүн гаргаж чадаагүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг уг хугацаа дууссанаас хойш 10 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад гаргаж болно.

3. Өргөдлөө хугацаанд нь гаргаагүй буюу эсхүл тусгай

зөвшөөрлийн хугацааг сунгаагүй тохиолдолд гэрээг хүчингүй болсонд тооцох бөгөөд энэ тохиолдолд уурхайн эдэлбэр түрээслэгч уг зөвшөөрлөөс өмнө авсан хайгуул хийх тусгай зөвшөөрлийг эзэмшигчийн эрхтэй үлдэнэ.

4. Ордыг ашиглах нь тухайн нөхцөлд үр ашиггүй нь нотлогдвол түрээслэгч таваарын бүтээгдэхүүн гаргалтаа зогсоож энэ тухай түрээслүүлэгчид мэдэгдэх эрхтэй.

5. Таваарын бүтээгдэхүүн гаргалтыг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад шалтгаанаар дараалсан хоёр жил ба түүнээс илүү хугацаагаар зогсоовол орд ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож болно.

6. Түрээслэгч тухайн уурхайн үйлдвэрийн төслийн нэг жилийн хүчин чадалтай тэнцэх хэмжээний таваарын бүтээгдэхүүн гаргалтыг нэг жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлж зогсоох өргөдлийг төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох бөгөөд энэ хүсэлт үндэслэлтэй нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага тийнхүү түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно.

7. Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа болон таваарын бүтээгдэхүүн гаргалтыг хуулийн хугацаанд эхлээгүй бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаагүй, түүнчлэн энэ зүйлийн 3, 4, 5 дахь хэсэгт заасан тохиолдолд түрээслүүлэгч түрээслэгчтэй үүргийн гүйцэтгэлийг тооцож, хохирлоо нэхэмжлэх эрхтэй.

#### 42 дугаар зүйл. Уурхайн ажлын дэвсгэр зураг

1. Уурхайн үйлдвэр бүр газар дээр нь хийсэн маркшейдерийн хэмжилтийг үндэслэж зохих нарийвчлалтай боловсруулсан уурхайн ажлын дэвсгэр зурагтай байна.

2. Түрээслэгч уулын ажлын явцад гарсан өөрчлөлтийг маркшейдерийн хэмжилтийг үндэслэн дэвсгэр зурагт тухай бүр тусгаж байвал зохино.

3. Холбогдох маркшейдерийн хэмжилт хийж дэвсгэр зурагт тусгахгүйгээр уурхайн ажил явуулах, хаахыг хориглоно.

4. Уурхайн ажлын дэвсгэр зураг зохих нарийвчлалгүй нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага маркшейдерийн хяналтын хэмжилтийг түрээслэгчийн зардлаар хийлгэж болно.

#### 43 дугаар зүйл. Стратегийн ашигт малтмалын харуул хамгаалалт

1. Стратегийн ашигт малтмалын орд ашиглах тусгай

зөвшөөрөл эзэмшигч нь харуул хамгаалалтын талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) стратегийн ашигт малтмал, түүнийг олборлогчид, уурхай (үйлдвэр)-г гэмт халдлагаас хамгаалах үүрэг бүхий байнгын мэргэшсэн хамгаалаалт тогтоож, түүний зардлыг санхүүжүүлэх;

2) үйлдвэрлэлийн явцад стратегийн ашигт малтмалын үрэгдэл, шамшигдлаас сэргийлэн хамгаалах зорилгоор дохиолол, хамгаалалтын техник хэрэгслээр уурхайн чухал объектуудыг тоноглож байх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлэх зорилгоор стратегийн ашигт малтмалын орд түрээслэгч нь цагдаагийн харуул хамгаалалттай байж болно.

#### 44 дүгээр зүйл. Уурхайн аюулгүй ажиллагаа

1. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайд ажиллагчдыг ажлын байранд аюул осолгүйгээр орж, гарах буюу хөдөлмөрлөх бүх төрлийн хамгаалалтын арга хэмжээ авах, түүнчлэн агааржуулах болон гал, үер, цахилгаан, тэсрэлтийн аюулаас хамгаалах, аврах үйл ажиллагааг явуулах талаарх хөдөлмөр хамгаалах, аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг мөрдөнө.

2. Ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төрийн захиргааны төв байгууллагатай харилцан тохиролцож сонгосон хөндлөнгийн шинжээчээр уурхайн хайгдлын сан болон усан сангийн бүрэн бүтэн байдлын талаарх гео-техинкийн судалгаа, уг байгууламжид эндрэл гарах магадлал болон эндрэлийн улмаас учирч болох хохирлын үнэлгээг хийлтгэж төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

#### 45 дугаар зүйл. Уурхайн ослоос сэргийлэх

1. Түрээслэгч уурхайн ослоос сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

2. Уурхайн ашиглалтын явцад хүний амь үрэгдүүлсэн, хүнд болон бүлэг осол, түүнчлэн аливаа этгээдийн эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн осол гарсан, онцгой аюултай нөхцөд байдал бий болсон тохиолдолд энэ талаар уурхайн захирал түүнийг эзгүйд орлогч нь буюу хөдөлмөр хамгаалах хяналт тавих эрх үүрэг бүхий ажилтан 24 цагийн дотор төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх бөгөөд төрийн захиргааны төв байгууллага холбогдох

хууль тогтоомжийн дагуу шаардлагатай бүх арга хэмжээ шуурхай авах үүрэгтэй.

**46 дугаар зүйл.** Орд ашиглалтыг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг цуцлах

1. Дараахь нөхцөл байдал тогтоогдвол орд, түүний тухайн хэсгийн ашиглалтыг хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрөл олгосон болон захиргааны тусгай хяналтын эрх бүхий байгууллагын шийдвэрээр зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

1) энэ хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5 дахь заалтад заасан нөхцөл байдал бий болсон;

2) улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт оруулах албан татвар, төлбөр, хураамжийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаанд нь төлөөгүй;

3) зураг, төслийн баримтад тусгагдсан техник технологийн үндсэн шийдэл, техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын болон орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг зөрчсөн.

2. Түрээслэгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй, түүнчлэн татан буугдсан, дампуурсан, орлого нь барьцаалагдсан, бусад шалтгаанаар хуулийн этгээдийн хувьд оршин тогтнохоо больсон бол тусгай зөвшөөрөл олгосон байгууллага өөрийн санаачилгаар буюу түрээслэгчийн хүсэлтээр уул зөвшөөрлийг цуцлах эрхтэй.

3. Орд ашиглалтыг хууль ёсоор түдгэлзүүлсэн хугацаанд түрээслэгч хууль тогтоомж, гэрээний дагуу төлбөл зохих албан татвар, төлбөр, хураамжийн үүргээс чөлөөлөгдөхгүй.

4. Орд ашиглах тусгай зөвшөөрлийг цуцалсан нь түрээслэгчийг уул зөвшөөрлийг цуцлах хүртэл хугацаанд хууль болон гэрээ ёсоор гүйцэтгэвэл зохих үүргээс нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

5. Түрээслэгч тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

**47 дугаар зүйл.** Орд ашиглах тусгай зөвшөөрлийг түрээслэгчийн хүсэлтээр хугацаанаас нь өмнө цуцлах

1. Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал орд ашиглах тусгай зөвшөөрлийг түрээслэгчийн хүсэлтээр мөн зүйлд заасан журмын дагуу хугацаанаас нь өмнө цуцалж болно.

2. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага уул зөвшөөрлийг түрээслэгчийн хүсэлтээр цуцлах тухай асуудлыг шийдвэрлэхдээ түрээслүүлэгчийн саналыг харгалзан үзэх үүрэгтэй бөгөөд түрээслүүлэгч тийнхүү цуцлахаас үндэслэл бүхий шалтгаанаар татгалзвал түрээслэгч дангаараа цуцлах эрхгүй.

**48 дугаар зүйл. Уурхайн эдэлбэрийг чөлөөлөх, хүлээлгэн өгөх**

1. Түрээслэгч нь ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрлийн болон гэрээний хугацаа дууссан буюу эсхүл тусгай зөвшөөрөл, гэрээг хууль ёсоор цуцалсан өдрөөс хойш 180 хоногийн дотор уурхайн эдэлбэрийг чөлөөлж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

2. Уурхайн эдэлбэр эзэмшигч нь тогтоосон хугацаанд талбайг чөлөөлөхгүй бол техник, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг түрээслүүлэгчийн зардлаар зайлуулж гарсан зардал, хохирлыг төлүүлнэ.

3. Уурхайн эдэлбэр газарт байгаа барилга байгууламж, суурилуулсан техник, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шилжүүлэн байрлуулах нь үр ашиггүй буюу зайлуулах шаардлагагүй, шууд буюу өөр зорилгатаар ашиглах боломжтой гэж төрийн захиргааны төв байгууллага тогтоовол талбайд хэвээр үлдэж болно. Энэ тохиолдолд уул хөрөнгийн ашиглалтын асуудлыг өмчлөгч шийдвэрлэх бөгөөд өмчлөгч нь эдэлбэр газартайгаа холбогдох асуудлыг газрын тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

4. Уурхайн эдэлбэрийг хүлээлгэн өгөхдөө энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

**49 дүгээр зүйл. Уурхайн эдэлбэрийг нөхөн сэргээх**

1. Түрээслэгч уурхайн эдэлбэр, түүний хэсгийн ашиглалтыг бүрмөсөн хаах тухайгаа төлөвлөсөн хугацаанаасаа нэг жилийн өмнө тусгай зөвшөөрөл олгосон байгууллага болон түрээслүүлэгчид бичгээр мэдэгдэж, ашиглалт, нэмэлт хайгуулын явцад уг талбайд гарсан аливаа эвдрэлийг арилгах, аюул осолгүй болгох, үхмалыг дарж, тэгшлэх буюу зөвшөөрөгдсөн өөр аргаар нөхөн сэргээх арга хэмжээг зохих төлөвлөгөөнд заасны дагуу авч, хүлээлгэн өгөхөд бэлтгэнэ.

2. Түрээслэгч нь уурхайн эдэлбэр дэх ухсан газар болон далд малталтын нөлөөгөөр үүсэж болзошгүй аюултай бүсийн зуулын ажлын гүйцэтгэлийн зурагт нарийвчлан тэмдэг-

лэж, гүйцэтгэлийн зураг болон түүний баталгаат хуулбарыг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад ирүүлнэ.

3. Түрээслэгч уурхайн эдэлбэрийг нөхөн сэргээх, аюулгүй болгохдоо тухайн хэсгийг тойруулан хааж хамгаалах бөгөөд орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлийг бүрэн тооцож уурхайн эдэлбэрийг эргүүлэн хүлээн авсан акт хүчин төгөлдөр болтол уул үүргээс чөлөөлөгдөхгүй.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Хайгуулын талбай, уурхайн эдэлбэр орчныг хамгаалах

**50 дугаар зүйл.** Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх

Тусгай зөвшөөрөл эзэмшигч (гүйцэтгэгч буюу түрээслэгч) ашигт малтмалын хайгуул хийх, орд ашиглахдаа хууль тогтоомж, гэрээ, төлөвлөгөөнд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, хайгуулын талбай, уурхайн эдэлбэр, түүний хөндөгдсөн орчныг нөхөн сэргээх, засан тохижуулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

**51 дүгээр зүйл.** Орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал хийх, олборлохдоо ухсан, малтсан зэргээр эвдсэн газрыг дарх, хөрс суулгах буюу өөр аргаар цаашид шингэж болохуйн засах тохижуулах, хайгуулын талбай, уурхайн эдэлбэр орчин (цаашид «орчин» гэх)-д үзүүлсэн бусад сөрөг нөлөө, аюул ослыг арилгах арга хэмжээ, түүний зардлыг тодорхойлсон иж бүрэн төлөвлөгөөг орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гэнэ.

2. Орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг тусгай зөвшөөрөл эзэмшигч боловсруулж байгаль, орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дүгнэлт гаргуулсан байвал зохино.

3. Эрх бүхий байгууллага нь орчныг хамгаалах арга хэмжээний дүгнэлтийг тусгай зөвшөөрөл олгох нэг үндэслэл болгоно.

4. Уул төлөвлөгөөний талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагын дүгнэлтийг эс зөвшөөрвөл үүссэн маргааныг хэрэгжүүлнэ:

**52 дугаар зүйл.** Орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн иргэн, хуулийн этгээд хайгуул хийх, орд ашиглах үйл ажиллагаанаас байгаль орчин, түүний дотор хүн амын эрүүл мэндэд үзүүлж болох сөрөг нөлөөг ашиглалтын явцад багасгах буюу арилгах арга хэмжээг тогтоосон норматив, стандартын дагуу бүрэн тодорхойлохыг орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ гэнэ.

2. Орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг ашигт малтмалын хайгуул хийх болон тухайн орд ашиглах зөвшөөрөл авахыг хүссэн иргэн буюу хуулийн этгээд зохих мэргэжлийн байгууллагаар хийлгэж байгаль, орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дүгнэлт гаргуулсан байвал зохино.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын явцад техник, технологийн үндсэн шийдлийг өөрчилсөн, хүчин чадлыг өргөтгөсөн тохиолдол бүрт орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг нэмж хийлгэнэ.

**53 дугаар зүйл.** Орчныг хамгаалах үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийн баталгаа болгож орчныг хамгаалах арга хэмжээний жил бүрийн төлөвлөгөөг зардлын 50-иас доошгүй хуьнтай тэнцэх мөнгийг тухайн сум, дүүргийн захиргааны байгууллагад барьцаалан шилжүүлнэ.

2. Сум, дүүргийн засаг захиргааны байгууллага нь барьцаалсан хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигч орчныг хамгаалах үүргээ биелүүлсэн хэмжээгээр буцаан олгох буюу үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол учирсан хохирлыг нөхөн төлүүлд, барьцаалсан хөрөнгийг улсын орлого болгоно.

3. Барьцаалсан мөнгөн хөрөнгийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар улсын орлого болгосон нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийг орчныг хамгаалах талаар хүлээсэн, уул хөрөнгөөр нөхөгдөөгүй үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар барьцаалсан хөрөнгийг хуримтлуулах, зарцуулах журмыг Засгийн газар батална.



## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Төрийн хяналт

**54 дүгээр зүйл.** Хайгуул хийх, орд ашиглах ажиллагаанд агаанд тавих төрийн хяналт

1. Хайгуул хийх, орд ашиглах үйл ажиллагаанд хууль хууль огтоомж, технологийн горимыг холбогдох этгээд хэрхэн хэрхэн нелүүлж байгаад геологи, уул уурхайн улсын хяналтын шалтын айгууллага, түүний байцаагч мэргэжлийн хяналт тавьж, тавьж, шалгалт хийнэ.

2. Геологи, уул уурхайн хяналтын байгууллага, түүний түүний янц байцаагчид нь Монгол Улсын Газрын хэвлийн тухай тухай уульд заасан эрх хэмжээнээс гадна дараахь бүрэн эрхийг эрхийг эрэгжүүлнэ;

1) ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн биелэлт, нелэлт, устай зөвшөөрөл олголт, хайгуулын ажил гүйцэтгэх болон болон уурхайн эзэлбэрийг түрээслэх гэрээний биелэлтийг хянан хянан шалгах;

2) хайгуул, уурхайн ажилд зайлшгүй шаардвал зохих, зохих ул-техникийн болон уурхайн ажлын технологийн горим горим огтоосон стандарт, техникийн нөхцөл болон энэ хуульд хуульд заасан төлөвлөгөөг хэрхэн биелүүлж байгааг шалгах. х.

**55 дугаар зүйл.** Маргааныг хянан шийдвэрлэх

1. Тусгай зөвшөөрөл олгогч, эзэмшигчийн болон гэрээч гэрээний талуудын хооронд гарсан савалын зөрөөтэй асуудлыг уудлыг уульд өөрөөр заагаагүй бол талууд зөвлөлдөн шийдвэрлэнэ. ээрлэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөвлөлдөн шийт- шийд- ээрлэж чадаагүй маргааныг шүүх шийдвэрлэнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

**56 дугаар зүйл.** Хууль тогтоомж зөрчсөнд хүдээлгэх хариуцлага

1. Ашигт малтмалын тухай хууль тогтоомж зөрчсөн ирчсөн ир- гэн, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүдээлгэхээр- лгэхээр- гүй бол геологи, уул уурхайн болон байгаль орчны хяналт хянал- тын улсын байцаагч зөрчлийн шийж байдлыг харгалзан гаргалзан гэм буруутай этгээдэд дор дурдсан шийтгэл ногдуулна: айна;

1) 1) хайгуулын явцад ашигт малтмал олборлосон, борлуу сан, сан, тусгай зөвшөөрөлгүйгээр хайгуул хийсэн, орд ашигд сан ( сан бол хууль бусаар олсон орлого буюу бүтээгдэхүүн хурал хурааж, гэм буруутай этгээдийг 25000 хүртэл төгрөгөө торго торгох;

2) 2) ашигт малтмалын хайгуул, орд ашиглалтын тайл мэдээ мэдээг цаг тухайд гаргаж өгөөгүй, худал мэдээлж тайлагн сан ( сан бол 15000 хүртэл төгрөгөөр торгох;

3) 3) хайгуулын талбайгаас авсан дээж сорьц, анхдагч м терминалыг санаатайгаар устгасан бол 25000 хүртэл төгрөгөө торгох;

4) 4) хайгуул, олборлолтын явцад илэрсэн зөрчлийг ари гуулаа гуулахаар эрх бүхий байгууллагаас тавьсан хууль ёсн шаардлагыг биелүүлээгүй бол 8000 хүртэл төгрөгөөр торго

5) 5) орчныг хамгаалах, хайгуулын талбай, уурхайн эдэ бэрийн бэрийн орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй, хүмүүсн эрүүл эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол, учруулах байдлаар ха гуул х гуул хийсэн, ашиглалт явуулсан бол учруулсан хохирлы нөхөн нөхөн төлүүлж, 10000 хүртэл төгрөгөөр торгох;

6) 6) иргэн, хуулийн этгээдээс ашигт малтмалын хуу тогтоо тогтоомжоор олгогдсон эрхээ эдлэхэд санаатайгаар са учруул учруулсан бол 25000 хүртэл төгрөгөөр торгох;

7) 7) хууль тогтоомжид заасан бусад шийтгэл.

2.) 2. Хяналт шалгалт явуулж байгаа эрх бүхий ажилтан үүргээ үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад учруулсан гэм бу руутай руутай этгээдэд шүүх 15000 хүртэл төгрөгөөр торгох ший гэл ноггэл ногдуулна.

57 д 57 дугаар зүйл. Хууль хүчин төгмөдөр болох  
Энэ Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэ дагаж дагаж мөрдөнө.

Мө Монгол Улсын Их Хурлын

дар дарга

Н. БАГАБАНД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 9 дүгээр  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. «Байгалийн байдлаар байгаа цуц алт, бусад үнэт металлыг улсад тушаах онцгой журмын тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1986 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 45 дугаар зарлигийг Ашигт малтмалын тухай хуулийг хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын  
дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар

Дугаар 69

Улаанбаатар

сарыг 3-ны өдөр

хот

### АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улс орны эдийн засаг, ийгмийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай Засгийн газрын илтгэлийг хэлэлцээд Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

1. Ж. Гомбожав — Улсын Их Хурлын дэд дарга

**Ажлын хэсгийн гишүүд:**

2. М. Мэндбилэг — Байгаль орчныг хамгаалах байнгын хорооны дарга
3. Б. Дэмбэрэл — Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хорооны дарга
4. Д. Лүндээжамнан — Гадаад бодлого, эюулгүй байдлын байнгын хорооны дарга
5. А. Базархүү — Төсөв, санхүү, мөнгө, дээлийн бодлогын байнгын хорооны дарга
6. А. Болат — Хурал, захиргааны байнгын хорооны дарга
7. Ц. Нямдорж — Хууль зүйн байнгын хорооны дарга
8. Д. Мөнхөө — Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, ийгэм хангамжийн байнгын хорооны дарга
9. Н. Баиртсайхан — Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга

10. Г. Цэдэндагва — Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны дарга
11. Л. Энзбиш — Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын шадар сайд

Дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН  
ТОГТООЛ**

1994 оны 10 дугаар

Дугаар 70

Улаанбаатар

сарын 3-ны өдөр

хот

**БАЙНГЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

«Улсын Бага Хурлын 36 дугаар тогтоолын биелэлтийг хэлэлцсэн тухай» Улсын Их Хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан хугацаанд тавигдаагүй тул хоригийг хэлэлцэх хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

Дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1994 оны 10 дугаар

Дугаар 71

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

хот

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН  
ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

В. Алзахгүйг Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцох тухай Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий Хорооны 1994 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 5 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Вандангийн Алзахгүйн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

Дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1994 оны 9 дүгээр

Дугаар 72

Улаанбаатар

сарын 26-ны өдөр

хот

**ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Үнэт цаасны тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасгай:

1) үнэт цаасны хоёрдогч зах зээл бий болгохтой холбогдсон бэлтгэл ажлыг энэ онд багтаан тусгай мөтөлбөрийн дагуу хийх;

2) үйл ажиллагаагаа нэгэнт явуулж бэйгээ хөрөнгийн бирж болон брокерийн пүүсүүдийг Үнэт цаасны тухай хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулах асуудлыг 1994 оны II дүгээр сарын I-ний дотор багтаан шийдвэрлэх;

3) Үнэт цаасны хорооны дүрмийн төслийг 1994 оны II дүгээр сарын I-ний дотор өргөн мэдүүлэх.

2. Үнэт цаасны хорооны дарга, гишүүдэд томилуулах хүмүүсийн талаарх саналаа 1994 оны II дүгээр сарын I-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Улсын Их Хурлын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо (Г. Цэдэндагва)-нд болон Монгол Улсын Ерөнхий сайд П. Жарай, Сангийн сайд Д. Даваасамбуу, Монгол-банкны Ерөнхийлөгч Д. Моломжамц нарт тус тус даалгасгай.

Дарга

Н. БАГАБАНДИ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар

Дугаар 73

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

хот

### УЛС ОРНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦАМШДЫН ЗОРИЛТЫН ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ИЛТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

Улс орны эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, цамшдын зорилтын тухай Засгийн газрын илтгэлийг Монгол Улсын Их Хурал хэлэлцээд тэмдэглэх нь:

Төрийн байгууллагын шинэ тогтолцоог төлөвшүүлэх, улс орны эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх өр-

чин нөхцөлд, эрх зүйн үндсийг бүрдүүлэх алхам хийгдэж, эдийн засагт өмчийн олоц хэлбэр бий болж, чөлөөт үнэ, тарифын тогтолцоонд шилжих зорилт хэрэгжиж байна. Эдийн засаг жолоодлогогүй инфляциас сэргийлэгдэж, гадаад өр төлбөр хөнгөрч, улсын валютын ба нэг чухал материалын нөөц бий болж байна.

Улс орны эдийн засгийн амьдралд нааштай эхлэл гарч байгаа боловч Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал хүнд хэвээр байна.

Нийгмийн хэрэглээ, хуримтлалын харьцааг оновчтой өөрчлөх, үйлдвэрлэлийг сэргээх, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх зорилт шаардлагын түвшинд хэрэгжихгүй байна.

Эдийн засгийн макро болон микро түвшинд хөрөнгө, санхүүгийн тэншвэржилт алдагдсан хэвээр байна. Санхүү, мөнгө, зээлийн механизмыг үйлдвэрлэлийн өсөлтийг хангах зорилгод үр өгөөжтэй ашиглаж чадахгүй байна.

Ажлаагүйчүүдийн тоо өсч, хүн амын ядуурал ихэсч, санхүүгийн гачигдлын улмаас нийгмийн хүрээний арга хэмжээ бүрэн хэрэгжихүй байна.

Хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг Засгийн газар хангалтгүй зохион байгуулж, энэ талаар Улсын Их Хурлаас тавих хяналт сул байна. Нийгэмд сахимга, дэг журам суларч, төрийн байгууллагын ажилтан, албан тушаалтны хариуцлагагүй байдал газар авах хандлагатай байна.

Улс орны эдийн засаг, нийгмийн өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, Засгийн газрын үйл ажиллагааг цаашид эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) «Монгол Улсын үндэсний эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал», «Монгол Улсын экологийн хөтөлбөр»-ийг төсөл боловсруулж Улсын Их Хурлын 1995 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барих;

2) шинэчлэх ухаан технологийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулж энэ онд багтаан Улсын Их Хуралд өргөн барих;

3) зах зээлийн дэд бүтэц Солон микро эдийн засгийн зохицуулалтын механизмыг туунтай дүгнэрүүлж, аж ахуй хоорондын, ялангуяа хөдөө аж ахуй-аж үйлдвэр, үйлдвэр-



лэгч хэрэглэгч хоорондын зохицой харилцааг бүрдүүлэх;

4) үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор түүхий эд, сэлбэг худалдаж авахад зориулсан зээлийн тусгай сан бий болгох, үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ борлуулах ЗИХ зээл олоход нь тус дөхөм үзүүлэх;

5) үндэсний үйлдвэрлэлийг сэргээх талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулж энэ оны II дүгээр сард багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

6) гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтыг хянан үзэж, цаашид зээл тусламж авч ашиглах улсын нэгдсэн бодлого боловсруулж энэ онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

7) үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт идэвхжих тааламжтай орчин бүрдүүлэх зорилгоор шаардлагатай гэж үзвэл гааль, татварын бодлогод өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулж энэ онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах тарифын бус зохицуулалтын механизмыг ашиглах талаар хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээгээ хэрэгжүүлэх үр нөлөөг дээшлүүлэх;

8) эрчим хүчний үйлдвэрүүдийн өр авлагын асуудлыг шийдвэрлэж, тэдгээрийн найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлж дүнг энэ онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

9) аймаг, сум, суурин газрын эрчим хүчний сүлжээг төвлөрсөн эх үүсвэрт холбох, усан станц байгуулах, нар салдвар ажилладаг жижиг өврийн цахилгаан үүсгүүрээр хөдөөг хангахад зарцуулах хөрөнгийн гадаад, дотоод эх үүсвэрийг 1995 оноос эхлэн жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

10) хөдөөгийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй хувийн өмчтөнтэй харилцах харилцааны зарчмыг тогтоох асуудлыг боловсруулж энэ онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

11) хөдөө аж ахуйн үйлдвэрлэл тогтворжихгүй байгаад дүгнэлт хийж бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг урамшуулах механизмыг салбарын өвөрмөц онцлогийг харгалзан буй болгож төлөвшүүлэх;

12) дотоодын гурилын үйлдвэрлэлийг тогтвортой болгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор «Улаан буудай» хөтөлбөр боловсруулж эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглагдах хөрөн-

гийн тусгай сан байгуулах асуудлыг шийдвэрлэж 1995 оноос эхлэн хэрэгжүүлэх;

13) төрийн удирдлагын бүх шатны байгууллага, тэдгээрийн аппаратын ажлын уялдаа холбоог сайжруулж, цомхон, чадварлаг бүтцийг бүрдүүлж, захиргааны шууд ба шууд бус зардлыг хэмнэх зохион байгуулалт хийж, энэ үндсэн дээр чөлөөлөгдөх хөрөнгөөр төрийн байгууллагад ажиллагсдын цалингийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг боловсруулж энэ оны II дүгээр сард Улсын Их Хуралд оруулах;

14) боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүл мэндийн байгууллагуудыг зах зээлийн харилцаанд үе шаттайгаар шинжжүүлэх асуудлыг боловсруулж, эдгээр салбаруудын санхүүжилтийн төсвийн болон бусад эх үүсвэрийн зохицой харьцааг тогтоох, зарцуулалт, ашиглалтыг сайжруулах үндсэн дээр чөлөөлөгдөх хөрөнгийг тухайн салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулахад ашиглах, хувийн эмнэлэг, сургууль, соёлын байгууллагыг дэмжих асуудлыг боловсруулж шийдвэрлэх;

15) хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн актуудыг өнөөгийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд тавих төрийн хяналтыг сайжруулах;

16) хүн амаас авч байгад төрөл бүрийн хураамж, төлбөрүүд хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан үлэж зөрчилгүй болгож, дүнг энэ онд багтаан Улсын Их Хуралд танилцуулах;

17) хуульд зааснаар олгогдсон байвал зохих цалин, тэтгэвэр, тэтгэмжийг энэ онд багтаан бүрэн олгох, тэдгээрийг тогтоосон хугацаанд нь олгож байх нөхцөлийг хангах;

18) хөдөөгийн эхчүүдийн төрөхийн өмнөх байрны үйл ажиллагааг сэргээх асуудлыг судлан шийдвэрлэх, эрүүл ахуй, халдвар судлалын байгууллагуудын материаллаг бааз, лабораторийн чадавхийг дээшлүүлэх;

19) ажилгүйдлийг багасгах, ядуурамыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төв, орон нутгийн байгууллагын гүйцэтгэл үүргийг тодруулж, нооц хүчийг нь дайчлах;

20) нийгэмд сахилга, дэг журмыг бэхжүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг сайжруулах, төрийн удирдлагын бүх шатны байгууллагын боловсон хүчний мэдлэг, боловсрол, ажлын харвицлагыг дээшлүүлэх, шүүх, прокурор болон хуулийн бусад байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаанд хийх шинэчлэлийг гүнзгий-

рүүдэл, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэх, болон оон хүний хангамжийг сайжруулах;

21) Засгийн газрын гишүүдийн ажлын хариуцагчийн талаар нийтлэн хэлэлцэж, шаардлагатай гэж үзвэл санхүүгийн Улсын Их Хуралд оруулах;

22) Улс, орон нутгийн төсвийн зарцуулалт, төрийн өмчийн бүрдэлт, ашиглалтад тавих хяналтыг чангатгаж, төрийн өмч хөрөнгийг үрэн тарах хийх, бусдад шилжүүлэх, хандив өргөх, дайчлага, цайчлага зэргээр үр ашгүй зарцуулах, үндэслэлгүйгээр цалин хөлсөө нэмэгдүүлэх, шан хярамж хүртээж байгаа зохисгүй үзэгдлийг таслан зогсоож, холбогдох албан тушаалтантай хариуцлага тооцож, олон нийтэд ил тод мэдээлж байх;

23) Улсын Их Хурлын Байнгын хороодын гаргасан санхүүгийн, дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүдээс санаал шуумжлалдыг нэг бүрчлэн судалж, тэдгээрийн дагуу авбал зохих арга хэмжээг авч дунд Улсын Их Хуралд улирал тутам мэдээлэх.

2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар, Монголбанкинд даалгасугай:

1) зээл, хүүгийн уян хатан механизмээр дамжуулан үйлдвэрлэлийг дэмжих зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

2) гадаад орны зээлээр болон дотоодын хөрөнгө оруулалтаар 1992 оноос өмнө баригдсан, баригдаж эхэлсэн үйлдвэр, аж ахуйн газрын өнөөг хүртэл төлөгдөөгүй зээлийн өрийг судалж энэ онд багтаан шийдвэрлэх.

3. Төрийн хяналтын тухай хууль, Компаний тухай хууль, Хоршооллын тухай хуулийн төсөл, Өмч хувьчлалын ажлын ивч, өнөөгийн байдал, цаашдын зорилтын тухай сонголыг энэ онд багтаан Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэлийг бүрэн хангахыг Улсын Их Хурлын зохих Байнгын хороодод даалгасугай.

4. 1994 оны улсын төвлөрсөн төсвийн зарцуулалт, хувьчлалтын байдлыг Сангийн яаманд шалгах ажлыг зохих байгуулж 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл хэлэлцэхийн өмнө Улсын Их Хуралд танилцууламж Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

5. Тус тусын эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зохих байгуулах, хянан шалгах ажлын үр нөлөөг дэлгэрүүлж, энэ тогтоолын холбогдох заалтын биелэлтэд хяналт

тавьж ажиглахыг Улсын Их Хурлын Байнгын хороодод даалгасугай.

6. Энэ тогтсолын биеэлэлтэд хяналт тавьж дүнг нэгтгэн Улсын Их Хурлын 1994 оны намрын болон 1995 оны хаврын чуулганд тус тус танилцуулахыг Улсын Их Хурлын дэд дарга (Ж. Гомбожав)-д даалгасугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛЫН ТОГТООЛ

1994 оны 10 дугаар

Дугаар 74

Улсынбаатар

сарын 13-ны өдөр

хот

#### ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГИЙН ТУХАЙ

«Байнгын хорооны дүгнэлтийн тухай» Монгол Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 70 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

1994 оны 9 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Ашигт малтмалын тухай хууль батлагдсантай холбогдуу-  
лан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Ул-  
сын Засгийн газарт даалгасугай:

1) дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газ-  
рын шийдвэрийг энэ хуульд нийцүүлэх, уг хуульд заасан  
дүрэм, зааврыг 1994 оны 12 дугаар сард багтаац баталж  
гаргах

2) энэ хууль хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд  
улсын хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг тухайн  
уурхайн эдэлбэрийн үнэлгээнд эвч тусгахын тулд үнийн  
мэсшэб, валютын ханшны өөрчлөлтийн дагуу шинэчлэн  
тогтоох.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1994 оны 7 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар  
хот

Н. ДОЛГОРСҮРЭНГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ  
УЛААН ТУГИЙН ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Хөдөөгийн эмнэлгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, мэс заслын яаралтай тусламжийг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн эмнэлгийн үйлчилгээг шуурхай, оновчтой зохион байгуулах, залуу эмч нарыг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн төвийн мэс заслын их эмч Намдагийн Долгосүрэнг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИВЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1994 оны 7 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар  
хот

С. СУГАРЫГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР  
ШАГНАХ ТУХАЙ

Ган сийлбэрчин, дарханаар олон жил ажиллахдаа үйлдвэрлэлд шинэ бүтээгдэхүүний хэв зохион бүтээж чанар, үзэмжийг дээшлүүлэн ажлын тодорхой амжилт, үр бүтээл гаргаж, Монгол Улсын төрийн тамга, одон, медалийн ган хэвийг мэргэжлийн өндөр түвшинд урлан бүтээснийг үнэлж

«Монгол хаж» хувиараа эрхлэх аж ахуйн эзэн Сономшарын Сугарыг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ

1994 оны 7 дугаар

Улаанбаатар

сарын 19-ний өдөр

Дугаар 87

ХОГ

С. БАРААНУСАНИГ «АЛТАН ГАДАС»  
ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Монголын радиогийн сурвалжлагчаар хөдөө нутагт тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллан «Малчин», «Таван эрдэнэ» нэвтрүүлгийг санаачлахад оролцож, зах зээлийн шилжилтийн үеийн чухал сэдвүүдээр хэдэн арван нэвтрүүлэг, радио найрууллыг уран сайхны өндөр түвшинд туурвин бэлтгэж сонсогчдыг шинэ соргог мэдээллээр хангах, олон ургальч үзлийг төлөвшүүлэх талаар нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын радиогийн Өвөрхангай аймагт суугаа сурвалжлагч Самбуугийн Бараанасанг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар

Дугаар 88

Улаанбаатар

сарын 19-ний өдөр

хот

**С. МӨНХДАЛАЙГ «АЛТАН ГАДАС»  
ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ**

Сонин хэвлэлийн газарт үр бүтээлтэй ажиллаж хариуцсан сонинхоо нийтлэлийн бодлогыг цаг үеийн шаардлагад зохицуулан олон түмнийг шинэ соргог, үнэн зөв мэдээллээр шуурхай хангах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өвөрхангай аймгийн «Хөдөлмөрийн төлөө» сонин хариуцлагатай эрхлэгч Сангидоржийн Мөнхдалайг «Алтан гадас» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар

Дугаар 89

Улаанбаатар

сарын 19-ний өдөр

хот

**ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ОДОН, МЕДАЛИАР  
ШАГНАХ ТУХАЙ**

Эрүүд мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**АЛТАН ГАДАС ОДОНГООР:**

- |  |  |
|--|--|
| 1. Баян-Өлгий аймгийн<br>Булган сумын хүн эм-<br>нэлгийн эрхлэгч, их эмч<br>Жумбайн Жүнс | Булган сумын хөдөлмөрчдийн<br>хүн эмнэлгийн үйлчилгээг<br>оновчтой зохион байгуулж<br>ажилласнаар сүүлийн 5 жилд |
|--|--|



2. Мөн аймгийн Цэнгэл  
сумын хүний бага эмч  
Донидын Шагдар

0—3 насны хүүхэд, эхийн эндэгдэлийг 2—3 дахин бууруулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж

Бригадын эмчээр олон жил үр бүтээлтэй ажиллаж урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийж, хүн эмнэлгийн яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлснээр эх, хүүхдийн эндэгдэл, халдварт өвчний гаралтыг эрс бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсныг үнэлж

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛНАР:

Мөн аймгийн Амаржих  
газрын их эмч Жанабилин  
Төрөхан

Жирэмсэн эмэгтэйчүүдийг эмчийн хяналтад бүрэн хамруулж урьдчилан сэргийлэх үзлэг тогтмол хийж хөдөөгийн эхчүүдийн дуудлагаар анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлснээр төрөлтийн хүндрэлийг эрс бууруулахад идэвхи зүтгэл гарган ажиллаж байгааг үнэлж

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЛЭГЧИЙН  
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар

Дугаар 90

Улаанбаатар

сарны 19-ний өдөр

ХОТ

**Ф. БЕРЖАНЫГ ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ  
МЕДАЛИАР ШАГНАХ ТУХЛАЙ**

Соёл урлагийн салбарт үр бүтээлтэй ажиллаж, олон түмний талархал хүлээсэн хөгжмийн олон бүтээл туурвиж казах үндэсний дуу, хөгжмийн урын санг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын хөгжмийн удирдаач Файзолдагийн Бержаныг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнасагтай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЛЭГЧИЙН  
ЗАРЛИГ**

1994 оны 7 дугаар

Дугаар 93

Улаанбаатар

сарны 20-ны өдөр

ХОТ

**ЗАРИМ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ,  
ШҮҮГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ  
ЧӨЛӨӨЛӨХ ТУХЛАЙ**

Шүүхийн ерөнхий эрхлэлийн саналыг үндэслэн Түгжийн Дэлгэрсүрэнг Эрдэнэт хот дахь дааж хээлдах шатны шүүхийн ерөнхий шүүгчийн, Дашинмын Мөнхбаярыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Баязрагчийн Батбаярыг Архангай аймгийн шүүхийн гишүүний, Дарамсэдийн Гүрсэдийг мөн аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Дэлчигийн Энхцэцэгийг Говь-Алтай аймгийн хэсгийн ардын

шүүхийн шүүгчийн, Гаажидын Дэлгэрбямбыг Өмнөговь аймгийн шүүхийн гишүүний албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРАНГ

1994 оны 7 дугаар

Дугаар 94

Улаанбаатар

сарны 20-ны өдөр

хот

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙГ  
ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Байсрагчийн Батбаярыг Архангай аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Минжүүрийн Жаргалсайханыг мөн аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Дансрангийн Бавууг Булган аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Пунцагдоржийн Оюунцэцэгийг мөн аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Данзангийн Сарантуга, Дэмчигийн Энхцэнэг, Жадамбын Наранцацрал, Чойжилын Алтанцоож нарыг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Жигмэддоржийн Долгормааг Дориод аймаг дахь сумын шүүхийн шүүгчээр, Лхамсүрэнгийн Ганчимэг, Зундуйн Энхцэнэг нарыг мөн аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Жигдэнгийн Баттогтохыг Зөвхан аймаг дахь сум дундын I шүүхийн шүүгчээр, Цэнд-Аюушийн Батхүүг мөн аймаг дахь сум дундын II шүүхийн шүүгчээр, Гаажидын Дэлгэрбямбыг Өмнөговь аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Гунаагийн Сүрэн, Шагжаагийн Дарьсүрэн нарыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Цэрэндоржийн Үнзибатыг Төв аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Бальдирын Болд, Дорангийн Лувсандорж нарыг мөн аймаг дахь сум дундын I шүүхийн шүүгчээр,

Базаргарьдын Сүхгомбо, Агвааны Батбаяр нарыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Банзрагчийн Оюунцэцэг, Бавуугийн Түмэндэмбэрэл, Ендонгийн Бямбацэрэн нарыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Жалцангийн Цэнгэлийг Нийслэлийн Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН  
ХУУЛИЙН ЦЭЦИЙН  
ТОГТООЛ**

1994 оны 11 дүгээр

Дугаар 02

Улаанбаатар

сарын 9-ний өдөр

хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г. Совд даргалж, гишүүн Г. Нямдоо, Л. Баасан, Ц. Цолмон, Н. Жанцан, С. Жанцан, Д. Чилхаажав, Ж. Бямбаа, Ч. Энхбаатар нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанаар «Шүүх байгуулах тухай Монгол Улсын 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн 2 дугаар зүйлийн гурав дахь хэсгийн 1, 3, 5, 7 дугаар заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудтай харилцаж байна гэж Улаанбаатар хотын Баянгол дүүргийн иргэн Ж. Баярсайханы гаргасан гомдолтой маргааныг эцэслэн хянац хэлэлцэв.

Цэцийн хуралдаанд маргагч талуудыг төлөөлөн Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Нямдорж, өргөдөл гаргагч иргэн Ж. Баярсайхан нар оролцов.

Монгол Улсын иргэд Жамбалын Баярсайхан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгүүдэд «шүүхийн үндсэн тогтолцоо нь Монгол Улсын Дээд шүүх, аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүдээс бүрдэнэ» гэж заасан. Гэтэл Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 14-ний хуулиар нийслэлд 12 дүүрэг буюу захиргааны нэгж байхад 8 дүүргийн шүүх байгуулж 4-ийг нь дүүрэг дундын (Хан-Уул-Туул дүүргийн, Баянзүрх-Гачуурт дүүргийн, Сонгинохайрхан-Жаргалант дүүргийн, Багануур-Багахангай дүүргийн) болгон байгуулжээ. Эдгээр шүүхүүдийн тамга, тэмдэг, хаяг, албан бичгийн маягт нь дүүрэг дундын хэлбэрээр хийгджээ. Эдгээр байдалуудаас үндэслэн үзэхэд Шүүх байгуулах тухай Монгол Улсын 1993 оны хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байгаа тул асуудлыг хинэн шийдвэрлэж өгөхийг хүсье гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа гаргасан 05 тоот дүг-

нэлтэндээ: Шүүх байгуулах тухай Монгол Улсын 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуулийн 2 дугаар зүйлийн гурав дахь хэсгийн «Багануур, Багахангай дүүргийн шүүх, Баянзүрх-Гачуурт дүүргийн шүүх, Сонгинохайрхан-Жаргалант дүүргийн шүүх, Хан-Уул-Туул дүүргийн шүүх» гэсэн 1, 3, 5, 7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг авч хэлэлцээд гаргасан Монгол Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 23-ны 52 дугаар тогтоолд: Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дэчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 1994 оны 7 дугаар сарын 18-ны 10 тоот тогтоолоор иргэн Ж. Баярсайханы гомдол бүхий шүүх байгуулах тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эрх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар эцэслэн шийдвэрлүүлэхээр шилжүүлжээ.

Цэцийн хуралдаанд оролцож иргэн Ж. Баярсайхан тайлбарлахдаа: Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал аваагүй атлаа 1994 оны 7 дугаар сарын 8-нд Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулж дүүргийн шүүхийг дугаарлах зохицуулалт буй болгожээ. Ер нь цэцийн дүгнэлтийг аваагүй нь:

1. Орон тоо, төсөв хэмнэх

2. Нийслэлд дүүргүүдийг байгуулахдаа хүн ам, нутаг дэвсгэрийн байршилг харгалзаагүй гэсэнтэй холбоотой байна. Ерөнхийлөгч П. Очирбат хүний эрхийг хамгаалах болон шүүхийн ажилд төсөв зарцуулахад гар татаж болохгүй гэснийг Улсын Их Хурал анхаарсангүй, Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны тогтоол мөн чанартаа Үндсэн хуулийг зөрчсөн бөгөөд энэ нь: 1. Засаг захиргааны нэгж болох дүүргүүд дунд шүүх ажиллах мөн чанар нь хэвээр байгаа. 2. Үндсэн хуулийн заалтаар «дүүргийн шүүх» гэсэн агуулга байгаагаар тайлбарлагдана.

Иймд Улсын Их Хурлаас 1993 оны 6 дугаар сарын 14-нд гаргасан шүүх байгуулах тухай хууль, мөн хуульд өөрчлөлт оруулах 1994 оны 7 дугаар сарын 8-ны хуулиуд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг

зөрчиж байгааг хянан үзэж зохих шийдвэр гаргахыг хүсье гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Нямдорж хуралдаанд оролцож тайлбарлахдаа: Шүүх байгуулах нэгэн үндэслэл бол тойргийн зарчим болно. Энэ зарчмын дагуу Улсын Их Хурал шүүх байгуулах хуульд өөрчлөлт оруулан нийслэлийн дүүргийн шүүхүүдийг тойргийн системээр байгуулсан.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэдэлцэж байх үед цэцийн хуралдаан даргалсан Л. Баасан Улаанбаатар хотод шүүхийн тойргоор байгуулах тухай үзэл ирвсэн. Энэ бол шүүх байгуулах асуудлаар Улсын Их Хурлын үзэл бодолтой нийцсэн үйл ажиллагаа мөн. Ниймээс цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй. Шүүх байгуулах тухай хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурлаас баталсан хуулиуд нь Үндсэн хуультай зөрчилдөөгүй байна гэжээ.

#### Хяцавал:

1. Шүүх байгуулах тухай Монгол Улсын 1993 оны хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 05 тоот дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэсэн Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 23-ны 52 дугаар тогтоол үндэслэлгүй байх тул хүчингүй болгох шаардлагатай байна.

2. Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хууль Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай зөрчсөн эсэх асуудлаар цэцийн хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёрын санал аваагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол нь гармагцаа хүчин төгөлдөр болохыг  
рдеугтай.

Далга  
гшүүд

Г. СОВД  
Г. НИМДОО  
А. БААСАН  
Ц. ЦОЛМОН  
Н. ЖАНЦАН  
Ж. БЯМБАА  
С. ЖАНЦАН  
Д. ЧИАХЛААЖАВ  
Ч. ЭНХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 95

Улаанбаатар

сарын 11-ний өдөр

ХОТ

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТГАЙ ЗАРИМ  
ГАЗРЫН ХИЛИЙН ЦЭС, ХАМГААЛАЛТЫН  
ГОРИМЫГ БАТЛАХ ТУХАЙ

«Зарим газрыг тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай» Монгол Улсын Их Хурлын 1993 оны 83 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Говь гурвансайханы байгалийн үндэсний цогцолборт газрын хилийн цэс, хамгаалалтын горимыг 1, 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

2. Дархан цаазтай Богдохан уул, Говийн их дархан газрын хамгаалалтын горимыг 3, 4 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

3. Говь гурвансайханы байгалийн үндэсний цогцолборт газрын хамгаалалт, судалгаа шинжилгээний ажлыг Даланзадгад хот дахь Говийг хөгжүүлэх төслийн төвд харууцусугай.

4. Говь гурвансайханы байгалийн үндэсний цогцолборт газрын хамгаалалт, судалгааны ажлыг олон улсын байгууллагаас энэхүү нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөлтэй холбон авч үзэж, нутгийн иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудалтай уялдуулан хэрэгжүүлж байхыг Байгаль орчны яам (З. БАТЖАРГАЛ), Өмнөговь аймгийн Засаг дарга (Ц. МИЖИДДОРЖ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Байгаль орчны сайд

П. ЖАСРАЙ  
З. БАТЖАРГАЛ

Засгийн газрын 1994 оны 95 дугаар  
тогтоомын 1 дүгээр хэсгээс

## ГОВЬ ГУРВАНСАЙХАНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЦЭС

Ар цал уул (1826,0) түүнээс баруун хойш орших 1890,0, 2183,0 тоот өндөрлөг, Аглан уул (2596,0), 1870,0 тоот өндөрлөг, Улаантолгойн худаг, түүнээс баруун тийш орших Баруун-ус, түүнээс урагш орших Их цагаан дэрсний худаг, түүнээс зүүн урагш орших 1643,0 тоот өндөрлөг, түүнээс баруун урагш орших 1887,0 тоот өндөрлөг, түүнээс баруун хойш орших 2102,0 тоот өндөрлөг, түүнээс баруун урагш орших Үйлэн худаг, түүнээс баруун хойш орших Хөтөлбулаг, түүнээс баруун урагш орших Шинэ-ус, 1418,0 тоот өндөрлөг, Хайрхантолгой (1559,0), түүнээс баруун тийш орших 1379,0 тоот өндөрлөг, Зангат уул (1849,0), 1980,0, 1692,0, 1703,0, 1482,0, 1089,0, 1001,0 тоот өндөрлөгүүдээр дайран баруун тийш Өмнөговь, Баянхонгор аймгийн хилийн зааг хүрч, хойш эргэн уг хэлийг даган Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн хилийн уулзвар, тэндээс Өвөрхангай, Өмнөговь аймгийн хилийг дагаж Халзанхайрхан уул (1482,0), түүнээс зүүн урагш орших 1401,0, 1529,0, 1592,0 тоот өндөрлөгүүдийг дайран Булагтай уул (1591,0), Улаан эргийн худаг, Цагаантолгойн худаг, Нэгдэл дундын үйлдвэрийн амралтаас баруун болон баруун урагш орших нэргүй булгуудын эх, түүнээс зүүн тийш орших Сүүжвийн худаг, түүнээс зүүн урагш орших нэргүй булгийн эх, Үнэгт (1863,0), түүнээс баруун урагш орших Ар цал уул (1826,0).

Засгийн газрын 1994 оны 95 дугаар  
тогтоомын 2 дугаар хэсгээс

## ГОВЬ ГУРВАНСАЙХАНЫ БАЙГАЛИЙН ҮНДЭСНИЙ ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ГОРИМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Говь гуравансайханы байгалийн үндэсний цогцолборт газар (цаашид «цогцолборт газар» гэнэ)-ын нутаг дэвсгэр,

түүний байгалийн бүх төрлийн байлаг нь төрийн зохицуулалтад байна.

2. Цогцолборт газрын хамгаалалт болон бусад үйл ажиллагааг улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, энэ горимын дагуу Говийг хөгжүүлэх төслийн төв (шашид «төв» гэнэ) зохицуулна.

3. Төв нь дүрмийнхээ дагуу үйл ажиллагаа явуулж, цогцолборт газрын хамгаалалтад өмчийн бүх төрөлд хамаарах аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг идэвхтэй оролцуулах үүрэг хүлээнэ.

### ХОЕР. Цогцолборт газрын хамгаалалтын горим

4. Байгаль орчны нам Тусгай хамгаалалттай газрын дүрэмд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ цогцолборт газарт дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а) судалгаа шинжилгээний ажил явуулах журам, хөтөлбөрийг батлах, уг хөтөлбөрийн хүрээнд судалгаа шинжилгээний ажил явуулах эрдэм шинжилгээний байгууллага, гадаад орны болон олон улсын байгууллагад зөвшөөрөл олгох, тэдний гүйцэтгэсэн ажилд нь дүгнэлт өгөх, холбогдох тайлан материалыг авч нэгдсэн санд оруулах

б) цогцолборт газрын бүс тус бүрээс судалгаа шинжилгээний дээж, сорьц авах, хэмжилт хийх, мөн үйлчилгээний бүсээс судалгааны зориулалтаар ан амьтан барих, агнах, нутагшуулах болон сүргийн бүтцийг зохицуулах журмыг батлах

в) эрдэм шинжилгээний холбогдох байгууллагын боловсруулсан цогцолборт газрын ан амьтныг тоолох аргачлал, хугацаа, хөтөлбөрийг батлах

г) цогцолборт газарт байгалийн аялал жуулчлал явуулах журам, аялал жуулчлалын үед байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн хэмжээг баталж, аялал жуулчлалын зам, чиглэлийг тогтоох

д) цогцолборт газрын байгалийн баялгийг зохих хууль тогтоомжийн дагуу эдийн засгийн үнэлгээтэй болгож, байгалийн дагалт байлаг, ашигт ургамал, ан олзворын зүйлийг ашиглах журмыг батлах

е) аялагчид, зөвшөөрөл бүхий бусад хүмүүс түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа хийх зориулалтаар орон байр барих газрын байршлыг тогтоох, уг үйл ажиллагаа явуулах журмыг батлах

ж) цогцолборт газрын нутаг дэвсгэр дэх автомашины замын чиглэл, зогсоол бий болгох журмыг холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран баталж мөрдүүлэх

з) цогцолборт газрын нутаг дэвсгэр дэх төв, суурин газар (сум, багийн төв, амралт, сувиллын газар) болон шинээр барих аялал жуулчлал, амралт сувиллын газрын байршил, ерөнхий схем, төлөвлөгөөнд экологийн магадлан шинжилгээний дүгнэлт гаргаж холбогдох газруудтай хамтран батлах.

5. Төв нь дор дурдсан үйл ажиллагаа явуулана:

а) цогцолборт газрын нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, тусгай хамгаалалттай газрын дүрэм, горимын биелэлтийг хангах, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд энэ талаар шаардлага тавьж, гэм буруутай үйлдлийг нь таслан зогсоож, тэдэнд зохих журмын дагуу хариуцлага ногдуулах

б) зохих зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын холбогдох байгууллагатай гэрээ байгуулж судалгаа шинжилгээний болон туршилтын ажлаа хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх, дээж, сорьц авах, хэмжилт хийх, ан амьтан тоолох барих, агнах, хөрс ургамлыг нөхөн сэргээхэд тэдэнд туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах

в) аялал жуулчлалын бүсэд аяллын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, засч тохижуулах, түр буудаллах, өтгөлөх, ажиглалт, судалгаа хийх зориулалттай байрыг зохих журмын дагуу экологчид сөрөг нөлөө багатай арга хэмбэрээр барих, авлагчид, бусад хүмүүсийн эрүүд ахуйн нөхцөлийг хангах зам тавих, зогсоол бий болгох, түүнчлэн биеийн тамирын арга хэмжээ авах

г) үйлчилгээний бүсэд зохих журмын дагуу автомашины болон олон нийтийн бусад арга хэмжээ явуулах журмыг батлан гаргаж, газрыг нь тогтоож өгөх, тэдгээрийг холбогдох байгууллагатай хамтран тохижуулах

д) загасны өнг тарьж ургуулах, нөхөн сэргээх, биотехникийн бусад арга хэмжээ авах, ан амьтны тоо, сүргийн бүтцийг зохих журмын дагуу зохицуулах

е) үйлчилгээний бүсийн байгалийн дагалт баялаг, ашигт ургамал, ан олзворын зүйлийн нөөц, ашиглах эрэмбэ дарааг жил тутам тогтоож, тэдгээрийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зохих журмын дагуу ашиглуулах

ж) цогцолборт газрыг сурталчлахтай холбогдсон үрэн зураг зурах, зохиом, бусад бүтээл туурвих, дүрс, дуу авианы бичлэг хийх, гэрэл зураг авах, кино хийх аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүст зөвшөөрөл олгох, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж хяналт тавих

з) аялал жуулчлал, үйлчилгээний бүсэд ус задгайлах булаг шанд тохижуулах, ан амьтанд зориулан хужир шүү тавих, нөмөр хорго барих, биотехникийн бусад арга хэмжээ авах

и) цогцолборт газрын үйлчилгээний бүсэд удамжлалт аж ахуйг эрхлэн аж төрж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эрхэд хяналт тавьж зохицуулах

к) цогцолборт газрын нутаг дэвсгэрт оршиж буй төв, суурин газарт барих бариага байгууламжийг батлагдсан зураг төслийн дагуу байрлуулах, барьж байгуулахад нь хяналт тавих.

6. Цогцолборт газрын нутаг дэвсгэрт нутгийн захиргааны байгууллага «Төв»-тэй хамтран дор дурдсан асуудлыг зохицуулна:

а) нутгийн иргэдийн улэмжлалт аж ахуй эрхлэх газар нутгийг тогтоох

б) малын хашаа, саравч барих, худаг гаргах

в) өвс, тэжээл бээлтгэх, отор'нуудэл хийх газар нутгийг тогтоох

г) цогцолборт газрын хамгаалалтын горимыг мөрдүүлэхэд орон нутгийн байгууллага, иргэдийн хүчийг дохион байгуулж оролцуулах

д) уул, овоо талх болон зан үйлийн бусад ёслолыг газрын хөрс, ургамалд сөрөг нөлөөлөхгүйгээр явуулах

е) цогцолборт газрын нутаг дэвсгэрт орших төв, суурин газрыг батлагдсан зураг төслийн нь дагуу хөгжүүлэх, барих, орчныг бохирдлосоо хамгаалах.

7. Цогцолборт газарт судалгаа шинжилгээний ажил явуулахад дор дурдсан чиглэл баримтална:

а) хамгаалалтын бүсэд ус, хөрс, заган ой, ургамал, амьтны аймгийн болон байгалийн төрх байдла, тэдгээрийн хувьсал, өөрчлөлтийг экологид нь аливаа өөрчлөлт оруулахгүй арга хэлбэрээр ажиглах, шинжлэн судлах

б) аялал жуулчлалын бүсэд энэ зүйлийн «а»-д зааснаас гадна газар зүйн тогтон, ургамал, амьтны аймгийн зүйл,

Бүтцийг зохих журмын дагуу нарийвчлан судлах, энэ зориулалтаар уг бүсээс дээж сорьц авах, хэмжилт хийх

а) үйлчилгээний бүсэд энэ зүйлийн «а», «б»-д зааснаас гадна түүний төрх байдал, экологийн тэнцвэрт сөрөг нөлөөлөхгүйгээр бусад нарийвчилсан судалгааг зохих журмын дагуу хийх

г) цогцолборт газрын аялал жуулчлалын болон үйлчилгээний бүсэд судалгаа шинжилгээний ажил хийх явцад хөрс, ургамлыг гэмтээсэн аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр төрх байдлыг нь сэргээн тохижуулж Төвд хүлээлгэн өгнө.

8. Цогцолборт газрын хөрс, ургамлыг нөхөн сэргээхэд дараахь журмыг баримтална:

а) тусгайлан тогтоосон газарт ургамлыг нөхөн сэргээхдээ тухайн нутаг дэвсгэрт ургадаг ургамал, модны үр, тарьц хэрэглэх

б) ургамал ургаж цэцэглэх, ан амьтан үржин төлжихөөс бусад хугацаанд ан амьтны байршил, экологид сөрөг нөлөөлөхгүй байх арга, техник, технологийг ашиглаж хөрс, ургамлыг нөхөн сэргээх.

9. Цогцолборт газарт биотехникийн арга хэмжээ авах, байгалийн дагалт баялгийг ашиглахад дор дурдсан журмыг мөрдөнө:

а) ан амьтны тоо, сүргийн бүтцийг зохицуулан зааглах ажлыг тэдгээрийн үржиж төлжихөөс бусад хугацаанд хийх, түүнчлэн судалгаа шинжилгээний зорилгоор агнах, барихад байршилыг алдагдуулах, экологид сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх

б) ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэхтэй холбогдсон биотехникийн арга хэмжээ авахдаа уламжлалт арга, ердийн хэсэг гэх мэт байгаль орчинд сөрөг нөлөөгүй техник, технологийг ашиглах

в) зөвшөөрөгдсөн бүсээс байгалийн дагалт баялаг, шингт ургамлыг үр жимс нь боловсорч гүйцсэн буюу зориуд тогтоосон хугацаанд байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих журмын дагуу ашиглуулах.

10. Цогцолборт газарт автомашины зам тавих, засварлах, тээврийн хэрэгслийн зогсоол бий болгоход дор дурдсан чиглэл баримтала:

а) автомашины зам, зогсоолыг зөвхөн экологийн магадлан шинжилгээ хийсэн, батлагдсан зураг төслийн дагуу барьж, засварлах

б) авто зам тавих, засварлахад хэрэглэгдэх шороо, хайргыг зөвхөн тогтоосон цэгээс авах бөгөөд уг цэгийг ашиглаж дууссаны дараа ашиглагч нь дарж тэгшлэн Төнд хүлээлгэн өгдөг байх

в) авто зам тавих, засварлахад ашиглах техник, технологийг гүйцэтгэгч байгууллага Төвтэй урьдчилан тохиролцсон байх

г) авто зам тавих, засварлах ажлын явцад цогцолборт газрын зөвшөөрөгдсөнөөс бусад газарт зорчих, урьдчилан тохиролцоогүй газраас шороо, чулуу, хайрга авах, бусад хэлбэрээр байгалийн төрх байдлыг өөрчлөхийг хориглоно.

11. Автомашинны зогсоол бий болгох, байр сууц барих, биеийн тамирын болон олон нийтийн бусад арга хэмжээ явуулахдаа байгаль орчныг бохирдуулах, экологид сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх арга хэмжээ авсан байна.

12. Цогцолборт газрын нутаг дэвсгэрт аялал жуулчлал явуулахдаа дор дурдсан шаардлагыг биелүүлнэ:

а) байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлийн дагуу зохион байгуулах, зөвхөн зөвшөөрөгдсөн газарт машинаар илж, бусад хэсэгт ердийн хөсөг, илганаар аялал хийх

б) түр буудаллах, отоглох, ажиглаат, судалгаа хийх, байр сууц барихдаа экологид сөргөөр нөлөөлөхгүй, орчныг нь бохирдуулахгүй байх нөхцөлийг хангах

в) аялал жуулчлалыг зохион байгуулахдаа экологид сөргөөр нөлөөлөх аливаа үйл ажиллагаа явуулахдаа, аялын тогтоосон зам, чиглэл, түр буудаллах, отоглох газрыг дүр мэдэн өөрчлөхийг хориглох.

13. Аялал жуулчлал, үйлчилгээний бүсэд уул, овоо тахих, зан үйлийн уламжлалыг бусад ёслол үйлдэхдээ байгаль орчныг бохирдуулах, төрх байдалд нь сөргөөр нөлөөлөх, ан амьтны байрлалыг алдагдуулахдаа сэргийлэх бүх талин арга хэмжээ авсан байвал зохино.

14. Экологид сөрөг нөлөө бүхий аргаар мэрэгчид, хортон шавьж устгах, батлагдсан зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөг зөрчин төв, суурин газрыг өргөтгөх, шинээр барих, худаг, гол горхи, нуур цөөрмийг бохирдуулах, булаг шанд, голын гольдрилыг өөрчлөх, хаалт, хашлага барихыг хориглоно.

15. Цогцолборт газрын нутаг дэвсгэрт Улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, энэ горим, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээлд Төвийн эрх бү-

хий ажиглалтууд зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага ногдуулах буюу шүүхэд шилжүүлэн хэргийг шийдвэрлүүлнэ.

Засгийн газрын 1994 оны 95 дугаар  
тогтоолын 3 дугаар хэсрэлт

## ДАРХАН ЦААЗТАЙ БОГДХАН УУЛЫН ХАМГААЛАЛТТАЙ ГОРИМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Дархан цаазтай Богдхан уул (цаашид «дархан цаазтай газар» гэнэ)-ын нутаг дэвсгэр, байгалийн бүх төрлийн баялаг нь төрийн зохицуулалтад байна.

2. Дархан цаазтай газрын хамгаалалттай холбогдсон үйл ажиллагааг Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, энэ горим, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Дархан цаазтай газрын хамгаалалтын захиргаа зохицуулна.

3. Дархан цаазтай газрын хамгаалалтын захиргаа нь аймаг, нийслэлийн аль нэг байгууллагын дөвхөр харьяалалгүй байх бөгөөд дүрмийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, дархан цаазтай газрын хамгаалалтад өмчийн бүх төрөлд хамаарах аж ахуйн нэгж, байгуулага, иргэдийг идэвхтэй оролцуулах үүрэг хүлээнэ.

### ХОЕР. Хамгаалалтын горим

4. Байгаль орчны яам тусгай хамгаалалттай газрын дүрэмд заасан арга хэмжээг дархан цаазтай газарт хэрэгжүүлэхийн зэрэгцээгээр дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а) судалгаа шинжилгээний ажил явуулах журам, хөтөлбөрийг батлах, уг хөтөлбөрийн хүрээнд судалгаа шинжилгээний ажил явуулах эрдэм шинжилгээний байгууллага болон гадаад орон, олон улсын байгууллагад зөвшөөрөл олгох, тэдний гүйцэтгэсэн ажилд нь дүгнэлт өгөх, холбогдох тайлан материалыг авч, нэгдсэн санд оруулах

б) Дархан цаазтай газарт байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд экологийн магад-



лан шинжилгээ хийж, тэдгээрээс дархан цаазтай газрын хамгаалалтын талаар гүйцэтгэх үүргийг нь тогтоож өгөх, байгальд сөрөг нөлөөлж буй үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авах

в) нийслэлийн Солон Төв аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтарч дархан цаазтай газрыг хамгаалах асуудлаар шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтэд нь хиналт тавих

г) дархан цаазтай газрын бүс тус бүрээс ажиглалт, судалгаа шинжилгээний дээж, сорьц авах, хэмжилт хийх, энэ зориулалтаар ан амьтан барих, агнах, түүнчлэн ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах журмыг батлах

д) эрдэм шинжилгээний холбогдох байгууллаагаас боловруулсан дархан цаазтай газрын ан амьтныг тоолох аргачлал, хөтөлбөр, хугацаа, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журмыг батлах, түүнчлэн хөрс, ургамлыг нөхөн сэргээх газар, түүний хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоож өгөх

е) дархан цаазтай газарт аялал жуулчлал хийх журам, аялал жуулчлалын үед байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн хэмжээг баталж, аялал жуулчлалын зам, чиглэл, аялагчид, зөвшөөрөл бүхий бусад хүмүүс түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа хийхэд зориулан орон байр барих газрыг тогтоож өгөх.

5. Дархан цаазтай газрын хамгаалалтын захиргаанаас дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а) дархан цаазтай газарт байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, тусгай хамгаалаалттай газрын дүрэм, горимын биелэлтийг хангах, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд энэ талаар шаардлага тавьж, гэм буруутай үйлдлийг нь таслан зогсоох, тэдэнд зохих журмын дагуу хариуцлага ногдуулах

б) батлагдсан хөтөлбөрийн дагуу судалгаа шинжилгээний ажил явуулах, уг хөтөлбөрийн хүрээнд судалгаа шинжилгээний ажилд оролцох зөвшөөрөл авсан гадаад, дотоодын байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах

в) судалгаа шинжилгээний дээж сорьц авах, хэмжилт хийх, ан амьтан барих, агнах, хангах, тоо толгойг нь зохицуулах, хөрс, ургамал нөхөн сэргээх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах

г) дархан цаазтай газрыг сурталчлахтай холбогдсон уран зураг зурах, зохиол, бусад бүтээл туурвих, дүрс, дуу авианы бичлэг хийх, кино болон гэрэл зураг авах аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүст зөвшөөрөл олгож, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, хяналт тавих

д) дархан цаазтай газрын хамгаалалтын болон хязгаарлалтын бүсийн дотор булаг шанд тохижуулах, ан амьтанд зориулан хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир шүү тавих, нөмөр хорго барих зэрэг биотехникийн бусад арга хэмжээ авах

е) Дархан цаазтай газрын хамгаалалт, хязгаарлалтын бүсэд уул, овоо эргэх, тахих, мөргөл үйлдэх зэрэг зан үйлийн уламжлалт ёслол үйлдэх асуудлыг зохицуулах

ж) зөвшөөрөгдсөн бүсэд байгалийн аялал жуулчлал зохион байгуулах, тогтоосон газарт түр буудаллах, отоглох болон ажиглалт, судалгаа, шинжилгээнд зориулсан орон байр барих

з) гал түймэр гарч болзошгүй улирлын үед дархан цаазтай газарт зорчих хүний хөдөлгөөнийг хязгаарлах, аялал жуулчлалыг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авах

и) байгаль орчныг хамгаалах түүхэн уламжлал, шашны зан заншлыг сэргээх, дархан цаазтай газрын ач холбогдлыг сурталчлах

к) дархан цаазтай газрын ажилтан, байгаль хамгаалагчид албан үүргээ гүйцэтгэж байхдаа бие хамгаалах зориулалтаар ангийн буутай явах асуудлыг зохицуулах.

6. Дархан цаазтай газарт судалгаа шинжилгээний ажил явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

а) онцгой болон хамгаалалтын бүсийн байгалийн төрх байдал, ус, хөрс, ургамал, амьтны аймгийн онцлог, тэдгээрийн хувьсал өөрчлөлтийг байгальд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр ажиглах, шинжлэн судлах

б) хамгаалалтын бүсэд энэ зүйлийн «а»-д зааснаас гадна ойн сан, ургамал, амьтны аймгийн зүйл, бүтэц, өөрчлөлтийг судлах, дээж сорьц авах, хэмжилт хийхдээ тухайн ургамал, амьтны зүйл, бүтэцд сөрөг нөлөөгүй аргыг хэлбэрийг хэрэглэх

в) хязгаарлалтын бүсэд энэ зүйлийн «а», «б»-д зааснаас гадна бусад нарийвчилсан судалгаа явуулахдаа тухайн газрын байгалийн төрх байдлыг өөрчлөхгүй байх арга хэлбэрийг хэрэглэх

г) судалгаа шинжилгээний ажлын явцад газрын төрх байдлыг өөрчилж, хөрс, ургамлыг гэмтээвэл түүнийг нөхөн

сэргээх арга хэмжээ авч Дархан цаазтай газрын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөх.

7. Дархан цаазтай газарт ойн аж ахуйн болон биотехникийн арга хэмжээний ажил гүйцэтгэхдээ дор дурдсан журмыг баримтална:

а) ойн сэргэн ургалт, хөрс, ус хамгаалах, бусад ашигт чанарыг нь дээшлүүлэх зорилгоор судалгааны үндэслэлд тулгуурлан ойн арчилгаа цэвэрлэгээг мод, ургамал ургаж нэцэглэх, ан амьтан үржиж төллөхөөс бусад хугацаанд хийх

б) хязгаарлалтын бүсэд ой үржүүлэх, тарьц ургуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээхдээ ан амьтны байршил, байгальд сөрөг нөлөөгүй арга, технологи, техник болон багтаж хэрэгсэл ашиглах

в) ан амьтныг судалгаа шинжилгээний зорилдлаар барих, агнах, хашах, тсолох, сүргийн бүтцийг зохицуулахдаа тэдгээрийн байршлыг алдагдуулахгүй байх, экологид сөрөг нөлөөлөхөөс сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх

г) сүргийн бүтцийг зохицуулах, ан амьтныг барих ажлыг тэдгээрийн үржиж төллөхөөс бусад хугацаанд хийх

д) ойн дагалт баялаг, эм, хүнсний зориулалттай ургамлын нөөцийг тогтоосны үндсэн дээр үр жимс нь боловсорч гүйцсэн үед экологид сөрөг нөлөөгүйг арга технологиор зөвхөн ахуйн зорилдлаар иргэдэд зохих журмын дагуу ашиглуулах

е) дархан цаазтай газрын байгалийн тэнцвэрийг хадгалах үүднээс ойн болон биотехникийн арга хэмжээг авч явуулахдаа зөвхөн тухайн бүс нутгийн буюу өөрийнх нь унаган ургамал, мод тарих, ан амьтан нутагшуулах.

8. Дархан цаазтай газарт байгалийн аялал жуулчлал, бусад арга хэмжээг явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

а) байгалийн аялал жуулчлалыг гал түймрийн аюултай үеэс бусад хугацаанд зөвхөн тогтоосон зам, чиглэлээр явган болон жорин аяллын хэлбэрээр зохион байгуулах

б) аялчин жуулчдын түр буудаллах, отоглох газарт байгальд сөрөг нөлөөлөхгүй байх арга хэмжээ авах

в) аялал жуулчлал болон эртний ёс горимыг сэргээж шашны зан үйлийн хүрээнд уул эргэх, мөргөл үйлдэх, овоо тахиx зэрэг арга хэмжээг байгальд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулах

г) хязгаарлалтын бүсэд байгаа зочид буудал, илал жуулчлалын бааз, сувиллын газрыг шинэчлэх, сэргээж тохижуулах, тэдгээрийг шинээр барьж байгуулахдаа байгальд сөрөг нөлөөгүй арга хэлбэрийг сонгон авч экологийн магадлан шинжилгээний дүгнэлт гаргуулах

д) хязгаарлалтын бүсэд дархан газрын болон монгол үндэсний өвөрмөц амьдрал ахуйн онцлогтой холбогдсон бүсэд арга хэмжээ зохион байгуулж болно.

9. Дархан цаазтай газарт байрлаж байгаа аж ахуйн иргэж, байгууллагууд дор дурдсан журмыг мөрдөнө:

а) Тусгай хамгаалалттай газрын дүрэм бодов энэ горимыг чанд мөрдөж дархан цаазтай газрыг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх талаар ногдуулсан үүргийг хэрэгжүүлэх

б) зөвхөн тогтоож өгсөн газарт зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг халбогдох байгууллагад тухай бүр мэдээлэх, таслан зогсоох арга хэмжээ авч байх

в) жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 1, 8 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд тусгай эргүүл томилж дэвсгэрийн байгаль хамгаалагч-байнаагчид туслэх

г) ой, хээрийн түймэртэй тэмцэхэд зориулсан багаж хэрэгслийг зохих нормативын дагуу бэлтгэж бэлэн байдалд байлгах

д) өөрийн ашиглаж байгаа газрыг эвдрэлээс хамгаалах, галхлагдсан хөрс, ургамлыг нөхөн сэргээх, баталсан зураг төслөөр орчны тохижилт хийх, тухайн дэвсгэрт дархан цаазтай газрын хамгаалалтын захиргаанаас ойн болон биотехникийн арга хэмжээний ажил зохион байгуулахад туслалцаа үзүүлж байх

е) бохир ус, хот хаягдлыг цаг алдаагүй зөөж тогтоосон шэгт (хилтйн гадна) хаях

ж) олон сэдээ зам гарахаас сэргийлэх анта хэстийн сайжруулсан буюу нармаа зам, тусгай зогсоол бий болгон тохижуулах

з) газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу төлөх

и) амралт сувиллын байгууллагууд нь амрагч сувилуулагчдын дүгээс байгаль орчинд сөрөг нөлөөлөхгүй байх асуудлыг хариуцах.

10. Дархан цаазтай газарт дор дурдсан үйл ажиллагааг хориглоно:

а) мод бэлтгэх, хамгаалалтын захиргаанаас бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хадлан хадах, зөвшөөрөгдсөнөөс бусад хүмүүс биедээ буу зэвсэг авч явах, ил задгай гал түлэх, цогтой үнс нурмаа асгах, ан амьтны байршил болон байгальд сөрөг нөлөөлөх аливаа үйл ажиллагаа явуулах

б) дархан цаазтай газрын нутаг дэвсгэрээс гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бугын ясан эвэр, эмийн болон хүнсний ургамал түүх, ан амьтан агнах, барих

в) аялал жуулчлалын зам, чиглэлийг өөрчлөх, зөвшөөрөгдсөнөөс бусад газарт түр буудаллах, отоглох

г) байгаль орчны төрх байдалд сөрөг нөлөөлөх (газар тарвалан, мал аж ахуй эрхлэх, химийн бодис хэрэглэх, Сохирдол ихтэй, хортой үйлдвэрлэл явуулах зэрэг) үйл ажиллагаа явуулах

д) хортон шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ экологид сөрөг нөлөөлөх аливаа арга, технологиг хэрэглэх, тухайн дархан цаазтай газарт урьд нь байгаагүй амьтныг нутагшуулах, мод ургамал тарих

е) зөвшөөрөлгүй буюу экологийн магадлан шинжилгээ хийгээгүй барилга байгууламж барих, бусад хэлбэрээр газар шингэлэх, байгаль хамгаалагчид дэргэдээ айл буулгах, тогтоосон хэмжээнээс илүү мал байлгах.

11. Дархан цаазтай газрын хамгаалалтын захиргаа өөрийн хариуцан хамгаалж байгаа нутаг дэвсгэрийн байгальд учруулсан хохирлын хэмжээг тухайн баялгийн эдийн засгийн болон экологийн ач холбогдлын үнэлгээ, уг баялгийг нөхөн сэргээх зардлын нийт дүнгээр тооцож гэм буруутай аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээр нөхөн төлүүлнэ.

12. Дархан цаазтай газарт Тусгай хамгаалалттай газрын дүрэм, энэ горим, бусад холбогдох хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээлд Дархан цаазтай газрын хамгаалалтын захиргааны эрх бүхий хүмүүс зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх буюу шүүхэд шилжүүлэн хэргийг шийдвэрлүүлнэ.

Засгийн газрын 1994 оны 95 дугаар  
тогтоолын 4 дүгээр хэсгээр

## ГОВИЙН ИХ ДАРХАН ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ГОРИМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Говийн их дархан газар (цаашид энэ горимд «Дархан газар» гэнэ)-ийн байгалийн бүх төрлийн байлаг нь төрийн зохицуулалтад байна.

2. Дархан газар нь Алтайн өмөр говийн «А» хэсэг, Зүүн ггарын говийн «Б» хэсэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

3. Дархан газрын судалгаа шинжилгээ, хамгаалалттай холбогдсон үйл ажиллагааг Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, энэ горим, бусад хууль тогтоомжид нийцүүлэн Говийн их дархан газрын хамгаалалтын захиргаа (цаашид «хамгаалалтын захиргаа» гэнэ) хариуцна.

### ХОЕР. Дархан газрын хамгаалалтын горим

4. Байгаль орчны яам Тусгай хамгаалалттай газрын дүрэмд зааснаас гадна дархан газарт дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а) судалгаа шинжилгээний ажил явуулах журам, хөтөлбөрийг батлах, уг хөтөлбөрийн хүрээнд шинжилгээ судалгааны ажил явуулах эрдэм шинжилгээний болон гадаад орон, олон улсын байгууллагад зөвшөөрөл олгох, тэдний гүйцэтгээс ажиг дүгнэлт өгөх, холбогдох тайлан материалыг авч нээгдсэн санд оруулах

б) дархан газрын бүс тус бүрээс судалгаа шинжилгээний дээж, сорьц авах, хэмжилт хийх, энэ зорилгоор ан амьтан баарих, агнах, түүнчлэн ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах журмыг батлах

в) эрдэм шинжилгээний холбогдох байгууллагаас боловсруулсан дархан газар дахь ан амьтныг тоолох аргачлал, хугацаа, хөтөлбөрийг батлах

г) хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, хөтөлбөрийг батлах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх газар, тэдгээрийн хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоож өгөх

д) дархан газарт аялал жуулчлал хийх журам, аялал жуулчлалын үед байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн хэмжээг баталж, аялал жуулчлалын

лам, чинээл, аялагчид, зөвшөөрөл бүхий бусад хүмүүс түр буудаллах, отоголох, ажиглалт, судалгааны зориулалтаар орон байр барих газрыг тогтоож өгөх

е) дархан газрын нутаг дэвсгэрээс ашиглах эмийн болон хүнсний ургамлын жагсаалт, тэдгээрийг бэлтгэх журмыг батлах.

5. Улсын хилтэй дархан газрын хилийн нэс давхцаж буй нутаг дэвсгэрт байрлаж байгаа улсын хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон дор дурдсан зууудыг Байгаль орчны яам, Хилийн цэргийг удирдах газар, холбогдох аймгуудын Засаг дарга нартай хамтран зохицуулна:

а) улсын хил хамгаалах байгууллагын байрлах газар, түүний гүйцэтгэх үүргийг тогтоох

б) уг байгууллагын туслах аж ахуйн малын дөрвөн улиралд байрлах, бэлчээрлэх нутаг дэвсгэрийг тогтоох

в) хил хамгаалах байгууллагын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо тарих газрыг тогтоож, ашиглах техник, технологийг тохиролцох

г) дархан газарт улсын хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгсэл зорчих зам, зогсох газрыг тогтоох.

6. Говийн их дархан газрын хамгаалалтын захиргаа дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а) дархан цааттай газарт байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, тусгай хамгаалалттай газрын дүрэм, горимын биелэлтийг хангах, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд энэ талаар шаардлага тавих, гэм буруутай үйлдлийг нь төсөлэн зогсоох, тэдэнд зохих журмын дагуу харуцлага ногдуулах

б) батлагдсан журам, хөтөлбөрийн дагуу судалгаа шинжилгээний ажил явуулах, уг хөтөлбөрийн хүрээнд судалгаа шинжилгээний ажилд оролцох зөвшөөрөл авсан гадаад, дотоодын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах

в) судалгаа шинжилгээний дээж, сорьц авах, хэмжилт хийх, ан амьтан барих, агнах, нутагшуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах

г) зохих журам, хөтөлбөрийн дагуу хөрс, ургамлыг нөхөн сэргээх, ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах

д) дархан газрыг сурталчлахтай холбогдсон уран зураг зурах, зохиол, бусад бүтээл туурвих, дүрс, дуу анхны бич-

лэг хийх, кино болон гэрэл зураг авах, аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүст зөвшөөрөл олгож, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж хяналт тавих.

е) дархан газрын хамгаалалтын болон хязгаарлалтын бүсийн дотор ус задгайлэх, булаг шанд тохижуулах, ан амьтанд зориулан өмс, гэжээл, хужир шүү тавих, нөмөр хорго барих, биотехникийн бусад арга хэмжээ авах.

ж) дархан газрын хязгаарлалтын бүсэд уул овоо тахих, ан үйлийн уламжлалт бусад ёслол үйлдэх асуудлыг зохицуулах.

з) дархан газрын ажилтан, байгаль хамгаалагчид албан үүргээ гүйцэтгэж байхдаа бие хамгаалах зориулалтаар ангийн буутай явах асуудлыг зохицуулах.

и) цаг агаар хүндэрсэн үед дархан газрын хязгаарлалтын бүсэд мал оруулах асуудлыг зохио журмын дагуу шийдвэрлэж, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

7. Дархан газарт эрдэм шинжилгээний ажлыг явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

а) онцгой болон хамгаалалтын бүсийн байгалийн төрх байдал, ус, хөрс, ургамал, амьтны аймгийн онцлог, тэдгээрийн хувьсал өөрчлөлтийн судалгаа явуулахдаа байгальд нөлөөгүй арга, хэлбэрээр ажиглах, шинжлэн судлах.

б) хамгаалалтын бүсэд энэ зүйлийн «а»-д зааснаас гадна ургамал, амьтны аймгийн зүйлийг нарийвчлан судлах, дээж сорьц авах, хэмжилт хийхдээ тухайн ургамал, амьтанд сөрөг нөлөөлөхгүй байх.

в) хязгаарлалтын бүсэд энэ зүйлийн «а», «б»-д зааснаас гадна бусад нарийвчилсан судалгаа явуулахдаа тухайн газрын төрх байдлыг өөрчлөхгүй байх арга хэлбэрийг хэрэглэх.

г) судалгаа шинжилгээний явцад газрын төрх байдалд өөрчлөлт оруулж хөрс, ургамлыг гэмтээвэл түүнийг нөхөн сэргээх арга хэмжээ авч хамгаалалтын захиргаанд газар дээр нь хүлээлтэн өгөх.

8. Дархан газрын хязгаарлалтын бүсэд хөрс, ургамлыг нөхөн сэргээх, мод, бут тарихдаа дор дурдсан журмыг баримтална:

а) ургамлыг нөхөн сэргээхэд болон мод, бут тарихад зөвхөн тухайн газарт ургадаг ургамлын үр, тарьц хэрэглэх.

б) ан амьтны байриул, ургамлын нөмрөгт нөлөөлөхгүй арга, технологиор тухайн газар нутгийн онцлогт тохируулан хөрс, ургамлыг нөхөн сэргээх.



9. Дархан газрын хязгаарлалтын бүсэд биотехникийн арга хэмжээ авах, ан амьтны судалгааг явуулахдаа дор дурдсан журам баримтална:

а) судалгаа шинжилгээний зориулалтаар ан амьтан агнах, барихад тэдгээрийн байршлыг алдагдуулахгүй байх, байгальд сөрөг нөлөөлөхөөс сэргийлэх арга хэмжээ авах

б) үржиж төлдөх, шинэ газарт нүүдэллэн шилжих, байршихаас бусад хугацаанд ан амьтны тоо толгойг зохицуулах.

—10. Аялал жуулчлалыг явуулахад дор дурдсан журам баримтална:

а) тогтоосон зам, чиглэлийг чанд баримтлах

б) түр буудаллах, отоглох газарт байгальд сөрөг нөлөөлөх аливаа үйл ажиллагаа явуулахаас сэргийлж, аяллын тогтоосон зам, чиглэл, түр буудаллах, отоглох газрыг дур мэдэн өөрчлөхгүй байх.

11. Дархан газрын хамгаалалтын захиргаа, орон нутгийн төрийн захиргааны байгууллага хамтран дор дурдсан асуудлыг зохицуулна:

а) дархан газрын нутаг дэвсгэрийг хамгаалах байгалийн баалгийг нөхөн сэргээх ажилд орон нутгийн байгууллага, иргэдийг татан оролцуулах

б) уул, овоо тахих, зан үйлийн уламжлалт бусад ёслолыг тухайн орчны байгальд сөрөг нөлөөлөхгүйгээр зохион байгуулах

в) дархан газрын хязгаарлалтын бүсэд өвөлжих, хаваржих айл өрх, малын тоог харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоож хүлээх үүргүүдийг нь тодорхойлох.

12. Дархан газрын нутаг дэвсгэрт хамгаалалтын горимоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

а) хамгаалалтын горимоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулахдаа тухайн газар нутгийн байгальд сөрөг нөлөөлөхгүй байх арга, технологийг ашиглах, ан амьтан үргэж дайжихаас сэргийлэх арга хэмжээ авсан байх

б) автомашины замыг тэмдэгжүүлж шинээр зам бий болох, орчныг бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээ авсан байх.

13. Дархан газарт дор дурдсан үйл ажиллагааг хориглоно:

а) дархан газрын хамгаалалтын бүсэд тусгай зөвшөөрлөөр түр нутаглаж байсан айл өрх заагдсанаас бусад хугацаанд нүүдэл хийх, хүмүүс ангийн буутай явах, ан амьтны

байршил, байгальд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах

б) аялал жуулчлалын зам, чиглэлийг өөрчлөх, зөвшөөрөгдсөнөөс бусад газарт түр буудаллах, отоглох

в) дархан газрын хязгаарлалтын бүсэд зөвшөөрсөн хугацаанаас бусад үед мал оруулж бэлчээрлүүлэх, зөвшөөрөггүй эрэлд гарах, баян бүрд, булаг шандны өмс хадах

г) дархан газарт урьд нь байгаагүй амьтан, ургамал нутагшуулах

д) энэ горимоор зөвшөөрөгдсөнөөс бусад үйл ажиллагаа явуулах.

14. Дархан газрын хамгаалалтын захиргааны ажлынгууд байгаль орчны хяналтын байцаагчийн үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

15. Хамгаалалтын захиргаа нь хариуцан хамгаалж байгаа нутаг дэвсгэртээ байгалийн байлагт учруулсан хохирлын хэмжээг эдийн засгийн болон экологийн гч холбогдлын үнэлгээ, уг байлагийг нөхөн сэргээх зардлын нийт дүнгээр тооцож гэм буруутай аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээр холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

16. Дархан газрын нутаг дэвсгэрт Тусгай хамгаалалттай газрын дүрэм, энэ горим, бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд дархан газрын захиргааны эрх бүхий хүмүүс зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх буюу шүүхэд шилжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 96

Улаанбаатар

сарын 18-ны өдөр

хот

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛЭГ  
ЯВУУЛЖ БАИХ ТУХАЙ

Улсын Их Хуралд суудал бүхий намуудын удирдлагын хүсэлдвйр харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Радио, телевизийн Хэрэг эрхлэх газар (Б. ӨВГӨНХҮҮ)-г даалгах нь:

а) Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлагдан гарах хүртэл хугацаанд Монголын радио, телевизэд Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намуудад үзэл баримтлалаа тайлбарлахад нь зориулан, тэдгээрийн Улсын Их Хурал дахь суудлын тоог харгалзан МАХН-д 20 минут, МҮАН, МСДН-д тус бүрд нь 10 минутын тогтмол нэвтрүүлгийг телевизэд 14 хоног тутам, радиод 7 хоног тутам нэг удаа бэлтгэн явуулж байсугай.

б) энэхүү нэвтрүүлгийг явуулах талаар Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намуудтай харилцан тохиролцсон гэрээ байгуулж ажилласугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын шадар сайд

П. ЖАСРАЙ

Ч. ПҮРЭВДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 97

Улаанбаатар

сарны 18-ны өдөр

ХОТ

### ЖАГСААЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

«Журам, жагсаалт батлах тухай» Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолоор баталсан «Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох журам»-ын хавсралтад «16. Аялал, жуулчлал эрхлэх, Худалдаа, үйлдвэрийн яам» гэсэн нэмэлт оруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Худалдаа, үйлдвэрийн сайд

П. ЖАСРАЙ  
Ц. ЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 98

Улаанбаатар

сарны 25-ны өдөр

ХОТ

### МЭРГЭЖЛИЙН УРЛАГИЙН ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ӨӨРЧДӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Соёлын яамнаас оруулсан саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

I. Мэргэжлийн урлагийн зарим байгууллагын боловсон хүчний нөөц бололцоо, материаллаг баазыг бүрэн дүүрэн ашиглах зорилгоор Дуурь, бүжгийн улсын академик театр, Улсын драмын академик театр, Балетийн үндэсний театр,

Цэргийн үндэсний жүжгийн театрыг 1994 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон татав буулгаж, тэдгээрийн боловсон хүчин, материаллаг баазад түшиглүүдэн бүрэлдэхүүндээ Дуурийн болон балетын үндэсний хүрээлэн бүхий Сонгодог урлагийн академик театр, Үндэсний жүжгийн академик театрыг тус тус байгуулж Соёлын яамны харьяанд ажиллуулсугай.

2. Морин хуурын улсын чуулгыг 1994 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Улсын филармонийн бүрэлдэхүүнд оруулж ажиллуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Шинээр байгуулагдсан болон зохион байгуулалтын өөрчлөлт орж буй мэргэжлийн урлагийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг тогтоон, тэдгээрийн орон тоо, дүрэм, зардлын төсвийн хязгаарыг хянан баталж мөрдүүлэхийг Соёлын сайд Н. Энхбаяр, Сангийн сайд Д. Даваасамбуу нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Морин хуурын улсын чуулга байгуулах тухай» Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 123 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Соёлын сайд

П. ЖАСРАЙ  
Н. ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар  
хот

### ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:  
«Улсын үйлдвэрийн газрын даргыг томилж журмын тухай» Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өд-

рийн 183 дугаар тогтоолоор баталсан журмын I дүгээр зүйлийг «1. Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид харьяалагдах үйлдвэрийн газрын даргыг тухайн шатны Засаг дарга, бусад үйлдвэрийн газрын даргыг сайд, тусгай газрын дарга буюу тэдний эрх олгосноор уг үйлдвэрийн газрыг харьяалах дээд байгууллагын удирдлага гэрээний үндсэн дээр тус тус томилно.» гэж өөрчлөн найруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Хууль зүйн сайд

П. ЖАСРАЙ  
Н. ЛУВСАНЖАВ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар  
хот

### ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хорих байгууллагын ажилтны сахилгын дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Хууль зүйн сайд

П. ЖАСРАЙ  
Н. ЛУВСАНЖАВ

## ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ САХИЛГЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хорих байгууллагын ажилтны сахилгын дүрэм нь хорих байгууллагуудад тавигдах нийтлэг шаардлага, түүнийг биелүүлэхэд амжилт гаргагчдад сайшаал хүртээх, зөрчигчдэд сахилгын шийтгэл хүлээлгэх харилцааг зохицуулна.

2. Хорих байгууллагын ажилтны сахилга нь Үндсэн хууль, Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар тогтоосон хэм хэмжээ, захирах даргын тушаалыг сахиж биелүүлснээр тодорхойлогдоно.

3. Хорих байгууллагын ажилтны сахилга нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ сахин биелүүлэх нггэл үнэмшилд тулгуурлах бөгөөд захирах дарга нь өөрт захирагдах, албан үүргээ амжилттай биелүүлсэн, гавьяа байгуулсан ажилтанд сайшаал хүртээх, албан үүрэгтээ хайнга хандсан, зөрчил дутагдал гаргасан ажилтанд зэмлэл, сахилгын шийтгэл хүлээлгэх эрхийг эдэлнэ.

### Хоёр. Хорих байгууллагын ажилтанд хүртээх сайшаал

4. Захирах дарга нь хариусан ажил, албандаа онц идээх зүтгэл гаргасан, үүргээ үлгэр жишээч биелүүлсэн ажилтанд энэ дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд дараахь сайшаалыг хүртээнэ:

- а) баяр хүргэж бие бүрэлдэхүүнд мэдээлэх
- б) урьд овогдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах
- в) байрын бачиг, сайшаалын үнэмлэхээр шагнах
- г) үнэ бүхий зүйл буюу мөнгөн шагналаар шагнах
- д) байгууллагын тугны дэргэд зургийг авахуулж дурсгах
- е) сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар нэмэгдүүлэх
- ж) зургийг нь хүндэт самбарт тавих
- з) хугацааны өмнө цол олгох
- и) тэргүүний ажилтан тэмдгээр шагнах

к) онцгой гавьяа байгуулсан тохиолдолд төр, засгийн шагналаар шагнуулахаар зохих журмын дагуу тодорхойлох.

5. Энэ дүрмийн 4-ийн «ж», «з», «и», «к»-д заасан сайшаалыг тухайн хорих ангийн даргын зохих журмын дагуу уламжилсан санал, тодорхойлолтыг үндэслэн Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга хүртээх буюу тодорхойлно. Буусад сайшаалыг хорих ангийн дарга хүртээнэ.

### Гурав. Хорих байгууллагын ажилтанд хүлээлгэх сахилгын шийтгэл

6. Захирах дарга нь сахилгын дүрэм зөрчсөн ажилтанд Хоорих байгууллагын болон Хорих ял эдлүүлэх хуулийн дагуу энэ дүрмээр олгосон эрх хэмжээний хүрээнд дараахь сахилгын шийтгэл хүлээлгэнэ:

- а) сануулах
- б) нолны мөнгийг 3 сар хүртэл хугацаагаар хасгах
- в) сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах
- г) цолыг нь бууруулах буюу хасгах
- д) ажлаас халгах.

7. Энэ дүрмийн 6-гийн «г», «д»-д заасан шийтгэлийг Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга, бусад шийтгэлийг хорих ангийн дарга тушаалаар хүлээлгэнэ.

8. Сахилга, дэг журмыг бэхжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, албаны үүргээ хангалтгүй биелүүлсэн, сахилгын шийтгэл хүлээлгэх эрхээ хэтрүүлсэн захирах даргад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### Дөрөв. Сахилгын шийтгэл хүлээлгэх, эдлүүлэх, арилгах журам

9. Сахилгын шийтгэлийг гаргасан зөрчлийн шинж чанар, хүнд хөнгөн, гэм буруугийн хэмжээ, ажилгын хувийн байдалд тохируулж хэрэглэнэ. Харуул, жижүүрлэлтийн үед, түүнчлэн давтан буюу бүлэглэн, эсхүл согтуугаар зөрчил гаргаж хэн журмыг гажуудуулсан нь захиргааны зөрчлийн шинжгүй бол сахилгын шийтгэлийг хүндрүүлнэ.

10. Сахилгын шийтгэлийг давхардуулан буюу нийт бие бүрээлдэхүүнд хавтгайруулан хэрэглэхийг хориглоно.

11. Сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай зөрчил гаргасан ажилтанд өөрт нь мэдэгдэж, анги, байгууллагын нийт бие бүрээлдэхүүнд албан ёсоор мэдээнэ.



12. Хорих байгууллаагын ажилтан нь захиргааны болон сахилгын зөрчил давхар гаргасан бол захиргааны шийтгэл хүлээсэн эсэхийг үд харгалзан сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

13. Сахилгын шийтгэлийг уг шийтгэл хүлээлгэсэн захирах дарга арилгах эрхтэй ба шаардлагатай тохиолдолд түүнтэй адил буюу ахлах тушаалын шууд захирах дарга арилгаж болно.

Цолийг нь бууруулах буюу хасах шийтгэлийг хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол уг шийтгэлийг арилгана.

**Тав. Сайшаал, сахилгын шийтгэлийг бүртгэх,  
гомдол гаргах журам**

14. Хорих байгууллагуудыг удирдах газар, хорих ангийн боловсон хүчин эрхэлсэн алба энэ дүрэмд заасан баяр хүргэх болон сануулахаас бусад сайшаал, шийтгэлийн бүртгэлийг хөтөлж, ажилтны хувийн хэрэгт тэмдэглэнэ.

15. Сайшаал, шийтгэлийг зөв хэрэглэж байгаа эсэх, түүний бүртгэл хөтлөлтөд Хорих байгууллагуудыг удирдах газраас хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

16. Хорих байгууллаагын ажилтан нь сайшаал, шийтгэлтэй холбогдсон санал, гомдлоо зохих шатны захирах даргад амаар буюу бичгээр гаргаж болно.

Санал гомдлыг хүлээн авсан захирах дарга 14 хоногт багтаан шийдвэрлэж хариу өгнө. Сахилгын шийтгэл хүлээсэн ажилтан гомдлоо хууль тогтоомжид заасны дагуу шүүхэд гаргаж болно.

---

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 103

Улаанбаатар

сүнийн 25-ны өдөр

хот

### УЛСЫН ЭРДСИЙН БАЯЛГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМД ЗАРИМ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Улсын эрдсийн баялгийн зөвлөлийн дүрмийг батлах тухай» Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 72 дугаар тогтоолоор баталсан «Улсын эрдсийн баялгийн зөвлөлийн дүрэм»-ийн «Нийтлэг үндэслэл»-д дор дурдсан згуулсгатай 3, 4, 5, 6, 7, 8 дугаар зүйлүүдийг нэмсүгэй:

«3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

4. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн газар батална.

5. Зөвлөлийн хуралдааныг шаардлагатай үед хийж, асуудлыг одонхийн саналаар шийдвэрлэн тогтоол гаргана.

6. Геологич дайгуулын ажил явуулах болон олборлолтын ажилд мөрдүүлэх зорилгоор зөвлөлөөс эрх хэмжээнийхээ асуудлаар гаргасан тогтоомыг аж ахуйн нэгж, байгууллагууд дээр лицензийн дагуу хяналт тавихад баримтална.

7. Зөвлөлийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, түүнийг биелэлтийг зохион байгуулна.

8. Зөвлөл тогтоосон журмвар хийлэгсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.»

2. Мөн дүрмийн 3, 4 дүгээр зүйлийг 9, 10 болгон өөрчилж 10 дугаар зүйлийн «г» заалтын «... зөвлөлөөр хэлэлцүүлэхээр, бэлтгэхтэй холбогдож гарсан зардлыг...» гэсэн хэсгийг «... зөвлөлөөр хэлэлцүүлэхтэй холбогдож гарсан зардлыг...» гэж өөрчлөн найруулсугай.

«3. Улсын эрдсийн баялгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай.

Зөвлөлийн дарга	— Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд
Орлогч дарга	— Эрчим хүч, геологи, уул уурхайн дэд сайд (геологи, уул уурхайн асуудал харууцсан)
Гишүүд:	— Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Уул уурхайн газрын ерөнхий захирал
	— мөн яамны Геологийн бодлого, төлөвлөлтийн газрын ерөнхий захирал
	— Байгаль орчны яамны Байгалийн нөөцийн бодлогын газрын ерөнхий захирал
	— Дэд бүтцийн хөгжлийн яамны Барилга, барилгын материалын үйлдвэрийн газрын дарга
	— Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Хяналтын газрын дарга
	— мөн яамны Уул уурхайн газрын уул уурхай, металлургийн асуудал эрхэлсэн ерөнхий инженер
	— мөн яамны Уул уурхайн газрын түлшний үйлдвэрийн асуудал эрхэлсэн ерөнхий инженер
	— мөн яамны Геологийн бодлого, төлөвлөлтийн газрын ерөнхий геологич
	— Үндэсний хөгжлийн газрын Технологи, хөрөнгө оруулалтын газрын геологийн асуудал харууцсан түшмэл
	— Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологийн бодлого, төлөвлөлтийн газ-

- рын металл ашигт малтмалын геологийн судалгаа эрхэлсэн түшмэл
- мөн яамны Геологийн бодлого, төлөвлөлтийн газрын металл бус ашигт малтмалын геологийн судалгаа эрхэлсэн түшмэл
- мөн яамны Геологийн бодлого, төлөвлөлтийн газрын гидрогеологи, инженер геологийн судалгаа эрхэлсэн түшмэл
- мөн яамны Газрын тосны хэрэг эрхлэх товчооны ерөнхий геологич
- мөн яамны Монголын геологийн албаны Эрдэс баялгийн эдийн засгийн төвийн захирал
- мөн яамны харьяа Эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн «Эрдэс» компани (УУГ)-ийн ерөнхий захирал
- Байгаль орчны яамны Усны бодлогын хүрээлэнгийн газрын дээрхи усны секторын эрхлэгч.
- орон тооны

Нарийн бичгийн дарга

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Улсын эрдсийн баялгийн зөвлөлийн дүрмийг батлах тухай» Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 72 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд

П. ЖАСРАЙ

Б. ЖИГЖИД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар

Дугаар 104

Улаанбаатар

сэрэг 25-ны өдөр

хот

### «ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР»-НИГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАН

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамнаас холбогдох бусад яам, газар, олон улсын болон Засгийн газрын бус олон нийтийн байгууллагуудтай хамтран боловсруулсан «Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр» (цаашид «хөтөлбөр» гэнэ)-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулан удирдах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хороог хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай.

2. Үндэсний хороо (Ч. ПҮРЭВДОРЖ)-д даалгах нь:

а) хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгө, төсөл, зээл тусламжийн асуудлыг нягтлан боловсруулж, бэлтгэл ажлыг сайтар хангасны үндсэн дээр 1994 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо болох Монголын хөгжлийг дэмжигч хандивлагч орнуудын зөвлөлгөөнд оруулж хэлэлцүүлэх

б) хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх ажилд Засгийн газрын бус олон нийтийн болон эзэд, хориоологчдын байгууллага, иргэдийн төлөөлөгчдийг оролцуулж ажиллах

в) хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил тутам Засгийн газарт танилцуулж байх.

3. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд байгуулан ажиллуулж, ажлын нөхөр дүнгийн талаар Үндэсний хороонд жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор мэдээлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нэрт даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулж өдөр тутмын шуурхай удирдлагаар хангах

үүүрэг бүхий «Ядуурлыг бууруулах асуудал эрхэлсэн илэгж»-ийг яамныхаа бүтнэд байгуулж ажиллуулахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожавт даалгасгай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого,  
хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

Засгийн газрын 1994 оны 104 дүгээр  
тогтоохын зөвшөөрлөөр

**«ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР»-ИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАН УДИРДАХ,  
ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга

— Монгол Улсын шадар сайд  
(Гадаад орнуудтай явуу-  
лах худалдаа, эдийн засаг,  
соёл, шинжлэх ухаан, тех-  
никний хамтын ажиллагаа-  
ны шуурхай зохицуулалтын  
асуудал эрхэлсэн)

Орлогч дарга:

— Хүн амын бодлого, хөдөл-  
мөрийн сайд  
— Монгол Улсын сайд бөгөөд  
Үндэсний хөгжлийн газрын  
дарга.

Гшнууд:

— Эрүүл мэндийн сайд  
— Шинжлэх ухаан, боловсро-  
лын сайд  
Хүнс, хөдөө, аж ахуйн  
сайд  
Худалдаа, үйлдвэрийн  
сайд  
— Дэд бүтцийн хөгжлийн  
сайд

Нарийн бичгийн  
дарга

- Сангийн дэд сайд
- Гадаад харилцааны дэд сайд
- Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны Ядуурлыг бууруулах асуудал эрхэлсэн нэгжийн дарга.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар  
хот

### ДУНДАЖ ХӨЛС ТОДОРХОЙЛОХ ЖУРАМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын «Журам батлах тухай» 1991 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 63 дугаар тогтоолоор баталсан «Дундаж хөлс тодорхойлох журам»-ын 5 дугаар зүйлд «Хэрэв амралт олгохын өмнөх 12 сарын хугацаанд ажилтны хөдөлмөрийн хөлсийг амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан өөрчлөн тогтоосон бол ээлжийн амралтын хөлсийг тодорхойлох өдрийн дундаж хөлсийг тухайн ажилтны хөдөлмөрийн хөлсийг шинэчлэн тогтоосноос хойш ээлжийн амралт эдлэх хүртэл хугацаанд олгосон хөдөлмөрийн хөлсний нийлбэрийг ажилласан өдрүүдийн тоонд хувааж тодорхойлно» гэсэн нэмэлтийг оруулсугай.

2. Төрийн өмчийн төсөвт байгууллагын ажилтнуудын 1994 оны ээлжийн амралтын хөлсний хэмжээг тухайн ажилтанд «Хүн амын нийгмийн баталгааг хангах ээлжит арга хэмжээний тухай» Засгийн газрын 1993 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний сүлжээгээр 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд олгож байгаа болон олгох хөдөлмөрийн хөлсийг үндэслэн тооцсон өдрийн дундаж хөлсийг уг ажилтны ээл-

жийн амралтын өдрийн тоогоор үржүүлж тодорхойлох нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Энэ тогтоол гарахаас өмнө 1994 оны ээлжийн амралтад эдэлсэн ажилтанд олгосон амралтын хөлс нь энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон амралтын хөдсөнөөс бага байвал зөрүүг нөхөн олгохыг төрийн өмчийн төсөвт байгууллагын эрх баригчдад үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого,  
хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЯН ТОГТООЛ

1994 оны 9 дүгээр

Дугаар 125

Улаанбаатар

сарын 12-ны өдөр

хот

### ДЭЭД ШҮҮХИЯН БҮГД ХҮРЛЫН ЗАРИМ ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын эдийн засаг, зах зээлийн зохицуулалтад, төлбөр тооцоо валютын чөлөөтэй хөрвөх ханшид шилжих явцад мөнгөний ханш буурч, бариа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тариф ихээхэн өсч байгаатай уялдан өмчийн эсрэг гэмт хэргийг зүйлчлэх гол шалгуур болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн илэрхийллийг цаг тухайд нь шинэчлэн тодорхойлж байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дээд шүүхээс гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлын хэмжээг 1991 оны 13, 1993 оны 26 дугаар тогтоолуудаар шинэчлэн тогтоож байсан боловч дээрх тогтоолууд гарах үеэс мөнгөний ханш ихээхэн өөрчлөгдсөний гадна эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт орсноос шалтгаалан уг хэмжээг төгрөг, ам, долларын суурь ханшны өөрчлөлттэй харьцуулан дахин шинэчлэн тогтоох шаардлага-



тай байна. Нөгөө талаар нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, төрөөс өмчлөгчийн эрхийг адил тэгш хамгаалах хууль зүйн баталгаа бүрэлдэн тогтсон учир гэмт хэргийн улмаас учруулсан ижил хэмжээний хохирлыг зүйл тус бүрээр илгавартай тогтоож байх шаардлагагүй болжээ.

Монгол улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Бүгд хурлын 1993 оны 13 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай» Дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 3-р сарын 11-ний 26 дугаар тогтоолын 2-р зүйлийг өөрчлөн бүсдийн өмчийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэмжээг дараах байдлаар шинэчилэн тогтоож, уг зүйлийн «Дөрвөн»-ийг дор дурьснаар өөрчлөн найруулсугай.

«Дөрвөн, Эрүүгийн хуулийн III бүлэгт заасан гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын хэмжээг дараах байдлаар тогтоосугай.

1. Бага хэмжээ 3000—50,000 төгрөг
2. Үдэмж хэмжээ 550,000—1500,000 төгрөг
3. Их хэмжээ 1500,000-аас дээш төгрөг
4. Онц их хэмжээ 3000,000-аас дээш төгрөг

Хоёр. «Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал, иалшид баримтлах чиглэлийн талаар» Дээд шүүхийн бүгд хурлын 1988 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 34 дүгээр тогтоолын 6-р заалтын «6000» зургаан мянган/төгрөгнөөс» гэснийг «300,000 төгрөгнөөс» гэж өөрчилсүгэй.

Гурав. Бүгд хурлын 1991 оны 13-р тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 26 дугаар тогтоолын 1-р зүйлийн «Ийнхүү өөрчлөн тогтоохдоо Зэсгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 182-р тогтоолоор тогтоосон хүн амын амжиргааны баталгаажих доод түвшингийн дундаж. Дээд шүүхийн бүгд хурлын 1991 оны 13 дугаар тогтоолоор тогтоосон хохирлын хэмжээг суурь шалгуур болгон уг хэмжээг хүн амын амжиргааны баталгаажих доод түвшингийн өсөлт, бууралтын харьцаагаар өөрчилж байлаар тогтоосугай» гэснийг хассугай.

Дөрвөн. Энэ тогтоолыг 1994 оны 9-р сарын 1-нээс хойш үйлдэгдсэн гэмт хэрэгт баримтлахаар тогтоосугай.

Ерөнхий шүүгч  
Шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭЭРЭН  
А. ДОРЖГОТОВ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1994 оны 9 дугаар

Улаанбаатар

Дугаар 126

сарын 12-ны өдөр

хот

### ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ

«Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» Монгол Улсын 1994 оны 3-р сарын 28-ны өдрийн хуулийн эрүүгийн хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулсан зүйл, хэсэг, заалтуудыг нэг мөр ойлгож, шүүхийн практикт зөв хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ** нь:

Нэг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, хэсэг, заалтуудыг дор дурьдсанаар тайлбарласугай:

1. ЭБШ Хуулийн 362-р зүйлийн «давж заалдах шатны шүүхийн магадлал» гэдэгт анхан шатны журмаар эрүүгийн хэргэг хэлэлцээд гарсан таслан шийдвэрлэх тогтоолд болон ЭБШ хуулийн 323-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан давж заалдах гомдол, эсэргүүцлийг хянан хэлэлцээд аймаг, нийслэлийн шүүх болон Дээд шүүхээс гаргасан магадлалыг хамааруулж ойлгоно. Дээд шүүхийн шүүгч эдгээр магадлалын аанид нь ч түүний дотор өөрөө оролцсон давж заалдах шатны шүүхийн магадлалд ч эсэргүүцэл бичиж Дээд шүүхийн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх эрхтэй.

2. Энэ зүйлийн «байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид» гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 3-р бүлэг, 317-р зүйлд заан нэрлэсэн «шүүгдэгч, түүний өмгөөлөгч буюу хууль ёсны төлөөлөгч» «иргэдийн төлөөлөгч», түүнчлэн «хохирогч, түүний өмгөөлөгч», «яллагч, прокурор», «иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч тэдний төлөөлөгч», «цагаатгалдсан этгээд»-ийг хамааруулна. Тэгэхдээ «Иргэдийн төлөөлөгч», «яллагч» нь анхан шатны эрүүгийн шүүх хуралдаанд оролцсон байвал зохих бөгөөд яллагч «таслан шийдвэрлэх тогтоолын бүх хэсэгт эсэргүүцэл бичих ба бусад прокурор нь энэ хуулийн 323-р зүйлд заасан «Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид» эсэргүүцэл бичих санал гаргах эрхтэй. Харин шүүгдэгч, түүний өмгөөлөгч бусад хууль ёсны төлөөлөгч, хохирогч түүний төлөөлөгч «таслан шийдвэрлэх тог-

тоол, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шийдвэрлүүлсэн бүх асуудлаар иргэдийн төлөөлөгч нь зөвхөн шүүгдэгч гэм буруутай эсэх асуудлаар, иргэний нэхэмлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч нар зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт цагаатгагдсан этгээд, цагаатгасан шалтгаан үндэслэлд холбогдох хэсэгт тус тус гомдол гаргах эрхтэй.

3. Хууль, энэ тогтоолын 2 дэхь хэсэгт заасан байцаан шийтгэх ажиллагаанд оролцогсдоо бусад хүмүүс гомдол гаргасан буюу оролцогсод хуулиар тодорхойлсон хүрээнд хамаарахгүй асуудлаар гаргасан гомдол нь хэрэг хянах, эсэргүүцэл бичих үндэслэл болохгүй байж болно.

4. ЭБШ Хуулийн 362 дугаар зүйлийн «шүүгч өөрийн үлэмжээр» гэдэгт хяналтын журмаар эрүүгийн хэрэг хянаж байгаа Дээд шүүхийн шүүгч оролцогсдоо гомдол гараагүй-эрх бүхий этгээд эсэргүүцэл бичээгүй тохиолдолд ЭБШ хуулийн 333-р зүйл, 370-р зүйлд дурдсан таслан шийдвэрлэх тогтоол болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох буюу өөрчлөх үндэслэл байна гэсэн дүгнэлтэд хүрсэн тохиолдолд бие даан эсэргүүцэл бичихийг ойлгоно.

5. Энэ хуулийн шүүх хуралдаанд оролцсон прокурор гэдэгт анхан шатны шүүх хуралдаанд оролцсон ялагч, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон прокурорыг тус тус хамааруулна. Ялагчийн хэлсэн үг, прокурорын дүгнэлтийг шүүх хуралдааны протоколд тэмдэглэсэн байвал зохино.

6. ЭБШ хуулийн 363-р зүйлд заасны дагуу таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг биелүүлэхийг түдгэлзүүдэл ажиллагааг тухайн хэргийг хянасан Дээд шүүхийн шүүгч тухайн таслан шийдвэрлэх тогтоол давж заалдах шатны шүүхийн магадлалыг биелүүлбэл зохих заалтыг хүчингүй болгох буюу өөрчлөхөөр эсэргүүцэл бичсэн тохиолдолд захирамж гарган гүйцэтгэж байх нь зүйтэй.

7. ЭБШ Хуулийн 367<sup>1</sup>-р зүйлд заасны дагуу Дээд шүүхийн зөвлөлдөх хуралдааныг хийхдээ даргаалагчийг томилж, протокол хөглөх, оролцогсдыг оролцуулах шаардлагагүй. Хэргийг эсэргүүцэл бичсэн шүүгч нь хэрэв тэрээр давж заалдах шатны шүүх хуралдаанаар үг хэргийг хэлэлцэхэд оролцсон бол уншсан шүүгч нь зөвлөлдөх хуралдаанд танилцуулна.

8. Энэ зүйлийн 2 дахь хэсгийг дахин нэг удаа эсэргүүцэл бичих гэдэгт урьд эсэргүүцэл бичсэн Дээд шүүхийн шүүгч өөрөө болон өөр аль нэг шүүгч нь оролцогсдын гомдол болон өөрийн үзэмжээр түүнчлэн Улсын Ерөнхий прокурор урьд бичсэн үндэслэлээрээ, эсхүл өөр шинэ үндэслэлээр ЭБШ Хуулийн 364-р зүйлд дурдсан хугацааны дотор эсэргүүцэл бичихийг хамааруулж ойлгоно. Ийнхүү хэргийг зөвлөлдөх хуралдаанаар 2 удаа хэлэлцэхдээ нэгэнт тал бүрээс нь бүрэн гүйцэд хянан шийдвэрлэх учир Дээд шүүхийн бусад шүүгчдээс уг хэрэгт эсэргүүцэл бичих, түүнийг нь хянан хэлэлцэх хууль зүйн үндэслэлгүй болно.

9. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн өөр бүрэлдэхүүнтэйгээр зөвлөлдөх хуралдаанаар хэлэлцэх гэдэгт хэргийг зөвлөлдөх хуралдаанд урьд танилцуулсан шүүгчээс гадна 2 өөр шүүгч оролцсон бүрэлдэхүүнээр хэлэлцэхийг ойлговол зохино.

10. Монгол улсын Шүүхийн тухай хуулийн 24-р зүйлийн 3 дахь хэсгийн 10-д заасны дагуу цаазаар авах ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолтой хэрэг Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд шууд хэлэлцэгдэх учир ийм хэргийн талаарх таслан шийдвэрлэх тогтоолд эсэргүүцэл бичих, түүнийг зөвлөлдөх хуралдаанаар урьдчилан хэлэлцүүлэх шаардлагагүй. Харин энэ тохиолдолд хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн шүүгчид хяналтын шатны шүүх хуралдаанд оролцохгүй.

11. ЭБШ хуулийн 368-р зүйлийн 4 дэх хэсгийн хуралдаанд оролцож байгаа шүүгчийн олонхи гэдгийг уг хэргийг хэлэлцэхэд оролцсон шүүгчдийн 50 хувиас дээшхийг хуралдаанд оролцсон шүүгчдийн дийлэнх олонхи гэдгийг мөн хэргийг хэлэлцэхэд оролцсон шүүгчдийн 66,7 хувиас дээшхийг Дээд шүүхийн шүүгчдийн гуравны нэгээс доошгүй гэдгийг Дээд шүүхийн ерөнхий шүүгч, нийт шүүгчдийн 33,3 хувиас доошгүйг тус тус ойлгоно.

12. ЭБШ хуулийн 369-р зүйлийн 3 дахь хэсгийн хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөх эрхтэй гэсэн заалтыг анхан шатны шүүхээс шүүгчид оногдуулсан хорих ялыг давж заалдах шатны шүүх үндэслэлгүйгээр хөнгөрүүлсэн буюу тэнссэн нь буруу гэж хяналтын шатны шүүх үзвэл давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хорих ялыг таслан шийдвэрлэх тогтоолд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр биечлэн эдлүүлэхээр шийдвэр гаргах эрхтэй гэж ойл-

говол зохино. Энэ тохиолдолд давж заалдсан гомдол, эсэргүүцлийг хэрхэн үзсэнийг хяналтын шатны шүүх тогтоолдоо зааж байх хэрэгтэй.

13. Мөн 369-р зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хяналтын шатны шүүх хэргийг шинэчлэн мөрдөн байцаалгахаар буцаахдаа ЭБШ хуулийн 231-р зүйлд дурдсан гурван үндэслэлээр буцаах бөгөөд тэгэхдээ уг зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэсэн байх ёстой.

14. Хяналтын шатны шүүх шийдвэр гаргахдаа мөн 369-р зүйлийн хэд хэдэн хэсгийг давхар баримтлах тохгоолдол гарч болно. Тухайлбал: эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж байгаа бол энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийг давхар баримтална. Түүнчлэн хяналтын шатны шүүх өөрийн урьд гарсан тогтоол болон анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалтай холбоотой асуудлыг шийдвэрлэж байгаа бол ЭБШ хуулийн 368, 369-р зүйлийн тохирох хэсгийг давхар баримтална.

15. ЭБШ хуулийн 370-р зүйлийн анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлгүйгээр хүчингүй болгосон буюу өөрчилсөн гэдэгт давж заалдах шатны шүүхийн хийсэн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалд нийцээгүй (ЭБШ хуулийн 335-р зүйл), давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн (337-р зүйл), давж заалдах шатны шүүхээс ил шийтгэлийг өөрчилсөн нь гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй (338-р зүйл) зэргийг хамааруулж ойлгоно.

16. Мөн зүйлийн анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэлгүйгээр хэвээр үлдээсэн гэдэгт давж заалдах шатны шүүх нь ЭБШ хуулийн 333-р зүйлд дурдаж, 334, 335, 336, 337, 338-р зүйлээр тодруулан заасан зөрчил бүхий таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгох буюу өөрчлөхгүйгээр үлдээсэн тохиолдлыг хамааруулна.

17. Мөн зүйлийн «давж заалдах шатны шүүх хэрэг хянахдаа хууль зөрчсөн» гэдэгт хэрэг хянасан давж заалдах шатны шүүх өөрөө ЭБШ хуулийн 336-р зүйлийн 2 дахь хэсгийн 1—7-д дурдсан зөрчлийг гаргасан буюу 327-р зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан давж заалдах шатны хуралдаанд прокурор оролцож байгаа тохиолдолд шүүгдэгч эсхүл түүний өмгөөлөгчийг заавал оролцуулах заалтыг биелүүлээгүй зэргийг хамааруулан ойлгоно.

18. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 371-р зүйлд заасанчлан хяналтын шатны шүүх хэргийн бүх ажиллагааг бүүрэн хянан үзэх учир уг хэргийн талаар Дээд шүүхийн тогтоол гарсны дараа байцаан шийтгэх ажиллагааны өөр оролцогч гомдол гаргавал түүнийг хянан хэлэлцэхгүй бөгөөд хяналтын шатны шүүхийн тогтоолыг тайлбарласан хариу өгч байвал зохино.

19. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 368 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасанчлан Дээд шүүхийн шүүгчдийн гуравны нэгээс доошгүй нь эсэргүүцлийг дахин авч хэлэлцэх тухай саналаа тухайн хэргийг хянан хэлэлцэж буй Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан дээр санал хураан шийдвэрлэж байх Хэрэв шүүх хуралдаан дээр Дээд шүүхийн шүүгчдийн гуравны нэгээс доошгүйн санал аваагүй бөгөөд зарим шүүгч уул хуралдаанд оролцоогүй бол тэдэнд тусгайлан танилцуулж санал авах журмаар ЭБШ хуулийн 364-р зүйлд дурдсан хугацааны дотор шийдвэрлэж байна. Энэ тохиолдолд хэргийг Дээд шүүхийн дараагийн хуралдаанаар хянан шийдвэрлэх бөгөөд шүүгчийг татгалзах үндэслэл байхгүй бөгөөд Дээд шүүхийн Ерөнхий шүүгч өөр шүүгчийг томилоогүй бол хэргийг урьдах хяналтын шатны шүүх хуралдаанд илтгэсэн шүүгч илтгэнэ.

20. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогсдоос хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хянасан Дээд шүүхийн шүүгч давж заалдах шатны шүүхийн магадлалд эсэргүүцэл бичих шаардлагагүй гэж үзвэл энэ тухайгаа гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ. Уг хэргийн талаар дахин гомдол гарвал урьд хэргийг хянасан Дээд шүүхийн шүүгч Монгол улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчид танилцуулна. Ингээд эсэргүүцэл бичих шаардлагагүй гэж үзвэл гомдол гаргагчид ерөнхий шүүгч зохих хариуг өгөх бөгөөд уг хэргийг түүнтэй зөвшилцөлгүйгээр дахин хянах шаардлагагүй гэж үзнэ.

21. Мөн хуулийн 371-р зүйлийн 2 дахь хэсгийн ялыг хүндэрүүлж буюу хүнд яатай хуулийг хэрэглэх эрхгүй, мөн зүйлийн 4 дэх хэсгийн шүүгчдэгийн байдлыг дордуулахгүйгээр өөрчлөлт оруулах гэдгийг хяналтын шатны шүүх нь давж заалдах шатны шүүхийн магадлал, анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд өөрчлөлт оруулахдаа хэргийн зүйлчлэл, ялын төрөл, хэмжээ, эдлүүлэх дэглэм, өршөөл үзүүлсэн, онц аюултай хэрэгтнээр тооцогүй үздээсэн, таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, хорих

ялаас хугацаанаас өмнө тэнсэн сулдасай буюу өөр хөнгөн ялаар сольсон, нэмэгдэл ялаас чөлөөдсөн, ял эдлүүлэх дэглэмийг хөнгөрүүлсэн сольсон, хянан харгалзах хугацаат тогтоосон, ялыг нэмж нэгтгэх буюу багтаах зэрэг асуудлыг анхан шатны шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор шийдвэрлэснээс дордуулсан өөрчлөлт оруулж болохгүй гэж ойлгоход зохино. Харин ялыг хундруулэх буюу хүнд ялтай хуулийг хэрэглэх тухай эсэргүүцэл бичигдсэн буюу гомдол гаргасан бөгөөд уг эсэргүүцэл, гомдол хууль зүйн үндэслэлтэй бол хяналтын шатны шүүх дээрх асуудлыг давж заалдах шатны шүүх шийдвэрлэснээс дордуулсан өөрчлөлт хийж болох боловч анхан шатны шүүхийн шийдвэрлэснээс дордуулахаар байвал таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгож дахин хянан хэлэлцүүлэх буюу мөрдөн байцаалтад буцааж байвал зохино.

Хоёр, Эрүүгийн хэргийг анхан шат, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхдээ ЭБШ хуулийн 57-р зүйлд заасан эрүүгийн хэрэг хэлэлцэхэд шүүгч оролцож болохгүй үндэслэл, түүнчлэн 58-р зүйлд заасан хэрэг хэлэлцэхэд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэлийг тус тус сайтар анхаарч мөрдөхийг нийт шүүх, шүүгч нэрт анхааруулсугай. Ялангуяа өөрийнх нь оролцоотойгоор гарсан таслан шийдвэрлэх тогтоол, магадлаал, тогтоолыг хүчингүй болгосон байхад уг хэргийг тухайн шатаар дахин хэлэлцэхэд оролцох, нэг хэргийг хэлэлцэх давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдааны бүрэлдэхүүнд аль алинд нь оролцох зэрэг зөрчил гарч байгааг зогсоовол зохино.

Гурав, Дээд шүүхийн хувьд хуулийн энэ заалтыг мөрдөхөд олон дахин хэлэлцэгдсэн зарим хэргийн хувьд шүүх бүрэлдэхүүнгүй болох хүндрэл учрах талтайг анхаарч хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай санал боловсруулан хууль санаачлагчид оруулах уг асуудлыг шийдвэрлэгдэх хүртэл Дээд шүүх бүрэлдэхүүнийг зохицуулж ажиллахыг Дээд шүүхийн ерөнхий шүүгчид хариуцуулсугай.

Дөрөв, ЭБШ хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийг хэрэглэхдээ энэхүү тогтоол болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх журмын тухай Дээд шүүхийн 1994 оны 7-р сарын 14-ний өдрийн 54-р тогтоолыг тус тус мөрдөн ажиллахыг нийт шүүх, шүүгчдэд даалгасугай.

Тав, Энэ тогтоол гарсантай холбогдуулан эрүүгийн хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэж байгаа шүүхийн практикийн тухай БИМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1984 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 36-р тогтоолыг хүчингүй болгоод тооцсугай.

Ерөнхий шүүгч

Шүүгч

Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Ч. ГАНБАТ



---

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч Н. Ринчиндорж  
Нарийн бичгийн дарга Сам. Жаргалсайхан  
Гийшүүд Т. Баасансүрэн  
Ч. Балуу

Техник редактор Т. Сарантуяа  
Уншиж хянасан Сам. Жаргалсайхан  
Б. Янжинпалам

Үйлдвэрт шилжүүлсэн 1994 оны 11-р сарын 4-нд,  
Өрбөлд 1994 оны 11-р сарын 5-нд, Хявалатд  
1994 оны 12-р сарын 11-нд, Цагсгм хэмжээ  
60X90/16, Хяваланын хуудас 7.0 Хявалсан тоо  
3550 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр